



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он... дугаар  
сарын...-ны өдөр

Дугаар.../880

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийн тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан тэмдэглэлийн хамт Улсын Их Хуралд хүргүүлж байна.

Хавсралт: 67 хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын хэрэг  
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021505437





**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН  
ЧИГЛЭЛ”-Д ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН**

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг Монгол Улсын Засгийн газар 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн салбарын бодлого, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилт, 127 бодлогын арга хэмжээг тусгав.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй болон аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангах, татварын орчныг хялбар, энгийн, шударга болгож, бизнес эрхлэлтийг дэмжих, үнэ, ханшийн тогтвортой байдлыг хангаж, мөнгөний бодлого хэрэгжүүлэх, төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлыг хангах, Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшнийг бууруулах зэрэг зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого, Засаглал, эрх зүйн шинэтгэл, гадаад бодлого, батлан хамгаалахын салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилт 118 арга хэмжээг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улмаар Байнгын хорооны хуралдаан болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар гишүүдээс гаргасан саналаар 9 арга хэмжээ шинээр нэмэгдэж, 127 бодлогын арга хэмжээтэйгээр Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор батлагдсан.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан нийт 5 бүлэг, 20 зорилт, 127 бодлогын арга хэмжээг 11 их наяд 022.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 461.3 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 2 их наяд 111.9 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 6 их наяд 174.2 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 1 их наяд 274.7 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан болно.



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД, ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлд:

"Х.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид даалгав;

2. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж байхыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР




**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-Д ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл” батлагдсан бөгөөд Үндсэн чиглэлийн биелэлтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн, үнэлгээ хийж танилцуулж байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан нийт 127 арга хэмжээнээс 77 нь “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-тай, 113 нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй, 28 нь Төрөөс баримтлах бодлоготой, 5 нь бусад бодлогын баримт бичгүүдтэй тус тус уялдсан байна.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллалаа.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-д тусгагдсан 5 бодлого, 20 зорилт, 127 арга хэмжээний биелэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар **75.9 хувьтай** гарлаа.



Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан нийт 127 арга хэмжээнээс:

- 64 арга хэмжээ 100 хувиар,
- 5 арга хэмжээ 90 хувиар,
- 26 арга хэмжээ 70 хувиар,
- 11 арга хэмжээ 50 хувиар,
- 14 арга хэмжээ 30 хувиар,
- 7 арга хэмжээ 0 хувиар тус тус үнэлэгдлээ.

#### **БИЕЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД :**

Биелэлт хангалтгүй буюу 0 хувиар үнэлэгдсэн дараахь 7 арга хэмжээ байна. Үүнд:

- 1.1. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй болон аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хангах;
- 2.2. Төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлыг хангах;
- 7.3. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх;
- 8.9. Дотоодод үйлдвэрлэсэн цементийг экспортлох бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх;
- 9.5. Аялал жуулчлалын дэд бүтэц, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- 12.3. Үндэсний соёл урлагийг дэмжих хүрээнд Үндэсний урлагийн Их театр шинээр байгуулах;
- 19.1. Хөрш орнуудтай хийх гадаад худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх.

#### **БИЕЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД :**

Биелэлтийг эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувиар үнэлэгдсэн дараахь 14 арга хэмжээ байна. Үүнд:

- 4.5. Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах;
- 5.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжих хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;
- 6.1. Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- 6.2. Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих;
- 6.3. Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх;
- 6.4. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх;

6.5. Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг эхлүүлэх;

6.6. Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

7.2. Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын 4С зэрэглэлд хүргэх;

7.4. Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх;

8.7. Дотоодын гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, темерлегийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

12.2. Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан Байгалийн түүхийн музейг шинээр барих;

13.3. Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний гено банканд шаардлагатай барилгыг барих;

14.4. Хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх;

### ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ:

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг холбогдох яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд үндэслэн гаргахад дараахь арга хэмжээг анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Тухайн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байгаа яамд болон байгууллагуудын хоорондын ажлын уялдааг хангаж ажиллах;
- Зорилт, арга хэмжээний биелэлтийн хувийг холбогдох журмын дагуу бодитой, хүрэх түвшинтэй харьцуулан үнэлэх;
- Үндсэн чиглэлийн биелэлтийг тайлагнахдаа зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлттэй уялдуулан зөвхөн тухайн жилийн ажлын үр дүнг тайлагнах.

### ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-Д ТУСГАГДСАН ЗОРИЛТ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ, БОДЛОГЫН ТӨРЛӨӨР**

*Хүснэгт.1 Үндсэн чиглэлийн биелэлт бодлогын төрлөөр, арга хэмжээний хэрэгжилтийн хувь/*

Д/д	Бодлого	Арга хэмжээний тоо	100	90	70	50	30	0	Нийт хэрэгжилтийн хувь хэмжээ
	Бүгд	127	64	8	26	11	14	7	75.9
1	Макро эдийн засгийн бодлого	10	2		4	2		2	58.2
2	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	28	8	2	8	2	18	1	68.6
3	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	22	12	1	3	3	1	2	76.4
4	Хувий хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	38	28	2	6	8	8	1	82.6
5	Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	29	22		5	1		1	89.6

*Жич: Биелэлтийн дундаж үнэлгээг жигнэсэн дунджийн аргаар тооцож гаргаав.*

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

№	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ  /тэрбум төгрөг/	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>							
<b>Зорилт 1. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлнэ.</b>							
1.1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /цаашид "МУТХҮБ-2030" гэх/-ын 2.1.7, Зорилт 1,  Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид "ЗГҮАХ" гэх/-ийн 1.4 дэх заалт	Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй болон аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хангах	Дотоодын нийт бүтээгдэхүүний /цаашид "ДНБ" гэх/ бодит өсөлт, хувиар	6.0		"Ковид-19" цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг агшиж, 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувийн бууралттай гараад байна. Үүнд, "Ковид-19"-ийн тархалттай холбоотойгоор улс орнуудын хилийн боомтуудад хязгаарлалт хийгдсэн, гадаад эрэлт буурсантай холбоотойгоор экспортын орлого буурсан, иргэдийн хөл хөдөлгөөнд хязгаарлалт хийсэн зэрэг нь эдийн засгийн салбаруудад сөрөг нөлөө үзүүлээд байна. Иймд Монгол Улсын Засгийн газраас "Ковид-19" цар тахлын тархалттай холбоотой зах зээлийн нийт эрэлтийн агшилтыг хязгаарлах үүднээс эдийн засгийг дэмжих багц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Түүнчлэн цар тахлын нөлөөгөөр төсвийн орлого буурч, төсвийн санхүүжилтийг хэвийн олгоход хүндрэлтэй байдал үүссэний улмаас Монгол Улсын 2020 оны төсөвт тодотгол хийсэн хэдий ч газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй болон аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг дэмжих улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг харьцангуй бага хувиар бууруулж, эдийн засгийг дэмжээд байна. Түүнчлэн эдийн засагт учирч буй эрсдэлийг бууруулах, төсөвт дэмжлэг үзүүлэх зорилгоор хөгжлийн түнш орнуудаас авах гадаад зээл, тусламжийг нэмэгдүүлээд байна.	0
1.2	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 1.4 дэх заалт	Татварын орчныг хялбар, энгийн, шударга болгож, бизнес эрхлэлтийг дэмжих					

1.3	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх	Ажилгүйдлийн түвшин, хувиар	6.5-аас ихгүй		Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 159 дүгээр тогтоолоор "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр" болон Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Хөтөлбөрийн зорилго нь зарим бодлогын баримт бичигт тусгагдсан ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтыг хангах хүрээнд салбар дундын уялдаатай бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, нийгмийн халамжийн бодлогыг нийгмийн зорилтот бүлэгт чиглүүлж, ядуурлын түвшин өндөр бүс нутгийн иргэдэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох замаар иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг ажилтай, орлоготой болгох, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг зөв, хүртээмжтэй ашиглан ажилгүйдэл, ядуурлыг цогцоор нь бууруулах асуудал юм.  2020 оны IY улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин 7.6 хувьтай байна.	50
<b>Зорилт 2. Макро эдийн засгийн тогтвортой орчныг хангахад чиглэсэн төсөв, м өнгөний бодлого хэрэгжүүлнэ.</b>							
2.1	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 1, 3	Үнэ, ханшийн тогтвортой байдлыг хангах мөнгөний бодлого хэрэгжүүлэх	Инфляцийн түвшин, оны эцэст хувиар	8.0-аас ихгүй		Хэрэглээний үнийн индексээр хэмжсэн инфляц 2020 оны туршид нам түвшинд байж, оны эцэст улсын хэмжээнд 2.3 хувь, Улаанбаатар хотод 1.99 хувь байв. Үүнд цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил суларч, эрэлтийн шалтгаантай инфляц саарснаас гадна Засгийн газар сайжруулсан түлшний үнийг 75 хувиар бууруулсан нь голлон нөлөөллөө. Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлс болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан Мөнгөний бодлогын хороо (МБХ)-оос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжилтийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын хүүг 2020 онд нийтдээ 5 нэгж хувиар бууруулж, 6 хувь букуу түүхэн доод түвшинд хүргээд байна.	100
2.2	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 1, 3	Төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлыг хангах	Нэгдсэн төсвийн алдагдлын дээд хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар	5.1-ээс ихгүй		УИХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны Монгол улсын 2021 оны нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн батлав. Монгол улсын 2021-2023 онд нэгдсэн төсвийн орлогын хувийг нь 27.9, 25.0, 24 харин нэгдсэн төсвийн зарлагын хувийг 33.0, 28.6, 26.8 нэгдсэн төсвийн алдагдлын хувийг -5.1, -3.6, -2.8 тус тус байна. УИХ-ын чуулганаар мөн өдөр батлагдсан 2020 оны төсвийн тодотголд алдагдлын хувь -5.1 байхаар	0



					туссан. Гэсэн хэдий ч коронавируст халдвар цар тахлын тархалтыг дотооддоо алдан хөл хорио тогтоосноор төсвийн орлого буурч, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 12.3 хувьд хүрээд байна.	
			Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийн дээд хэмжээ, ДНБ-д эзлэх хувиар	55.5-аас ихгүй	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 61 хувь байна. Засгийн газар 2020 онд арилжааны нөхцөлтэй гадаад болон дотоод зээл шинээр аваагүй бөгөөд баталгаа, концесс зэрэг өрийн хэрэгслээр өр үүсгэхгүй байх бодлогыг баримтлан ажилласан. Дэлхийн дахинд тархаад буй коронавируст цар тахлын нөлөөгөөр нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий 5.1 хувиас төсвийн тодотголоор 12.3 хүртэл нэмэгдэж, шинээр авах гадаад төсөл болон хөтөлбөрийн гадаад зээлийн ашиглалт өссөн нь Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.	
2.3	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 1	Уул уурхайн салбараас хуримтлуулах хөрөнгийг үр ашигтай удирдах тогтолцоог бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндэсний баялгийг хүн ам, нийгмийн бүлэг болон өнөө ба хойч үеийнхэнд шударга, тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн орлогын тодорхой хэсгийг хуримтлуулах зорилготой Ирээдүйн өв санд 2019 оны 7 дугаар сараас бодит хуримтлал үүсэж эхэлсэн. Хуульд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой корпорацын зардлын хязгаарыг тогтоож, санхүүжүүлэхдээ санд хуримтлал бий болж эхлэх үеийн хэмжээний хөрөнгийг удирдахад тохирсон бүтцийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэлийг хангахад нийцсэн зохистой түвшинд байлгах зарчмыг баримтлахаар заасан. Үүний дагуу Ирээдүйн өв санд хуримтлагдсан хөрөнгийг үр ашигтай удирдах, зардлыг оновчтой түвшинд байлгах, хөрөнгийн удирдлагын чадавхыг бүрдүүлэх санал, хувилбаруудыг боловсруулан ажиллалаа. Нэн тэргүүнд Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах ерөнхий зарчим, нөхцөл, шаардлагыг тодорхойлсон бодлогын баримт бичиг буюу хөрөнгийн удирдлагын мандатыг боловсруулж, батлуулсан болно.	70

2.4	МУТХҮБ-2030-ын 2.1, ЗГҮАХ-ийн 1.2 дахь заалт	Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлж, валютын зохицуулалт, векселийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	80.0	<p>Монголбанкны валютын захын оролцоог зохицуулсан журам, заавруудын давхардлыг арилгах, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор "Монголбанкны гадаад валютын спот арилжааны журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, батлуулав.</p> <p>Монгол Улсын дотоодын болон олон улсын зах зээлд гарч буй өөрчлөлтүүдтэй холбогдуулан Монголбанкны урт хугацаат своп хэлцлийн нөхцөлийг 2020 оны Монголбанкны Ерөнхийлөгчийн А-22 болон А-196 дугаар тушаалаар тус тус шинэчлэн батлав.</p> <p>Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, эдийн засгийн харьяат хоорондын болон тэдгээрээс харьяат бустай хийх валютын бүх төрлийн гүйлгээний эрх зүйн зохицуулалт, валютын дотоодын захын дэд бүтэц, мэдээллийн урсгалыг тодорхойлох, ханшийн механизм ажиллах, зах зээлийн мэргэжлийн оролцогчдын шударга өрсөлдөөнийг хангах нөхцөлийг бүрдүүлэх замаар валютын зах үр ашигтай ажиллах эрх зүйн орчныг бий болгох, эрх бүхий төрийн байгууллагуудын дээрх харилцаанд оролцох эрх зүйн байдал, төрөөс явуулах хяналт, шалгалт, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн.</p> <p>Монгол Улсын эрдэнэсийн эх нөөцийг хамгаалах, төрийн эрдэнэсийн санг бүрдүүлэх, хамгаалах, арвижуулах, тус сангаас хөрөнгө гүйлгээнд оруулах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд "Эрдэнэс"-ийн тодорхойлолтыг өргөжүүлэх, эрдэнэсийн гүйлгээ сангийн зориулалтыг зөвхөн үйлдвэрлэл, судалгаа, дурсгалын чиглэлээр зарцуулах, Эрдэнэсийн санд олборлосон алт авах, гадаад валютын улсын нөөц нэмэгдүүлэх үйл ажиллагааг тусгаарлах, Эрдэнэсийн сангийн бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэл, стандартын дагуу Монголбанк өөрийн тайлан тэнцэлд бүртгэх зэрэг агуулгаар боловсруулав. Хуулийн төслийг хууль санаачлагчид уламжилсны дагуу 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэхийг</p>	70
-----	--	--	-----------------------------------	------	---	----

					<p>дэмжиж, хэлэлцүүлэгт бэлтгэв.</p> <p>Векселийн эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хуулийн төсөлтэй нийцүүлэн агуулгыг сайжруулан хууль санаачлагчид уламжлахаар ажиллаж байна.</p> <p>Банкны салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-ын 2020 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан. Хуулийн төсөл 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хурлаар батлагдсан ба 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Уг шинэтгэл нь банкны зохистой засаглалыг бэхжүүлэх, хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банкныг нээлттэй болон хаалттай хувьцаат компани хэлбэртэй болгон өөрчлөх, хөрөнгийн зах зээлийг дэмжих зэрэг үр дагавартай байна. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай тус тус хуулийг Улсын Их Хурлаар батлуулав.</p>	
2.5	МУТХҮБ-2030-ын 2.1, ЗГҮАХ-ийн 1.2 дахь заалт	Санхүүгийн салбар дахь зээлийн хүү, чанаргүй активыг бууруулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	50.0	<p>Банкууд Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөг боловсруулан ирүүлсэн бөгөөд улирал бүр явцын тайлан мэдээг ирүүлж байна. Журмын дагуу Монголбанкнаас хэрэгжилтийг үнэлж байна.</p> <p>Түүнчлэн санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар ББСБ, ХЗХ-оос олгосон зээлийн ангиллын хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж дэмжсэн тул СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 тоот хамтарсан тушаалаар "Хадгаламж зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам", "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам"-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.</p>	70

хамгаалах эрх  
зүйн орчныг  
бүрдүүлэх

Урт хугацааны даатгалыг хөгжүүлэх замаар зээлийн хүүг бууруулах зорилго бүхий Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 354 дүгээр тушаалаар "Ипотекийн даатгалын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх гарц шийдлийг тодорхойлох, санал дүгнэлт боловсруулах" чиг үүргийг хэрэгжүүлэх СЗХ, Монголбанк, Монголын даатгалын холбоо, Монголын банкны холбоо, "Нэйшнл лайф даатгал" ХХК, "Үндэсний давхар даатгал" ХК болон "МИК ОССК" ХХК-ийн төлөөллүүд оролцсон ажлын хэсгийг байгуулж, холбогдох эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах санал боловсруулахаар, ажиллаж байна.

Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийн хамтарсан тушаалаар баталсан "Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу банкны мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох, цахим хэлбэрт шилжүүлэх, банкны эх үүсвэр, үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилгоор Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Мөн банк, санхүүгийн салбарын чанаргүй активыг шийдвэрлэж, зээлийн хоёрдогч захыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгаа, үнэлгээ, олон улсын сайн туршлага, судалгаанд үндэслэн чанаргүй зээл, активыг шийдвэрлэх, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанкнаас боловсруулсан Актив удирдлагын компанийн тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт бэлтгэж байна.

Зээлийн хүүг бууруулах арга хэмжээний дараагийн чиглэл болох банкны засаглал, институцийг сайжруулах, санхүүгийн байгууллагуудад зохистой засаглалын зарчмууд, шилдэг туршлагауудыг мөрдүүлэх чиглэлээр банкны удирдлагын эрсдэлээс зээлийн хүүд нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, уг эрсдэлийг банкны хэлбэр, хувьцаа эзэмшлийн хязгаарлалт, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэрт байдлыг бүрдүүлэх үүднээс Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2020 оны 8 дугаар сард Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэн,





					65000 иргэдийн ипотекийн зээлийн эргэн төлөлт, иргэдийн орлогод сөргөөр нөлөөлж байгаатай холбоотойгоор ипотекийн зээлээр баталгаажсан бондын эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулах, иргэдийн орлогыг дэмжихээр Санхүүгийн зохицуулах хорооноос судалгааг хийж, "МИК ОССК" ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасны купон төлбөрийг түр хугацаанд царцаах, иргэдийг санхүүгийн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор ипотекийн зээлийн эргэн төлөлтийг 6 сараар, хүү хуримтлуулахгүйгээр хойшлуулав.	
2.6	МУТХҮБ-2030-ын 2.1.6, Зорилт 2	Санхүүгийн салбарын өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зохицуулалтыг боловсронгуй болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх	Боловсронгуй болгох хуулийн тоо	5	Хадгаламж, зээлийн хоршооны зах зээлийн өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зохицуулалтыг боловсронгуй болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилго бүхий Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг боловсруулсан.  Мөн даатгалын салбарын хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, COVID-19 цар тахлын улмаас үүсээд буй хүндрэлийг даван туулах чиглэлээр Хорооноос санал, санаачилга гаргаж дараах даатгалын бүтээгдэхүүнийг шуурхай хянаж, бүртгэж ажилласан. -"Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн "Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал, "Ковид-19" эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүн, "Мандал даатгал" ХК-ийн "Ковид хүртээмжтэй даатгал"-ын бүтээгдэхүүн, "Ард даатгал" ХК-ийн "Ковид-19", ажилтны нөхөн олговрын даатгал" зэрэг болно.	70
2.7	МУТХҮБ-2030-ын 2.7 дахь заалт	Банкнаас бусад санхүүгийн салбарт олгох тусгай зөвшөөрлийн тоог бууруулж, хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах	Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тусгай зөвшөөрлийн буурах хувь	20.0	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр олгодог зохицуулалтыг хугацаагүй болгохоор тусгасан. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төсөлд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог бууруулж, тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох, нэгдсэн хяналт шалгалтын зохицуулалтыг тусгасан. СЗХ-ны 2020 оны 959 дүгээр тогтоолоор баталсан "Даатгалын багц дүрэм"-ийн нэгдүгээр хавсралтын шинэчилсэн найруулгын "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-д зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах зохицуулалтыг тусгаж, бүртгэл зөвшөөрлийг түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.	50

2.8	"Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.2.4 дэх заалт	Үнэт цаасны төлбөр тооцооны программ хангамжийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх	Дараа төлбөрт горимд шилжих ажлын явц, хувиар	100.0		<p>Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор "Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх тухай" тогтоолыг баталж, шилжилтийг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор хэрэгжүүлэхээр тогтсон. Энэ хүрээнд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 35/47 тоот хамтарсан тушаалаар батлагдсан нарийвчилсан төлөвлөгөөнд туссан ажлуудыг хийж гүйцэтгэж, үнэт цаасны зах зээлд төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх бэлтгэл ажлуудыг хангаж, дээрх зарчмыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хөрөнгийн зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.</p> <p>Мөн "Арилжааны төлбөр тооцоо ҮЦК" ХХК-ийн "Үнэт цаасны клирингийн журам"-ыг Хорооны даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 45 тоот тушаалаар баталсан бөгөөд хорооны 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 103 тоот тогтоолоор "ҮЦТХТ" ХХК-д Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосон. "Үнэт цаасны хадгаламжийн журам"-ын нэмэлт өөрчлөлт, "Үнэт цаасны төлбөр тооцоог Т+2 горимоор гүйцэтгэх журам", "Төлбөрийн үйлчилгээний журам"-ыг тус тус СЗХ-ны даргын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 110 тоот тушаалаар баталсан. Түүнчлэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Арилжааны журмын нэмэлт өөрчлөлтийг СЗХ-ны даргын 123 дугаар тушаалаар баталсан.</p>	100
-----	--	--	---	-------	--	---	-----

**ХОЁР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО**

**Зорилт 3. Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимтэй хөгжүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулна.**

3.1	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /цаашид "ТХХААТББ" гэх/-ын 2.1.3,	Малын үржил, селекцийн хүртээмж, үр дүнг дээшлүүлж, цөм сүргийн үзлэг ангилалтыг зохион байгуулан малын бүртгэл, мэдээллийн	Үзлэг, ангилалд хамрагдах малын тоо, сая толгой	1.5	0.5  Улсын төсөв	<p>Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх ажилд шаардагдах 430.0 сая төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-112 дугаар тушаалаар баталж, аймгуудад хамаарах төсвийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, аймгийн Худалдан авах ажиллагааны газарт тус тус шилжүүлэн, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэл, нэгдсэн арга зүйгээр хангаж, ажлын удирдамж хүргүүлсэн.</p> <p>1. Улсын төсвийн хөрөнгөөр 21 аймгийн 99 сумын баталгаажсан үүлдэр, омгийн үржлийн болон цөм сүргийн 94.9 мянган бод,</p>	70
-----	--	---	---	-----	------------------------	--	----



2.1.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.25, 2.33 дахь заалт	санг өргөтгөх				<p>131.5 мянган бог, нийт 226.5 мянган толгой малыг хувьслын үзлэг ангилалтад хамруулахаас 94.5 мянган бод, 200.0 мянган бог, нийт 294.6 мянган толгой малыг хамруулж, гүйцэтгэл 30.0 хувийн өсөлттэй гарлаа. Үзлэг ангилалтад хамрагдсан бод малын 31.5 хувь буюу 29.8 мянга нь цөм сүргийн, 52.2 хувь буюу 49.6 мянга нь үржлийн, 15.9 хувь буюу 15.0 мянга нь хэрэгцээний сүргийн, бог малын 34.7 хувь буюу 69.3 мянга нь цөм сүргийн, 48.1 хувь буюу 96.2 мянга нь үржлийн, 17.2 хувь буюу 34.4 мянга нь хэрэгцээний сүргийн шаардлага тус тус хангаж, нийт сүрэгт үржлийн мал дийлэнх хувийг эзэлж байна.</p> <p>2. Орон нутгийн төсөв, сум хөгжүүлэх сангийн 101.8 сая төгрөгийн хөрөнгөөр 6 аймгийн хэмжээнд 3.1 сая хонь, 701.8 мянган ямаа, 30.4 мянган үхэр, 20.5 мянган тэмээ, нийт 3.8 сая толгой малд сонголт, ангилалт хийсэн. Үүнээс нутгийн шилмэл омгийн малд хувьслын ангилалт хийж, үржил селекцийн ажлын ололтыг хянан магадалж, баталгаажуулах ажлыг зохион байгуулав. Үүнд: Баянхонгор, Булган, Өмнөговь, Дундговь аймгийн 269.3 мянган хонь, Өмнөговь, Хэнтий аймгийн 56.1 мянган ямаа, Төв аймгийн 23.0 мянган үхэр, Дундговь аймгийн 7.0 мянган тэмээ, нийт 355.4 мянган толгой мал бүхий цөм сүрэг бүрдүүлэв.</p>
		Малын үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгжийн тооны өсөлт, хувиар	30.0		<p>Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг шинээр байгуулах, үүсгэл санаачилгыг дэмжих чиглэлийг бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлснээр 2020 онд шинээр 35 нэгж байгуулагдаж, нийт 151 нэгж үйл ажиллагаа явуулж байна. Улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр малын үзлэг ангилалтын ажлыг 59 нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэв. Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил Нэмэлт санхүүжилт төсөл хэрэгжиж буй Архангай, Өвөрхангай, Дундговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн 13 суманд 108.5 сая төгрөг, орон нутгийн оролцооны 216.0 сая төгрөгийн зоо багаж, тоног төхөөрөмжийг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжид дэмжлэг болгон олгов.</p>
		Малын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх хээлтүүлэгч болон цөм	1.5	0.1 Гадаад эх үүсвэр, 0.2 Улсын төсөв	<p>Дэлхийн худалдааны байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд төсөл хэрэгжиж буй Өвөрхангай аймгийн Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумын нийт 173.2 мянган толгой малыг</p>



			сүргийн малын тоо, сая толгой		0.1  Улсын төсөв	<p>бүртгэлжүүлээ. Монгол адууны үүлдэрлэг байдалд молекул биологийн судалгаа хийх, стандартыг шинэчлэн тогтоох, хурдан морины цахим бүртгэлийн программ, мэдээллийн сан бий болгох ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, 1200 адуунд туршилтын чип суулгах, цус авах ажлыг гүйцэтгэв.</p> <p>Улсын хэмжээнд хавар, намрын хугацаанд 12.9 мянган малчин өрхийн 335.3 мянган толгой цөм сүргийн мал, Өвөрхангай аймгийн төслийн сумдын 173.2 мянган толгой малыг 2020 онд шинээр ялган тэмдэглэж, 1046.7 мянган толгой үржлийн, нийт 1555.2 мянган толгой малын мэдээллийг Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулж, жилийн эцсийн байдлаар тус санд 4.5 сая толгой малын мэдээлэл бүртгэлтэй байна. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шинээр бүртгэгдсэн 1.5 сая толгой малын 17.4 мянга буюу 1.1 хувь нь үржлийн хээлтүүлэгч, 508.5 мянга буюу 32.7 хувь нь цөм сүргийн мал байна.</p>	
3.2	МУТҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/	59	28.7  Улсын төсөв	<p>2020 онд мал, амьтны гоц халдварт 3 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 32.1 сая толгой мал, халдварт 19 нэрийн өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 39.2 сая толгой мал, амьтан, нийт 22 нэрийн өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 71.3 сая толгой мал, амьтан хамруулсан. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт бүртгэгдээгүй тайван байлаа. Гоц халдвартын тарилгын үйлчилгээний хөлсөнд давхардсан тоогоор 951 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж 4.9 тэрбум төгрөг олгосон.</p> <p>2020 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсын хэмжээнд мал, амьтны 21 нэрийн халдварт өвчин бүртгэгдэж, давхардсан тоогоор 776 суманд 1163 удаагийн гаралтаар 8950 мал, амьтан өвчилж, үүнээс 2548 мал, амьтан хорогдож, 394 мал, амьтныг зориудаар устгаж, 15 мал, амьтныг нядалсан бол 5993 толгой мал, амьтан эдгэрсэн байна. 2019 онтой харьцуулахад халдварт өвчний гаралтын тоо 58, өвчилсөн малын тоо 8687 толгой хорогдсон малын тоо 1654 толгойгоор тус тус буурсан байна. Халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын үйлчилгээний хөлсөнд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж Улсын төсвөөс 3.6 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс 2.1 тэрбум төгрөг олгосон.</p>	100

			Вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоо, мянга	200		<p>Шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг зэрэг мал, амьтны гоц халдварт өвчнөөс сэргийлэх тарилгын төлөвлөгөө, гүйцэтгэлийг мал эмнэлгийн цахим системээр дамжуулан улсын хэмжээнд хянаж, хяналт, шалгалт хийсний дараа тарилгын үйлчилгээний хөлсийг олгосон. Тус цахим системээр дамжуулан нийт 26.0 сая толгой малыг урьдчилан сэргийлэх тарилгад хамруулсан хяналтыг хийсэн.</p> <p>2020 онд Бруцеллёзын вакцинжуулалтын дараах мониторингийн лабораторийн шинжилгээнд нийт 9280 толгой мал хамруулснаас 7866 сорьц эерэг урвал үзүүлж, дархлаажуулалтын үр дүн 84.7 хувь, шүлхий өвчний вакцинжуулалтын дараах мониторингийн лабораторийн шинжилгээнд нийт 4,950 толгой мал хамруулснаас О хэвшилд 3833 сорьц, А хэвшилд 3967 сорьц эерэг урвал үзүүлж, дархлаажуулалтын үр дүн О-77.4, А-80.1 хувь, Бог малын мялзан өвчний вакцины дараах мониторингийн лабораторийн шинжилгээнд нийт 4992 толгой мал хамруулснаас 2988 сорьц эерэг урвал үзүүлж, дархлаажуулалтын үр дүн 60 хувьтай байв. Тус 3 өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан малын лабораторийн сорьцын тоо 19222, дархлаажуулалт дунджаар 75.5 хувьтай гарсан.</p> <p>2020 онд Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт, халдварт 22 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулсан нийт 71.3 сая толгой малын 36.1 хувийг вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулж, вакцинжуулалтын гүйцэтгэл сайн хийгдсэн гэж үзсэн байна.</p>	
3.3	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.38 дахь заалт	"Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн явц, хувиар	30.0	0.8 Улсын төсөв	<p>Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 130 дугаар тогтоолоор сүүний урамшуулал олгох журмыг баталсан. Сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ и-баримтад бүртгүүлэн баталгаажуулсан 2375 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/387 дугаар тушаалын дагуу 970 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгов. Мөн сайдын тушаалаар эрчимжсэн мал аж ахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгуудын ХХАА-н газар тус бүрд 10-25 сая төгрөг, нийт 319.6 сая төгрөгийн санхүүжилт хуваарилан хүргүүлсэн. 2020 онд төсөл сонгон шалгаруулалт зарлаж Сэлэнгэ, Дархан, Төв аймгийн 5 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, ферм барих газарт нь геодезийн шинжилгээ хийлгэсэн. Одоогоор фермийн барилга барих нэгжийн сонгон шалгаруулалт явагдаж байна. 2020 оны 11 сард "Нүүдэлчин" ХХК Франц Улсаас өөрийн хөрөнгөөр 96 монбильрд</p>	70

					үүлдрийн гунжийг импортлон кластер фермээ өргөтгөв. Дархан аймаг орон нутгийн төсөвт 500 сая төгрөг тусгаж, 150 толгой сүүний чиглэлийн симменталь үүлдрийн үхрийн ферм байгуулав.		
3.4	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 1, ТХХААТББ-2.1.10, ЗГҮАХ-ийн 2.36, 2.38 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, жамгаалалтын эрх зүй, хариуцлагын тогтолцоо, бэлчээрийн менежментийг сайжруулах	Бэлчээр ашиглалтыг хариуцуулах аймгийн тооны өсөлт, хувиар	50.0	0.1 Гадаад эх үүсвэр	21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, 330 сумын ХАА-н тасгийн мэргэжилтнүүдийг оролцуулан 570 гаруй хүнд "Бэлчээрийн ашиглалтыг сайжруулах нь" зөвлөгөөн Архангай, Дорнод, Дундговь, Ховд аймагт зохион байгуулж, бэлчээрийн харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бэлчээр ашиглалтыг сайжруулах, төлбөр авах боломжийн талаар мэдээлсэн. УИХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр "Малын тоо толгойн албан татварын тухай хууль"-ийг хэлэлцэн, баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна. "Ногоон алт малын эрүүл мэнд" төслийн 46.7 сая төгрөгийн санхүүжилтээр 8 аймагт орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн судалгаа хийснээр Архангай аймагт 178.0 мянган га, Дундговь аймагт 205.6 мянган га, Дорнод аймагт 299.9 мянган га, Өвөрхангай аймагт 496.5 мянган га, Өмнөговь аймагт 3030.0 мянган га, Сүхбаатар аймагт 629.8 мянган га, Хөвсгөл аймагт 245.6 мянган га, Ховд аймагт 102.3 мянган га нийт 5187.7 мянган га бэлчээрийг орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээр болгож, хил заагийг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах ажлыг аймгуудын Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хийж байна. "Ногоон алт малын эрүүл мэнд" төсөл хэрэгжиж буй 18 аймгийн 1520 бэлчээр ашиглагчдын хэсгийн малчидтай хамтран 2820 цэгт бэлчээрийн төлөв байдлын фото мониторингийн судалгааг хийв. Бэлчээр ашиглалт сургалтыг 5 аймгийн 8 суманд зохион байгуулж сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын 63 гэрээ байгуулсан. "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт" төсөл хэрэгжиж буй 6 аймгийн 18 суманд 50 малчдын бүлэг бэлчээрийн даацад малын тоог тохируулах, талхлагдсан бэлчээрийг зохистой ашиглан сайжруулж, нийт 120.0 мянган га бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулав.	100

			Бэлчээрийн менежментэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хувь	30.0	5.3 Улсын төсөв  3.7 Гадаад эх үүсвэр	2020 онд Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 193 сумдад улсын төсвийн 1.67 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83, гадаадын төсөл, хөтөлбөрийн 3.7 тэрбум төгрөгөөр 180, орон нутгийн төсвийн 3.7 тэрбум төгрөгөөр 287 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачилгаар 170 гар худаг, нийт 9.0 тэрбум төгрөгөөр 550 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 825.0 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон. 2020 онд бэлчээрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хэмжээг өмнөх оны түвшинтэй харьцуулахад төсвийн хөрөнгө оруулалт 470 сая төгрөгөөр, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт 2.5 тэрбум төгрөг буюу 38.5 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Харин орон нутаг болон малчдын санаачилгаар гаргах хөрөнгө оруулалт 400 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. НҮБ-ын Хнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хөдөө аж ахуйг дэмжих олон улсын сан, Швейцарын хөгжлийн агентлаг, Мерси кор Монгол зэрэг байгууллагуудын хүрээнд байгуулагдсан нийт 18 аймгийн 165 сумын 1630 малчдын бүлэг /бэлчээр ашиглагчдын хэсэг/ бэлчээр ашиглах гэрээг сумын Засаг даргатай байгуулан бэлчээрээ хамгаалан ажиллаж байна. Эдгээрээс бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулсан нь 900 гаруй байна.	
		1	Тэмцсэн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээ, талбайн хэмжээ, сая.га	1	6.2 Улсын төсөв	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Мэрэгч судлалын болон Шавж судлалын лабораторийн эрдэм шинжилгээний ажилчид хөнөөлт мэрэгч амьтад, шавжийн тархалт, олшрохын тодотгох судалгааг 2020 онд 20 аймгийн 215 сумын нутагт гүйцэтгэж, нийт 9.43 сая га бэлчээрийн талбайд ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.  1.Дээрх дүгнэлтэд суурилан бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг энэ оны 4-8 дугаар сарын хооронд улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 20 аймгийн 204 сумын нийт 1.65 сая га, 4 аймаг дундын отрын бүс нутгийн 0.64 сая га, нийт 2.29 сая га бэлчээрийн талбайг хамруулан гүйцэтгэлээ. Үүнээс үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг нийт 1.63 сая га, царцаатай тэмцэх ажлыг 0.66 сая га бэлчээрийн талбайд тус тус	



						<p>хэрэгжүүлсэн нь эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан нийт тэмцэх шаардлагатай талбайн 24.28 хувьд бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх ажил зохион байгуулсан. Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээний 2020 оны гүйцэтгэл нь өмнөх оноос 0.6 сая га, сүүлийн 10 жилийн дунджаас 1.0 сая га талбайгаар тус тус нэмэгдсэнээрээ онцлог байна. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг 2019 онд өргөн хүрээтэй бүх нийтийн ажил болгон зохион байгуулах зорилгоор Засгийн газрын 185 дугаар тогтоолоор жил бүрийн 5 сарын эхний долоо хоног болон 10 сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарласантай холбогдуулан бэлчээр хамгааллын арга хэмжээг эрчимжүүлэн өргөн хүрээтэй зохион байгуулж, үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээнд 20 аймгийн 200 гаруй сумын 400 гаруй багийн нийт 7000 орчим малчид, иргэд идэвхтэй оролцож ажилласан.</p> <p>2.Орон нутгийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр микро биологийн бэлдмэлийг 8 аймгийн зарим сумдын 285.0 мянган га талбайд цацаж, бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж, бэлчээрийн даацыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн болно.</p>	
<b>Зорилт 4. Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрийг бодлогоор дэмжинэ.</b>							
4.1	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18, 2.23, 2.34 дэх заалт	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40.0	-	<p>Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2020 онд хийгдсэн томоохон ажлуудаас дурдвал: Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 130 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ журмын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 2375 малчин, фермерийн аж ахуй эрхлэгчдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-387 дугаар тушаалаар нийт 969.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Улсын хэмжээнд 2020 онд 18.6 мянган га талбайд төмс, 9.6 мянган га талбайд хүнсний ногоо, 61.1 мянган га талбайд тосны ургамал,</p>	70

					<p>52.7 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалсан. "Ковид-19" халдварт цар тахлын эрсдэлтэй нөхцөлд ургамлын гаралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах зорилгоор хүнсний ногоог өнгөрсөн жилтэй харьцуулахад 26.5 хувиар илүү тариалсан. Улсын хэмжээнд 2020 онд нийт 244.3 мянган тонн төмс, 121.2 мянган тонн хүнсний ногоо, 160.0 мянган тонн тэжээлийн ургамал, 20.2 мянган тонн тосны ургамал тус тус хураан авсан. Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас "Өглөөний цай" болон "Ээжийн сонголт-Эрүүл хүнс" хөдөлгөөний хэлэлцүүлгийг 2020 оны 1 дүгээр сарын 10-нд Төрийн ордонд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны удирдлагууд холбогдох төрийн байгууллага болон цэцэрлэг, дунд сургуулиудын удирдлага, багш, эцэг эх, мэргэжлийн тогооч нарын төлөөлөл 100 гаруй хүн оролцсон. Хэлэлцүүлгээс олон нийтэд хандсан уриалга гаргасан. Пестицидийн үлдэгдлийг хянах төлөвлөгөөний төслийг боловсруулж, цахим хэлэлцүүлгийг 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан.</p>			
				<p>Нөөцийн махны хэмжээ, мянган.тонн</p>	10.0	3.7	<p>Улсын төсөв</p>	<p>Бэлтгэж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн. Нөөцийн махыг Нийслэлийн 9 дүүргийн 169 хорооны хүнсний 413 дэлгүүрээр дамжуулан хонины ястай мах 6700 төгрөг/кг, үхрийн ястай мах 7700 төгрөг/кг, ямааны мах 6200 төгрөг/кг үнээр худалдаанд гаргасан. Нөөцийн махны худалдааг 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүртэл нийслэлийн хүн амд худалдаалж, нийт 10.5 мянган тонн махыг нийлүүлээд байна. Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд доор дурдсан байдлаар махны нөөцийг бүрдүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Арилжааны банкны эх үүсвэрээр: 12 аж ахуйн нэгж, нийт 8857,0 тонн, Үүнээс: үхрийн ястай мах 2025 тонн, хонины ястай мах 4968 тонн, ямааны ястай мах 1864 тонн</li> <li>2. Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр: 4 аж ахуйн нэгж, нийт 552,0 тонн, Үүнээс: үхрийн ястай мах 305,3 тонн, хонины ястай мах 194,0 тонн, ямааны ястай мах 52,6 тонн</li> <li>3. Бодлогын гэрээгээр мал, мах бэлтгэсэн: 22 аж ахуйн нэгж, нийт 1102 тонн, Үүнээс: сүлжээ дэлгүүрээр 623,14 тонн, хүнсний дэлгүүрээр 479.26 тонн-ыг Нийслэлийн Захирагчийн ажлын албатай хамтран хэрэгжүүлсэн.</li> </ol>

4.2	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 2, ТХХААТББ-ын 3.1.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.39, 2.40, 2.45 дахь заалт	Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хангалтыг нэмэгдүүлэх	Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх хувь	5.0	0.16 Улсын төсөв,	Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд улсын төсвөөс 160 сая төгрөг, НҮБ-аас 113.5 сая төгрөгийн үрийн дэмжлэг үзүүлж, 19.2 мянган га -д 244.3 мянган тонн төмс, 10.6 мянган га-д хүнсний ногоо тариалж, 121.2 мянган тонн ургац хураав.	50
			Жимс, жимсгэнэ тариалах шинээр нэмэгдэх талбайн хэмжээ, га	8000	0.1 Гадаад эх үүсвэр	2020 оны Улсын төсвийн 99.0 сая төгрөгийн санхүүжилтээр тендер шалгаруулалт зохион байгуулан, Говь-алтай, Сүхбаатар аймагт тус бүр 3 га талбай бүхий жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг байгуулав. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт" төслийн 15.0 мянган ам.долларын санхүүжилтийн хүрээнд ХААИС-ийн харьяа Борнуур дахь туршилт судалгааны төвд "Жимс жимсгэнийн сортуудын туршилт судалгаа хийх, жимс жимсгэнийн генефонд байгуулах төсөл хэрэгжүүлэв. Үүний үр дүнд Чацарганын байгалийн хэлбэр дээжүүдээр генефонд байгуулж, суулгац үржүүлэх ажлыг эхлүүлэв. Монголын жимс, жимсгэнийн үндэсний холбоотой гэрээ байгуулан "Жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн газар байгуулах техникийн ерөнхий шаардлага" стандарт боловсруулж, батлуулав. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас жимс, жимсгэнэ хүнсний ногоо боловсруулах 9 аймгийн 14 аж ахуйн нэгжид 1.4 тэрбум төгрөгийн зээл олгов. Булган аймагт Шинэ хөдөө төслийн хүрээнд жимс, жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2018-2020 онд 217.5 мянган ширхэг үхрийн нүд, чацарганын суулгацыг иргэд аж ахуй нэгжид олгож, тариалуулав.	
			Хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикуулах түвшин, хувиар	60.0	3.2 Гадаад эх үүсвэр	Хөдөө аж ахуйг дэмжих санд үлдэгдэлтэй байсан төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн зориулалттай мотоблок, 50-80 морины хүчтэй трактор, бууц ачигч, ургамал хамгааллын бодис цацах машин, үрлүүр, сийрүүлүүр, лууван, манжин ухагч, хүнсний ногооны 1-3 га талбайг услах усалгааны систем зэрэг иж бүрдэл 450 гаруй техникүүдийн үнийг 50 хувиар хөнгөлж тариаланчдад олгосон. Энэ нь хүнсний ногооны гар ажлыг хөнгөвчилж хөрс боловсруулах, хүнсний ногоог үрлэх, тарилтын дараа арчилгаа хийх, усалгаа хийх ажлыг 60 хувь хүртэл механикуулав.	
4.3	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 3, ТХХААТББ-ын 3.1.7 дахь заалт, ЗГҮАХ-	Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулж, ургацын	Хураан авах үр тарианы хэмжээ, мянган.тонн	400	5.0 Улсын төсөв	2020 оны ургац хураалтын дүнгээр 430.3 мянган тонн үр тариа, үүнээс 408.1 мянган тонн улаан буудай, 244.3 мянган тонн төмс, 121.2 мянган тонн хүнсний ногоо, 21.2 мянган тонн тосны ургамал, 169.4 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд 238.6 мянган тонн буудай нийлүүлэгдээд байна. 2020 онд аж ахуйн нэгж, иргэд 356.4	70

ийн 2.18, 2.39-2.47 дахь заалт	хэмжээг нэмэгдүүлэх, Атрын IV аяныг эхлүүлэх			12.7 Хувийн хэвцил	мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэсний 196.1 мянган га талбайг нь дэвшилтэт технологиор боловсруулсан бөгөөд дараа оны тариалалтад зориулан аж ахуйн нэгж, иргэд 42.2 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн байна. Ургацын хэмжээг нэмэгдүүлж чанарыг сайжруулах, тариаланчдад учрах санхүүгийн дарамтыг багасгах, тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд чанартай зохион байгуулах зорилгоор 4.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 2.6 мянган тонн шатахуун, 11.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 12.5 мянган тонн улаан буудайн үр, 2.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий бордоо, ургамал хамгааллын бодисыг 30-50 хувийн урьдчилгаатайгаар давхардсан тоогоор 1100 гаруй иргэн, аж ахуйн нэгжид зээлээр олгож дэмжлэг үзүүлсэн. Ерөнхий Сайдын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар захирамжаар "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг Улсын хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөлийг байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А-118 дугаар тушаалаар "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан, орон нутагт хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгууллаа.
		Усалгаатай талбайн хэмжээ, мянган га	50 хүртэл	8.0 Гадаад эх үүсвэр	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд олгож буй усалгааны тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийг олгох үнэ нөхцөлийг батлах тухай Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2020 оны А-145, А-136 дугаар тушаалаар усалгааны тоног төхөөрөмжийн үнийг 50 хувь хөнгөлж урьдчилгаа төлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй 6 жилийн хугацаатайгаар олгосон. Үүний үр дүнд зээлийн шалгуур хангасан үр тариа, тэжээлийн таримал тариалдаг эрхэлдэг 30 аж ахуйн нэгж, иргэнд 42 ширхэг бороожуулагчийг зээлээр олгож, суурилуулаад байна. Үүний үр дүнд Усалгаатай газар тариалангийн талбайг 3000 га талбайгаар нэмэгдүүлсэн. Мөн Азийн хөгжлийн банкны "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийг 2020 оноос эхлүүлж үүний үр дүнд усалгаатай тариалангийн талбайг 7.9 мянган га нэмэгдүүлэх боломж бүрдсэн.
		Аяны бэлтгэлийг хангах ажлын явц, хувиар	100.0	5.8 Улсын	Ерөнхий Сайдын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар захирамжаар "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөлийг байгуулсан.



					төсөв	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А-118 дугаар тушаалаар "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсан. Төлөвлөгөөнд 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 77.7 хувийн биелэлттэй байна.	
4.4	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.15, 2.50, 2.54 дэх заалт	Жижиг, дунд үйлдвэр болон загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих	Ажлын байрын тооны өсөлт, хувиар	20.0	22.9 Улсын төсөв	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2020 онд эргэн төлөлтийн эх үүсвэрийн хүрээнд төсөл хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 1579 төслийн 238.4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт хүлээн авч 249 аж ахуйн нэгжийг 22.9 тэрбум төгрөгөөр дэмжиж, 1497 шинэ ажлын байрыг бий болгов. Энэхүү шинэ ажлын байр нь 2019 онтой харьцуулахад 49.6 хувиар бага байгаа нь Улсын төсөвт ЖДҮХС-ийн эх үүсвэрийг тусгаагүй, Ковидын нөхцөл байдлын улмаас Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах" талаар гаргасан 2020 оны А-83, А-373 дугаар тушаалын хэрэгжилтийн улмаас төлөвлөсөн эргэн төлөлтийн орлого буурсантай холбоотой юм.	50
4.5	МУТХҮБ-2030-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 5.6.8 дахь дэд заалт	Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Экспортын боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт, хувиар	2.0-оос доошгүй	7.3 Улсын төсөв	Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, брэнд бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, олон улсын стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг экспортлох, шинэ зах зээлд гаргах, түншлэлийг бий болгох зорилгоор "Улаанбаатар түншлэл-Н23 Олон улсын үзэсгэлэн худалдааг 2020 оны 9 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 110 гаруй ААН оролцсон.  -"Монгол экспорт экспо-2020" дотоодын үзэсгэлэн худалдааг 2020 оны 11 дүгээр сард Мишээл экспо төвд зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн салбарын 108 үйлдвэрлэгчид оролцож, 300 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. Нийт давхардсан тоогоор 6000 гаруй хүн очиж сонирхон худалдан авалт хийсэн.  - "Экспорт монгол 2020" Олон улсын цахим форум, сургалт, виртуал үзэсгэлэнг ГХЯ, ҮХГ, Экспорт Дэлхийн олон улсын худалдааны төв ТББ-тай хамтран 2020 оны 12 сард зохион байгуулсан. Цахим үзэсгэлэн худалдаанд хөнгөн, хүнсний салбарын нийт 43 ААН 200 гаруй нэр төрлийн бараа	30

					<p>бүтээгдэхүүнээр оролцсон бөгөөд 10 гаруй орноос давхардсан тоогоор 24000 гаруй удаагийн хандалт хийж, сайтад байршуулсан ААН-ийн материалуудаас 200 гаруй материалыг татаж авсан байна. Нийт арга хэмжээний хүрээнд <a href="https://www.expromongolia.org/">https://www.expromongolia.org/</a> хаягаар АНУ, Япон, Австри, ХБНГУ, Франц, ОХУ, БНХАУ, Их Британи, Сингапур, Вьетнам, Болгар, Чех, Польш, БНСУ зэрэг 20 орчим улсын 360 гаруй, дотоодын 1600 гаруй оролцогч бүртгүүлэн оролцож, бусад олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар 6400 гаруй удаагийн хандалт хийсэн. "Ковид-19" цар тахалтай холбоотой 2020 оны 2 сараас хойш бизнесийн үйл ажиллагаа хумигдаж хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ 60 хүртэл хувиар буурсан. Тухайлбал, арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс шир өнгөрсөн онтой харьцуулахад экспорт 47 хувиар, ноос ноолуурын салбарын борлуулалт 60 хувиар тус тус буурсан. Ажиллах хүчин 50 хувиар сул зогсож, 10 хувийг цомхотгосон байна.</p>	
4.6	МУТХУБ-2030-ын 2.1.3, Зорилт 1, 4, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын 4.2.3 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.48, 2.50, 2.55, 2.56, 2.57 дахь заалт	"Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	21 аймагт үйлдвэр байгуулах	<p>0.44 Гадаадын хөрөнгө оруулалт, 2.8 Хувийн хэвшил, 0.75 ЖДҮХС</p> <p>Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд Бүтээн байгуулалтын ажил 100 хувь хийгдэж шинээр бүрэн ашиглалтад орсон 47 үйлдвэр, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа 23 үйлдвэр, хөтөлбөрийн 5.4-т "Хөтөлбөр хэрэгжих явцад улсын болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин зэргээс шалтгаалан үр ашиг, ач холбогдол бүхий шинээр байгуулсан үйлдвэрийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйлдвэрийн тоонд тооцож болно" гэж заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, гадаадын хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр, нийт 81 үйлдвэр 2018-2020 онд байгуулагдсан байна. Үүнээс нийслэлд 5, орон нутагт 76 үйлдвэр /2017 онд 2, 2018 онд 22, 2019 онд 48, 2020 онд 9 шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.</p> <p>Хөтөлбөрийн үр дүнд: Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувьд хүрч, арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 41 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 26 хувь, нийт 81 үйлдвэр байгуулагдаж 4100 орчим ажлын байр бий болсон байна.</p>	70

**Зорилт 5. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.**

5.1	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 1-ийн I үе шат, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид "ТЭБСББ" гэх/-ын 3.2.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.59 дэх заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх	1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	45.0	17.6  Улсын төсөв	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Тэрэм уул-50, Тээгийн гол-50, Сант-50, Баян-Индэр-50 төслүүдийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2020 оны А/35, А/39, А/149, А/150 дугаар тушаалаар хүлээн авсан. Эдгээр талбайд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар бүрхсэнээр тухайн талбайд тархсан төрөл бүрийн хурдас чулуулгийн тархалт, хил зааг, нас, найрлага зэргийг тодорхойлон зурагласан бөгөөд ашигт малтмалын хэтийн төлөвийг тодруулж, хэтийн төлөвтэй 20 талбайг ялгасан. 2020 онд үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2020 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийг хэлэлцэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн сайдын 2020 оны А/112 - А/122, А/128, А/131 - А/142, А/144 - А/146 дугаар тушаалаар баталсан. Мөн 2020 онд шинээр Овоот толгой-50, Улаангом-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Хар хайрхан-50, Их бэрх уул-50, Цэцэрлэг-50, Их элзэт уул-50, Их хараат уул-50, Үнэгт уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, нийт 12 төслийг шинээр хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдаар 2020 оны 2-р сарын 14-ний өдөр батлав. Төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг цахимаар зарлан, 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар тендерт шалгарсан 6 гүйцэтгэгч нартай зөвлөх үйлчилгээний гэрээг тендер хүчинтэй байх хугацаанд буюу 6 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан. Энэхүү ажилд 2020 онд 8.5 тэрбум төгрөг зарцуулахаар батлуулж, санхүүжилтийг олгосон. Худгийн нуруу-50, Норовлин-50, Их Өлзийт-50, Цайлангийн нуруу-50, Галбын говь-50, Сүүжийн говь-50, Номгоны нуруу-50, Олон гол-50, Шүтээн улаан уул-50 төслүүдийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Сайдын тушаалаар хүлээн авч, гэрээ дүгнэгдсэн ажлууд монгол улсын газар нутгийн 41 хувийг бүрэн хамруулсан бол үргэлжилж байгаа төслүүдийг хүлээн авснаар нийт газар нутгийн 45 хувийг хамрахаар байна.	90
			Улсын геологийн иж бүрдэл зургийг К, L, M	2		1. Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх төслийн 2020 оны төсөв, төлөвлөгөөг Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн сайдын 2019 оны А/254 дүгээр тушаалаар	

		<p>болон N хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх төслийн тоо</p>				<p>батлуулж суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн. Мөн төслийн 2020 оны суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/127 дугаар тушаалаар баталсан.</p> <p>2. Улсын геологийн иж бүрдэл зургийг L хавтгайн хэмжээнд нэгтгэх төслийн 2020 оны төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлуулж хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслийн 2020 оны хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/130 дугаар тушаалаар баталж ажлыг үргэлжлүүлсэн.</p> <p>3. Монгол орны M (N) хавтгайн хэмжээнд иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг 2020 онд эхлүүлэхээр Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн сайдын А/254 дүгээр тушаалаар төлөвлөгөө, төсвийг баталсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдын 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр баталсан. Төслийн ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй гэрээг 6-р сарын 12-нд байгуулсан. Улсын геологийн иж бүрдэл зургийг K, L, M (нийт 3 төсөл) хавтгайн хэмжээнд нэгтгэх ажилд 2020 онд 1.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлуулж, бүрэн олгоод байна.</p>
		<p>Агаарын геофизикийн судалгааны ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар</p>	<p>2.5</p>			<p>Монгол орны баруун хэсэг буюу 104,044.0 кв.км талбай /6.6%-г хамарсан агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгийн судалгааны ажлыг 2020 онд хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдын 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/254 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг тус тус батлуулсан.</p> <p>Энэхүү Ховд-2020 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч байгууллага гэрээ болон ажлын даалгаварт заасны дагуу төлөвлөгөөт онд нийт судалгаа хийх 104,044.0 кв.км буюу 6.6% талбайгаас 53,062 кв.км буюу 51%-д судалгааг хийсэн. Өөрөөр хэлбэл нийт 58960 тууш км нислэг үйлдэхээс 30283 тууш км нислэгийг үйлдсэн байна. Ингэснээр нутаг дэвсгэрийн судалгаанд хамрагдсан суурь түвшин 60 хувийг 3.4 хувиар нэмэгдүүлж, завсрын суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэж</p>



					байна. Төслийн ажилд 593.9 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөж төсвийг бүрэн олгосон.
		Монгол орны геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлын явц, хувиар	40.0		Монгол орны нутаг дэвсгэрийн 1,1 сая кв.км талбай /73.5 хувь/-г хамарсан 1:1000000-ны масштабын геохимийн зураглал хийх, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны ажлыг 2020 онд үргэлжлэн хэрэгжүүлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/254 дүгээр тушаалаар төсөв, төлөвлөгөөг батлуулж суурин боловсруулалт, хээрийн судалгааны ажлын бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Төлөвлөгөөт онд Монгол орны төв хэсэгт буюу L-47,48, 49, M-47, 48, 49 хавтгайд хээрийн судалгааны дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд ингэснээр судалгааны талбайн 65 хувьд хээрийн судалгааг гүйцэтгэсэн.
		Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах сэдэвчилсэн судалгааны ажлын тоо	5		Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/254 дүгээр тушаалаар дараах ажлуудын төсөв, төлөвлөгөөг батлан дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: 1. Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын суурин болон хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/126 дугаар тушаалаар батлан үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. 2. Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын даалгаврыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдын 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр тус тус баталсан. Судалгааны ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг цахимаар зарлаж гүйцэтгэгч хуулийн этгээдийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг 2020 оны 6-р сарын 12-ны өдөр байгуулан ажлыг эхлүүлсэн. Дээрх 2 төслийн 2020 оны хээрийн судалгааны ажлын баримт материалыг цахимаар хүлээн авсан. 3. Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/143 дугаар тушаалаар батлуулан суурин болон хээрийн судалгааны ажлын бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Стратегийн ашигт малтмалын төрлүүдийг тектоник, металлогени болон бусад геологийн хүчин зүйлс, дэд бүтэц зэрэг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдтэй хамтатган судалж, өнөөдрийн

					<p>нөхцөлд стратегийн ашигт малтмал гэж авч үзэх төрлүүдийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт өгөх, энэхүү судалгааны үр дүнд дэлхийн түүхий эдийн зах зээл дээр эрэлт ихтэй өндөр технологийн болон энергийн түүхий эдийг нарийвчлан судалж, Монгол Улсын экспортын чиг хандлагыг тодорхойлох суурь судалгааг 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж үр дүнг хүлээн авна.</p> <p>4. Үндэсний гео-мэдээллийн санг Интрузив, эффузив чулуулгийн үнэмлэхүй насны мэдээллийг нэгтгэх, Давхарга зүй, палеонтологийн олдвор, горизонтын тулгуур зүсэлтийн мэдээллийг нэгтгэх, хээрийн баримт материал, үр дүнгийн тайлангийн мэдээллийг цахимаар хүлээн авах, сан бүрдүүлэх аргачлал, үлгэрчилсэн загвар боловсруулах, багажийн хэмжилтийн утгыг нарийвчлан гаргах, бүх төрлийн масштабын геологийн зураг, давхаргын мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн загварт оруулах зорилгоор 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн Гео-мэдээлэл-2019 төслийн 2020 оны ажлын хэмжээ, арга аргачлалыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/129 дүгээр тушаалаар баталж суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн. 2021 онд төслийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>5. Голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017) төслийн ажлын үр дүнд тогтоогдсон ашигт малтмалын хэтийн төлөвтэй 3 талбай буюу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших 245.01 кв.км талбайд үнэт, холимог металлын чиглэлээр эрэг-үнэлгээний ажил (ЭҮ-1-2020)-ын геологийн даалгаврыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдын 2020.2.14-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Төслийн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж шалгарсан этгээдтэй 6-р сарын 12-ны өдөр гэрээ байгуулсан. Төслийн ажлын хээрийн материалыг хүлээн авсан. Төсөлд 682.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулаад байна.</p>
		"Алт-2" хөтөлбөрийн хүрээнд Монгол орны алтны	1		Монгол орны баруун, баруун өмнөд, хангайн бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны ажил (БӨМ-Алт-2019)-ыг үргэлжлэн хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/254 дүгээр тушаалаар

			хэтийн төлөвийг тогтоох хүрээнд хэрэгжүүлэх төслийн тоо			батлуулсан. Төслийн 2020 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/125 дугаар тушаалаар батлуулж, суурин болон хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Монгол орны зүүн, зүүн өмнөд (ТЗМ-Алт-2017) төслийн хүрээнд 521,200.0 кв.км талбай буюу 33.3 хувьд тархсан алтны хүдэржилт бүхий талбай, дүүрэг, зангилаа, түүнд тогтоогдсон орд, илрэл, эрдэсэжсэн цэг, сарнилын хүрээ бүхий хэсгүүдийг 100 хувь нарийвчлан судалж, төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. БӨМ-Алт-2019 төслийн 2020 оны төсвийг 1.14 тэрбум төгрөгөөр батлуулан, санхүүжилтийг олгоод байна.	
5.2	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24 дэх заалт, 2.61 дэх заалт	Уул уурхайн салбарын томоохон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	84.0	2,740.0  Хувийн хөрөнгө оруулалт	Далд уурхайн нэвтрэлт 48,173 экв.мет буюу 112 хувьтай, газрын гадарга руу гарах туузан дамжуурга 12,762 экв.метр буюу 85 хувьтай, инженерийн зураг төсөл 99.7 хувьтай, босоо ам 1, 2-ын гүйцэтгэл дууссан ба 3, 4-р амны барилгын ажил 60.44 хувьтай, материал гаргах систем 64.9 хувьтай хэрэгжиж байна. 2020 онд төлөвлөсөн далд уурхайн бүтээн байгуулалт 95 хувьд хүрсэн. Далд уурхайн бүтээн байгуулалтын ажил 26 хувьтай байна. Уг төсөлд нийт 4.0 тэрбум ам.долларын санхүүжилт хийгдээд байгаа ба 2020 онд 900 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Далд уурхайн геотехникийн асуудлаас үүдэн далд уурхайн санхүүжилт нэмэгдэх, далд уурхай ашиглалтад орох хугацаа хойшилсон.	90
			Тавантолгойн ордын ашиглалтыг өргөжүүлэн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын явц, хувиар	30.0		2020 оны төсөвт суулгасан 2 флит уулын техникийн худалдан авалтыг хийсэн. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэлтийн хөрөнгө оруулалт 4.5 хувьд, Конвейерын системийн ТЭЗҮ боловсруулах ажил 10 хувьд, төслийн Монгол Улсын стандарт шаардлага хангасан ТЭЗҮ боловсруулах ажил дууссан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэргэжлийн шинжээчдийн баг 2020 оны 11 дүгээр сарын 12-нд томилогдон ажиллаж байна. Шинжээчдийн багийн дүгнэлт гарсны дараа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлсэн. ТЭЗҮ-ийг боловсруулах, батлуулах ажил 95 хувьд хүрсэн. Загийн усны хоолойн гүний усны ордоос Тавантолгойн уурхай хүртэл 70 км шугам хоолой татах трассыг баталгаажуулан захирамж гаргасан. Тус усан хангамжийн системийг цахилгаанаар хангах техникийн нөхцөлийг ЭХЯ болон Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ	

					ТӨХК-аар гаргуулсан. Ус хангамжийн системийн зураг төсөл боловсруулах ажил дууссан. Баталгаажуулах гарын үсэг зурах, экспертизээр хянуулах шатанд хүлээгдэж байна. Зураг төсөл, холбогдох шийдвэр гаргах ажлууд 90 хувьтай.	
5.3	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, 4, ЗГҮАХ-ийн 2.70-2.73 дахь заалт	Эдийн засгийн өсөлтийг дэмжих хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	40.0	500.0 Гадаад эх үүсвэр  20.9  Улсын төсөв	30

Газрын тос боловсруулах үйлдвэрийн төлөвлөлт, инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжуудын барилга-угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, БНЭУ-ын "Жи Эм Си Прожектс Индиа" компани шалгарч, төслийн менежментийн зөвлөх компанитай ажил гүйцэтгэх гэрээг 2020 оны 10-р сарын 13-ны өдөр гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаж байна. Технологийн зарим байгууламжийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилсан сонгон шалгаруулалт болон гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгох ажлууд дуусах шатандаа явж байна. 2020 онд Төслийн менежментийн зөвлөх компани "Инженерс Индиа Лимитед" компанид хуваарийн дагуу төлбөр хийсэн бөгөөд үйлдвэрийн бүтээн байгуулалт, худалдан авалтад санхүүжилт хийгдээгүй болно. Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхон барих төслийн талаар:

-Хотхоны бүтээн байгуулалтын ажил 2020 онд эхний ээлжийн 4 орон сууцны 5 давхар, офисс-үйлчилгээний барилгын 1 давхрын цутгалтын ажил тус тус хийгдсэн ба барилгын ажилд Хөгжлийн банкны санхүүжилтээр 20.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

*Үйлдвэрийн дэд бүтцийн талаар:*

Авто зам: Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас газрын тос боловсруулах үйлдвэрийн авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хяналт шалгалт хийж, хэрэгжилттэй нь танилцаж, цаашид хийж гүйцэтгэх ажлын үүрэг даалгаврыг өгч ажилласан.

Төмөр зам: Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбосон төмөр замын тээвэрлэлт, арчлалт, хамгаалалтын ажлыг "Монголиан транс ложистик" ХХК хийж



				гүйцэтгэж байна.	
				Эрчим хүч: Бор хөөврийн говийн усан хангамжийн эрчим хүчний ЦДАШ, дэд станц барих урьдчилсан тооцоог Монгол улсад хэрэглэгдэж байгаа үнийн жишгийг үндэслэн боловсруулаад байна. Мөн үйлдвэрийн газрыг хашаажуулах болон талбайн газар шорооны ажлуудыг 2020 оны 04 дүгээр сараас гүйцэтгэж эхлээд байна. Уг ажил 6 дугаар сарын байдлаар үйлдвэрийн талбайн тэгшилгээний ажил 20 хувийн гүйцэтгэлтэй, нийт 5000 м хамгаалалтын хашаа (1500 м төмөр бетон, 3500 м төмөр сараалж) барихаас 1500 м төмөр бетон хашааг талбайд зөөвөрлөөд байна. Үйлдвэрийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж дууссан бөгөөд 2019 онд ашиглалтад хүлээн авсан.	
		Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах шугам хоолойн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын явц, хувиар	100.0	5.0 Гадаад эх үүсвэр	Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тэмдэглэлээр үйлдвэрт шаардлагатай түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэн. Тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах талаар Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. МГТБҮ ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/11, 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/51 дугаар тушаалуудаар Ажлын хэсэг байгуулж тос дамжуулах хоолойн трассыг оновчлон, Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Баруун-Урт, Халзан, Баяндэлгэр, Дорноговь аймгийн Дэлгэрэх, Өргөн, Алтанширээ сумдын нутгаар дамжин нийт урт 530 км урттай байхаар урьдчилсан байдлаар тооцоолоод байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/267-р тушаалаар "Дамжуулах хоолойн ТЭЗҮ-ийн ажлын даалгавар боловсруулах, трассыг эцэслэн тогтоох, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал дүгнэлт боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж трасст зохих өөрчлөлтийг хийж, Газар зохион байгуулалт, зураг зүйн газрын мэдээллийн санд бүртгүүлэхээр хүргүүлсэн. Дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулахаар бэлтгэл хангаж тендерийн баримт бичгийн төслийг боловсруулаад байна.
		Нүүрс угаах, гүн боловсруулах	15.0	450.0	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/43 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд

			үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар		Хувийн хөрөнгө оруулалт	<p>"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж Дэлхийн банкны стандарт шаардлагад нийцсэн ТЭЗҮ, бүс нутгийн байгаль орчны үнэлгээ болон байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлангуудыг боловсруулж бэлэн болгоод байна. Төслийн ТЭЗҮ-д тооцоолсон одоогийн хүчин чадлаар үйлдвэрийг барихад 2.5 тэрбум ам.доллар буюу их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй байгаа тул төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж, зорилготой хүчин чадалд хүргэх боломжийг судлах зорилгоор батлагдсан ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийх, мөн төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгох, түүнтэй гэрээ хэлэлцээр хийх, газрын болон бусад холбогдох зөвшөөрлүүдийг авахад уг төслийн үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх төсөл хэрэгжүүлэх нэгж бус аж ахуйн тооцоот хуулийн этгээд эрхлэн явуулах хууль, эрх зүйн бодит шаардлага үүссэн бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02 тоот шийдвэрийн дагуу асуудлыг Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газраас Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төслийн нэгжийг татан буулгах чиг үүргийг "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлэх асуудлыг дэмжин 451 дугаар тогтоолыг баталсан.</p>
		15.0	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар		<p>1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын 2018.12.12-ны өдрийн "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 378 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолын дагуу 2019.04.03-ны өдөр улсын тусгай хэрэгцээнд газрыг ашиглуулах тухай 2019/01 дугаар гэрээг байгуулсан. Түүнчлэн тус үйлдвэрийг байгуулах тухай асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмж гарсан бөгөөд Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2017.09.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж, нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна.</p> <p>2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ</p>	

		<p>ХАНГАЙН ХАНГАЙН ХАНГАЙН ХАНГАЙН ХАНГАЙН</p>	<p>ХАНГАЙН ХАНГАЙН ХАНГАЙН ХАНГАЙН ХАНГАЙН</p>			<p>боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагаа нь Төрийн нууцад хамаарсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу зохион байгуулах болсон. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгох аргачлалын төсөл, хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулан Засгийн газарт танилцуулан Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлийн дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өгсөн зөвлөмжийн дагуу үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэх бэлтгэл ажлын хүрээнд Ажлын баг Өмнөговь аймгийн Ханбогд суманд ажиллаж үйлдвэрийн ус хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор гадаргын болон газрын доорх усны эх үүсвэр олох судалгааг гүйцэтгэж, үр дүнгээр тайлан боловсруулсан.</p> <p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн макетыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж. Үйлдвэрийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, гадаад дэд бүтэцтэй холбох судалгааны ажлын хүрээнд үйлдвэр байгуулах талбайн топо суурь зураг, цахилгаан эрчим хүчний агаарын шугам, дэд өртөө, салбар төмөр зам байгуулах замын зураглалыг гүйцэтгэж, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс гарах дайвар бүтээгдэхүүн болох хүхрийн хүчлээр фосфорын баяжмалыг боловсруулан фосфорын бордоо үйлдвэрлэх ТЭЗҮ-ийг боловсруулсан.</p>
		<p>Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр болон Төмөртэйн ордын баяжуулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар</p>		10.0	75.0 Хувийн хөрөнгө оруулалт	<p>“Уул уурхай хар төмөрлөгийн цогцолбор” байгуулах төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 1-р шатны ажлууд болох төмрийн хүдрийн ордуудаа эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн үйлдвэрлэлийг дэд бүтцийн хамт байгуулах ажлуудыг амжилттай хэрэгжүүлэн төмрийн хүдрийн 2 уурхай нээж, уурхайнууд дээр хуурай соронзон баяжуулах үйлдвэрүүд, гангийн үйлдвэрийн дэргэд нойтон баяжуулах үйлдвэр зэргийг дэд бүтэц /төмөр зам, ачиж буулгах терминал, авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц г.м/-ийн хамт барьж байгуулсан. Төслийн 2-р шатанд шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, гангийн үйлдвэрийг өргөтгөх, шинэ гангийн үйлдвэр байгуулах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд: Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дархан-</p>

					<p>Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн техник-эдийн засгийн үндэслэлийг Канад Улсын "Hatch" компани гүйцэтгэн 2017 онд, "Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ"-г Монгол Улсын "Экотон" ХХК болон "Ажид" ХХК, "Экосфер" ХХК-иуд гүйцэтгэж, 2019 онд тус тус хүлээлгэн өгсөн.</p> <p>Ган бөмбөлгийн цувих үйлдвэр барих талбайн инженер геологийн судалгаа -25000 тонн/жил хүчин чадалтай ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэр -6 кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугам, 6 кв-ын хуваарилах байгууламж, 6/0.4 кв-ын 2х2500 квт чадалтай дэд станцын барилга -Бэлдэц үйлдвэрлэх цех дэх 25 тонн багтаамжтай шанган зуухны тоног төхвөрөмж -Бэлдэц үйлдвэрлэх цөхийн 6/0.4 кв-ын 1600 квт дэд станц, үйлдвэрийн 110/22/6.6/6 кв-ын Төмөрлөг дэд станцыг 110/22 кв-ын 6.3 МВА дэд станцаар өргөтгөсөн өргөтгөл, 22кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугам, барилга -Хаягдал төмрийг боловсруулах пресс хайчны тоног төхөөрөмжийн угсралт -Цахилгаан соронзон холигч, хэлбэлзүүлэгч ширээ, зэс талсжуулагч шинээр суурилуулах ажлыг 2019 оны 03 сард эхлүүлсэн бөгөөд туршилтын ажлыг хийж 04 сард ашиглалтад оруулсан. Төслийн хүрээнд дээрх бүтээн байгуулалтын ажилд нийтдээ 630.8 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.06.03-ны өдрийн А/136 дугаар тушаалаар байгуулагдсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх концессын гэрээ"-ий хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг нь төслийн явц 75 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн.</p> <p>2020 оны хилийн эцсийн байдлаар Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 7 компанид, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 компанид, үнэт металл, эрдэнийн чулуугаар үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 компанид шинээр олгосон. Мөн "Люкс минерал" ХХК-ийн төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасан.</p>	
5.4	ЗГҮАХ-ийн 2.17.6, 2.63.4 дахь заалт	Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог	Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны	50.0	Өнөөгийн байдлаар манай улс шатахууны хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2019 онд 493.4 мянган тонн автобензин, 1,118.4 мянган тонн дизель түлш, 2020 онд 568.3 мянган тонн автобензин, 966.9 мянган тонн дизель түлш, нийт 1,535.2 мянган тонн шатахуун тус тус импортлон хэрэглэжээ.	70



		<p>сайжруулж, Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх</p>	<p>хэмжээ, хувиар</p>			<p>Үүнээс Евро-5 /K5/ стандартын шаардлагад нийцсэн шатахууны импорт, хэрэглээ 2019 онд 211.7 мянган тонн буюу нийт шатахууны 13.1 хувь байсан бол 2020 онд 229.7 мянган тонн буюу нийт шатахууны 14.9 хувийг тус тус эзэлж байна. Хэдийгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч, манай улсын импортолж, хэрэглэсэн Евро-5 стандартын шатахууны хэмжээ дорвитой нэмэгдэхгүй байна. Энэ нь ОХУ-ын Роснефть компаниас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартад нийцсэн шатахууны импортын үнэ ердийн шатахууны импортын үнээс тонн тутамдаа төрлөөс хамааран 25-60 ам.доллараар өндөр байдгаас шалтгаалан Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ ердийн шатахууны үнээс 100 орчим төгрөгөөр илүү байдагтай холбоотой юм.</p> <p>Манай улсын шатахууны гол ханган нийлүүлэгч "Роснефть" ХХК-тай 2017, 2018, 2019 онуудад хийсэн ээлжит уулзалтуудаар Монгол улсад нийлүүлэх Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх, үнийн хөнгөлөлт үзүүлэх талаар тухай бүр санал тавьж хэлэлцэж ирсэн. Роснефть компанийн хувьд ОХУ-ын дотоодын хэрэгцээг Евро-5 шатахуунаар хангах асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа тул Монгол улсад нийлүүлэх Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх боломж, нөхцөл бага байгаа боловч, импортлогч компаниудын урьдчилсан захиалгын дагуу боломжит хэмжээгээр нийлүүлэх талаар анхаарч ажиллахаа илэрхийлсэн болно. Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд тухайн бүтээгдэхүүний импорт, хэрэглээг дэмжсэн, экологийн бага ангиллын шатахууны хэрэглээг хязгаарлах, үе шаттай хориглох эрх зүй, татварын орчин бүрдүүлэх нэн шаардлагатай байгаа болно. Тухайлбал шатахууны Онцгой албан татварын хувь хэмжээг экологийн ангилалтай уялдуулах, Евро-5 стандартын шатахууны онцгой албан татварыг экологийн бага ангиллын стандартын шатахуунаас харьцангуй багаар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх нь тус бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд чухал дэмжлэг болох юм. Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг дэмжсэн эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p>
--	--	---	-----------------------	--	--	---

						<p>-Онцгой албан татварыг шатахууны чанар, стандарттай уялдуулан тогтоом, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.</p> <p>-Агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Агаарын тухай хуульд нэмэлт оруулах хуулийг төслийг боловсруулсан.</p>	
<b>Зорилт 6. Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.</b>							
<b>6.1</b>	<b>МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /цаашид "ТЭХТББ" гэх/-ын 3.2.1.2, 4.1.1.4 дэх заалт, ЗГҮАХ-ийн 2.97 дахь заалт</b>	<b>Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх</b>	<b>Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар</b>	<b>100.0</b>	<b>4.0</b>  Улсын төсөв  76.2  Гадаад эх үүсвэр	<b>БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг өргөтгөх төслийн ажил 2020 оны байдлаар турбингенераторын угсралт 95 хувьтай, турбин цехийн 8м,13м, 18м түвшний цутгалт хийгдсэн, үндсэн барилгын ажил 95 хувьтай, деаэратор, эргэлтийн усны насос, бөмбөлгөн шүүлтүүр суурилуулсан, хими цехийн тоног төхөөрөмжийн суурийн цутгалт хийгдсэн, хөргөх цамхгийн ган каркасны угсралт 40 хувь, гадна дулааны шугам хоолойн суурь хийгдсэн, төслийн нийт хэрэгжилт 75 орчим хувьтай байна.</b>	<b>30</b>
			<b>Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар</b>	<b>30.0</b>	<b>-</b>	<b>Хөгжлийн банкны шаардлага хангасан ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ерөнхий үнэлгээг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, шалгарсан БНХАУ-ын ТБЕА компанитай гэрээг байгуулсан. Захиалагч болон ТБЕА ХХК-ны хооронд Төсөл хэрэгжүүлэх нэгжийг санхүүжүүлэх гэрээг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгч ТБЕА компани нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу нийт гэрээний үнийн дүнгийн 30%-ийг өөрөө эхлэн санхүүжүүлж, ажлыг эхлүүлсэн бөгөөд, 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр "Эрчим хүчний хөгжлийн төв" Төрийн өмчийн үйлдвэрийн газартай барилга угсралтын ажлын зураг төсөл магадлал хийлгэх гэрээг байгуулсан. Зураг төслийг барилгын тухай хуульд нийцүүлэн объект, зардал тус бүрээр боловсруулан эхний гүйцэтгэлийг ашиглагч болон Эрчим хүчний хөгжлийн төвөөр хянуулан, ЭХЯ-нд ирүүлээд байна. Барилга угсралтын ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 15-наас</b>	

					эхлэх төлөвлөгөөтэй байсан боловч, "Ковид-19" цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор хөл хориотой онцгой үеийн дэглэмийг мөрдөн ажиллаж төлөвлөсөн хугацаанаас хоцорч эхэлсэн хэдий ч, ажлыг шуурхай зохион байгуулж, эрчимжүүлж ажилласны дүнд 2020 онд төслийн барилга угсралтын суурийн ажлыг гүйцэтгэсэн бөгөөд төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна.
		Хоёрдугаар дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар	10.0		Монгол Улсын эрчим хүчний системд түргэн маневрлах чадвартай турбингенератортой болох зорилгын хүрээнд 50*2 МВт-ын хийн генератор бүхий 100 МВт-ын цахилгаан станцыг ДЦС-2-ыг түшиглэн барьж байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулан 2020 оны 02 дугаар сард ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр гадаадын хөрөнгө оруулагч хэд хэдэн байгууллагад хүсэлт хүргүүлсэн. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын хорио цээрийн улмаас төслийн талбартай танилцах боломж бүрдэхгүй байна.
		Гуравдугаар дулааны цахилгаан станцын өндөр даралтын хэсгийн суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явц, хувиар	30.0		Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх ТЭЗҮ-ийг боловсруулж салбарын Шинжлэх, ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Төслийн 85 хувийг Монгол Улсын Хөгжлийн банкны урт хугацаат хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр, 15 хувийг Улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэж, Хөгжлийн банканд 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн б/385 тоот албан бичгээр дахин хандсан. Хөгжлийн банкнаас зээл авахаар холбогдох судалгаа хийгдэж байна. Мөн Сангийн яамнаас 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 8-1/7567 тоот албан бичгээр Дулааны 3 дугаар цахилгаан станцын 75, 250 МВт-ын өргөтгөлийн санхүүжилтийг бүхэлд нь ОХУ-ын Засгийн газрын экспортын зээлээр шийдвэрлэхийг санал болгосны дагуу Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна.
		Дөрөвдүгээр дулааны цахилгаан станцын турбингенератор /№1-4/-ийг шинэчлэх ажлын явц, хувиар	100.0	194.0 Гадаад эх үүсвэр	"ДЦС-4" ТӨХК-ийн турбоагрегат 2, 3-ын шинэчлэлийн ажил. Төслийн эхний үе шатанд турбоагрегат №1, 4-ийг 2019 онд ашиглалтад оруулж горим ажиллагаанд холбосон. Төлөвлөгөөний дагуу турбоагрегат №2-ыг шинэчлэх ажлыг 2020 онд хийж дуусгасан бөгөөд турбоагрегат №3-ын шинэчлэх ажил дуусаж, 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр сүлжээнд залгав. Төсөл хэрэгжсэнээр цахилгааны нийлбэр хүчин чадал 89 МВт-аар, дулааны нийлбэр хүчин чадал 75

					Гкал/ц-аар нэмэгдэж, уурын турбинуудын АҮК 3 хувиар нэмэгдэж, жилд 20000 орчим тонн жишмэл түлш, нүүрс хэмнэх юм.		
			Амгалангийн дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц болгон өргөтгөх барилгын ажлын явц, хувиар	30.0	-	Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор "Амгалан дулааны станц" төрийн өмчит хувьцаат компани болгон бүтэц, зохион байгуулалтыг өөрчилсөн. Бие даасан төрийн өмчит компани болсноос эхлэн Хөгжлийн банканд зээлийн судалгаа хийгдэж байна.	
6.2	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.2, 4.1.1.1 дэх заалт, ЗГҮАХ-ийн 2.98 дахь заалт	Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвэртэй байдал, өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих	Тавантолгойн 300 МВт-ын цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар	10.0	-	"Оюутолгой" ХХК-иас 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын Засгийн газар "Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээ"-гээр хүлээсэн үүргээ хугацаандаа хэрэгжүүлээгүй тул нөөц хувилбар буюу 7.4 б-д заалтыг хэрэгжүүлэх талаар мэдэгдэл ирүүлсэн. 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Оюутолгой ХХК төслийн техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яаманд ирүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар Оюутолгой төслийн талаар хэлэлцээд, 74 дүгээр тогтоолоор эрчим хүчний асуудлаар өмнө нь ажиллаж байсан Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах, хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээр хийхийг үүрэг болгосон. Мөн "М-Си-Эс" ХХК тэргүүтэй дотоодын компаниудаас Тавантолгойд нүүрсээр галладаг цахилгаан станц барих санал ирүүлснийг Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Энэхүү хуралдааны 22 дугаар тэмдэглэлд, Тавантолгой цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд өмнөх гэрээ хэлэлцээр бусад эрхийн актуудыг нягтлан дахин хэлэлцэхээр шийдвэрлэсний дагуу ажиллаж, улмаар 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанд станцыг төрийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах саналыг танилцуулсан. Тавантолгой цахилгаан станцыг төрийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулахаар Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 124 дүгээр тогтоол гарсантай холбоотойгоор Төрийн өмчийн "Тавантолгойн цахилгаан станц" ХХК байгуулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Түүнчлэн, Засгийн газрын 2020 оны 05 дугаар	30



			<p>БАНГУУРЫН 700 МВТ ын дулааны цахилгаан станц барих төслийн барилгын ажлын явц, хувиар</p>	25.0	-	<p>сарын 13-ны өдрийн 31 дүгээр тэмдэглэлээр Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээг сунгах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах эрхийг Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор Эрчим хүчний сайд, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга нарт олгосон болно. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар ТТДЦС ТӨХХК-ийн хувь эзэмшлийн асуудлыг шийдвэрлэж, ЭТТ ХК-д 30 хувийг эзэмшүүлэх замаар хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр болсон. Төсөл хэрэгжүүлэх загвар өөрчлөгдсөн тул барилга угсралтын ажил эхлээгүй байна.</p> <p>Төслийн барилга угсралтын ажил 2017 онд эхэлж, станцын яндангийн суурийн цутгалт хийгдсэн, мөн ажилчдын түр байр, түүний дэд бүтцийн барилгын ажлууд хийгдсэн. Олон нийт, ТББ-уудаас удаа дараа шаардсаны дагуу ҮАБЗ-өөс төслийг түр зогсоосон. Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд "Багануурын цахилгаан станц төсөл"-ийн концессын гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг танилцуулсан. Үүний дагуу Багануурын станцын концесс эзэмшигч компанитай концессын гэрээнд өөрчлөлт оруулах хэлцэл хийхээр ажиллаж байна. Төслийн нэгжийн хүчин чадлыг бууруулах Монголын талын шаардлагын дагуу суурилагдсан хүчин чадлыг бууруулахгүйгээр нэгж агрегатын хүчин чадлыг бууруулан 2*200МВт+300МВт болгосон Техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн зөвшилцсөн. Улмаар "Багануурын цахилгаан станц төсөл"-ийг хэрэгжүүлэх (барих-ашиглах-шилжүүлэх) концессын гэрээнд 2 дугаар нэмэлт гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай" асуудлыг Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанд танилцуулан тооцоо, судалгааг нарийвчлан хийх үүрэг хүлээсний дагуу Концессын гэрээний дагалдах Цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээнд өөрчлөлт оруулж, диспетчерийн зохицуулалтад оруулах асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж, гэрээний өөрчлөлтийг тохирсон. Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А86 дугаар тушаалаар Багануурын цахилгаан станцын төслийн концессын 2 дугаар нэмэлт гэрээнд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдаж, 2020 оны 1 дүгээр сарын 18-наас 12 дугаар сарын 11-ний өдрүүдэд концессын гэрээний нэмэлт өөрчлөлтийг харилцан тохиролцож, улмаар</p>
--	--	--	--	------	---	---

				Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ажиллаж байна.
	Баруун бүсэд 60 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийн барилгын ажлын явц, хувиар	20.0	-	<p>Баруун бүсэд дулааны цахилгаан станцыг барих хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөлөгчид БНХАУ-д ажиллаж "Тэлмэний дулааны цахилгаан станц" төслийн хөрөнгө оруулагч Blue Ocean Corporate Services Limited компани, зээлийн даатгагч SINOSURE корпорац, хөрөнгө оруулалтын зуучлагч Хятадын үйлдвэр худалдааны банк (ICBC), барилгын ажлын гүйцэтгэгч Электрик компани болон Шинэ Азиа группын албаны хүмүүстэй ажил хэргийн уулзалт хийж, төслийн санхүүгийн хаалтын гэрээний талаар санал солилцсон.</p> <p>2018 оны 04 дүгээр сард БНХАУ-ын Хэнань мужийн Шэньюань Электрик компанигай Тэлмэний дулааны цахилгаан станцын төслийн санхүүжилт гүйцэтгэлийн гэрээг байгуулсан. Тус компани Монгол Улсад барилгын ажил явуулах зөвшөөрлийг Хятадын хилийн чанадад барилгын ажил эрхлэх нийгэмлэгээс авсан.</p> <p>БНХАУ-ын экспортын зээлийн даатгалын корпорац уг төсөлд зээлийн даатгал хийх тухайгаа Монгол Улсын Үндэсний хөгжлийн газарт мэдэгдсэн. Хөгжлийн банкнаас санхүүжилтийн баталгаа хүлээгдэж байгаа бөгөөд санхүүжилтийн бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.</p> <p>Үндэсний хөгжлийн газарт "Тэлмэний дулааны цахилгаан станц" төслийн концессын гэрээний нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банк төслийг бодлогын хувьд дэмжиж байгаа болно.</p>
	Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх ажлын санхүүжилтийг шийдвэрлэх ажлын явц, хувиар	100.0	-	"Багануур"ХК, "Шивээ-Овоо" ХК-ийн үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн ажиллагааг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны "Экспортын зээлийн шугам нээх төсөл"-ийн зээлийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.
	Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх ажлын санхүүжилтийг шийдвэрлэх	100.0	-	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3.-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болохоор заасны дагуу хамтран зээлдэгч болох "Эрдэнэс Монгол" ХХК Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк

			ажлын явц, хувиар			/JBIC/-ны зээлийн санхүүжилтээр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулахаар үнэлгээний хороог байгуулж тендерийн баримт бичгийг боловсруулж, сонгон шалгаруулалтыг хийсэн бөгөөд техник нийлүүлэгчээр "Трансвест" ХХК шалгарсан. "Багануур", "Шивээ-Овоо" ХК-иудад зээлийн хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэж, угсралт хийгдсэн.	
6.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 4.1.1.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.99 дэх заалт	Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх	Төслийн гэрээ, хэлэлцээрийн ажлын явц, хувиар	100.0	-	Шивээ-Овоогийн нүүрсний орд газрыг түшиглэсэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай, станцын усан хангамжийн "Шивээ-Энержи" цогцолбор төслийн ТЭЗҮ-ийн Монгол Улс дахь дэд станц, цахилгаан дамжуулах шугамын судалгааны ажлын хүрээнд БНХАУ-ын Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компани дараах байгууллагуудтай хамтран ажилласан. Үүнд: Станцын усан хангамжийн ТЭЗҮ-ийг "Өвөр Монголын ус ашиглалт, усан цахилгаан станцын судалгаа төлөвлөлтийн хүрээлэн", цахилгаан станцын ТЭЗҮ-ийг "Шандунь эрчим хүчний инженеринг консалтинг институт", нүүрсний уурхайн ТЭЗҮ-ийг "Нүүрсний технологи, инженеринг группын Шен Янь төлөвлөлт судалгааны хүрээлэн", дамжуулах шугамын ТЭЗҮ-ийг тус компани өөрөө хариуцаж хийсэн. Төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авч Эрчим хүчний сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай, усан хангамжийн талаар өөр өөр институтуудын боловсруулсан тус ТЭЗҮ-үүдийг судлан үзээд ТЭЗҮ тус бүрт шүүмж өгсөн.	30
						Хашаат цавын уурхай дээр 3000 МВт-ын экспортын зориулалттай цахилгаан станц барих тусгай зөвшөөрөл авсан "Би Эс Юу" ХХК-д төслийн ажлын хүрээнд дэмжлэг үзүүлэн ажилласан. Тус компани нь төслийн ажлыг 3 үе шаттайгаар нийтдээ 10 жилийн хугацаанд барьж байгуулахаар төлөвлөж байгаагаа мэдэгдсэн. Эрчим хүчний яамнаас БНХАУ-ын холбогдох эрх бүхий байгууллагатай цахилгаан эрчим хүч нийлүүлэх, Монголоос экспортлох талаар гэрээгээ байгуулж, хариу мэдэгдэх чиглэлийг өгч ажилласан. Энэхүү төсөл нь БНХАУ-ын 13 дугаар таван жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, ирээдүйд судалж үзэх боломжтой төсөл гэж үзсэн.	

6.4	МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 2, ТЭХТББ-ын 3.2.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.100 дахь заалт	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх	Эгийн голын 315 МВт-ын усан цахилгаан станц барих төслийн биологийн олон янз байдлын судалгааг хийх ажлын явц, хувиар	100.0	-	Концесс эзэмшигч Чайна Гежуба групп лимитед компани Эгийн голын УЦС, түүний дэд бүтцийг барихаа илэрхийлж байсан бөгөөд Монгол Улсад концессын санхүүжилт хийх зөвшөөрөл авахаар БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороонд хандсан, тус хорооноос төслийн талаар ОХУ-тай нэгдмэл ойлголтод хүрэх хүртэл концессын санхүүжилт хийхийг түр зогсоосон. Засгийн газрын 2017 оны 117 дугаар тогтоолоор "Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн нэгжийг "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулсан. Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй тул судалгааны ажил хийгдээгүй.	30
			Эрдэнэбүрэнгийн 64 МВт-ын усан цахилгаан станцын санхүүжилтийг шийдвэрлэх ажлын явц, хувиар	100.0	-	2020 онд төслийн бэлтгэл ажлын хүрээнд 35кВ - ын ЦДАШ болон 35/10 кВ дэд станцын техникийн нөхцөл гаргуулж, төслийн талбайн инженер-геологийн судалгааны ажлын тайланд эксперт магадлалын дүгнэлт гаргуулсан. Эрчим хүчний зохицуулах хорооноос Төсөл хэрэгжүүлэх нэгжид Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл олгосон. Улсын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх, ЭБУЦС барих төслийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ хийх тендерийг зохион байгуулах ажлууд хийгдэж байна. 2020 оны 06 дугаар сард Улсын тусгай хэрэгцээний Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цэгт газрын хил заагийг тэмдэгжүүлж, эргэлтийн цэгийг газарт бэхлэн Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Увс аймгийн Өмнеговь сум, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Ховд аймгийн Мянгад, Эрдэнэбүрэн сумын газрын албанд акт үйлдэн хүлээлгэн өгөв. Барилга, хот байгуулалтын яамны 2020/0006 тоот Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх хүрээнд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, Газрын нөхөн сэргээлт ажлын төрлөөр мэргэжлийн байгууллагын эрх"-ийн тусгай зөвшөөрөл бүхий "Бест гео ланд" ХХК-ийг харьцуулалтын аргаар шалгаруулан төслийн нэгжийн хамт ажил гүйцэтгэх үе шатны төлөвлөгөөг боловсруулан улсын тусгай хэрэгцээний 28000 га газарт хээрийн судалгааны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.	



			Баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх төслийн барилгын ажлын явц, хувиар	30.0	1.0 Гадаад эх үүсвэр	<p>Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 40.5 МВт суурилуулсан чадалтай сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг баруун бүсэд 2019-2023 оны 5 жилийн хугацаанд барьж байгуулах юм. Төслийн хэрэгжилтийн явц 2020 оны жилийн эцсийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Увсын Өмнөговь 10 МВт СЦС Төслийн талбай дээр салхины ЭХ-ийг хэмжих хэмжилт болон нүүдлийн шувууны судалгаа хийгдэж байна. Тендер зарлах бэлтгэл хангагдсан. Шувууны судалгааны дүгнэлтийг АХБ зөвшөөрснөөр тендер зарлах нөхцөл бүрдэнэ.</li> <li>• Говь-Алтай, Есөнбулаг 10 МВт НЦС: Тендер шалгаруулалтын шатанд хэрэгжиж байна. Тендерийг 2 дахь удаагаа зарласан. Тендерийг 2020 оны 12 дугаар сарын 11-нд хүлээн авсан. 2021 оны 01 дүгээр улиралд эхлүүлнэ.</li> <li>• Говь-Алтай, Алтай суманд 300 кВт-ын НЦС: Тендерийн материалыг шинэчилж, хянуулахаар АХБ-нд хүргүүлсэн. Тендерийг 12-р сарын 11-нд зарласан. 2021 оны 01-р сарын 25-нд тендерийг хүлээж авна.</li> <li>• Завхан, Улиастай 5 МВт НЦС: Гэрээний хэлцлийн шатанд байна. Тендерийн хүчинтэй хугацаа буюу 2021 оны 01-р сарын 08-нд багтааж гэрээг байгуулахаар ажиллаж байна.</li> <li>• Завхан, Тэлмэн 5 МВт СЦС: Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах шатанд байна. Салхины эрчим хүчний хэмжилтийг хийх хэмжилтийн багажны худалдан авалтыг хийсэн, суурилуулалт, хэмжилт хийх ажил цар тахлаас улмаас хойшлоод байна. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг 2020 оны 11 сард эхлүүлсэн, нүүдлийн шувууны судалгаа хийгдэж байна. ТЭЗҮ-ийг салхины эрчим хүчний хэмжилттэй уялдуулан тодотгоно.</li> <li>• Хөвсгөл, Мөрөн 10 МВт-ын НЦС: Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах шатанд байна. ТЭЗҮ-ийг ШУТЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. ТЭЗҮ дэмжигдсэн тул тендерийн бичиг баримтыг бүрдүүлж, 2021 оны 1 дүгээр улиралд тендер зарлана.</li> <li>• Нийлбэр хүчин чадал нь 0.5 МВт бүхий газрын гүний дулааны насосны 5 төсөл хэрэгжүүлэхээс Ховдын Жаргалантад БУА 80 хувьтай, бусад 4 байршилд газрын гүний өрөмдлөг, ТЭЗҮ-ийн нарийвчилсан судалгаанууд хийгдэж байна. Цар тахлын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн төслийн тендер шалгаруулалтын хугацаа хойшилсон.</li> </ul>
--	--	--	---	------	-------------------------	---

			<p>Улаанбаатар хот орчимд 100 МВт хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар</p>	10.0	-	<p>Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг "Морьт Импекс" ХХК 100МВт-ын чадалтай усан цэнэгт станц байгуулахаар төлөвлөж ирсэн боловч уг компани төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрээ шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаагаас уг төсөл удааширч байна. Эрчим хүчний яамны зүгээс 100 МВт-ын хүчин чадалтай Усан цэнэгт цахилгаан станц барьж байгуулах боломжтой газруудын талаарх урьдчилсан судалгааны ажлыг хийж Хэрлэн голд 3, Ерөө голд 1, Орхон голд 1 байршлыг тус тус илрүүлж, урьдчилсан тооцоо, судалгааны дүнд Дэлхийн банктэй хамтран Хэрлэн голд Усан цэнэгт цахилгаан станц барих байрлалыг олох, ТЭЗҮ хийх төсөл хэрэгжүүлэхээр тохиролцож судалгааны ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. "Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц" ХХК-ийн барихаар төлөвлөж буй 100МВт-ын хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэлийг насос-турбин хосолсон үр ашигтай тоног, төхөөрөмжөөр техник эдийн засгийн үндэслэлийг баяжуулж, шинэчлэх шаардлага тавин ажилласан. "Сан хидро" ХХК Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэр, Майхан ууланд 75 МВт-ын хүчин чадалтай Усан цэнэгт цахилгаан станц барьж байгуулах ТЭЗҮ-ийг Эрчим хүчний салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын хурлаар хэлэлцэн дэмжсэн. Тус компанид эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл олгох асуудлыг судалж шийдвэрлэх асуудлыг Эрчим хүчний зохицуулах хороонд, УЦС-ын газрын асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг НЗДТГ-т тус тус уламжилсан. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг, Хэрлэн голын эрэгт барихаар төлөвлөж буй 45 МВт-ын хүчин чадалтай ус хуримтлуурт цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэгч "Эрдэнэс пауэр" ХХК-д эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг олгох тухай зөвлөмжийг ЭХЗХ-нд өгсөн. Орхон аймгийн Баян-Өндөр суманд барихаар төлөвлөж буй "Эрдэнэт усан цэнэгт цахилгаан станц" ХХК-ийн 50МВт-ын хүчин чадалтай станцын төслийг хэрэгжүүлэхэд дэмжиж ажилласан.</p>
--	--	--	---	------	---	--

			Бага орлоготой малчин өрхөд 100 МВт нарны цахилгаан үүсгүүрийг хөнгөлөлттэй үнээр олгох төслийн санхүүжилтийг шийдвэрлэх ажлын явц, хувиар	100.0	-	Төв Азийн бүсийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа төслийн хүрээнд Азийн хөгжлийн банктай хамтран ажиллаж, тус банкны буцалтгүй тусламжаар Нарны эх үүсвэр бүхий гэр ахуйн цахилгаан хэрэгслийн иж бүрдлийг тус хөтөлбөрийн гишүүн орнуудад загвар төсөл болгон нийлүүлэх төсөлд Монгол Улсыг хамруулах шийдвэр гарсан. Азийн хөгжлийн банкны зүгээс Монгол Улсад малчин өрхийг нарны цахилгаан эх үүсгүүрээр хангах төсөл өмнө нь амжилттай хэрэгжсэн тул энэ удаад Төв Азийн бүсийн бусад орнуудад эхний ээлжид хэрэгжүүлэхээр болж, энэхүү төсөлд хамрагдах Монгол Улсын дараалал хойшлогдож, уг арга хэмжээ хэзээ хэрэгжих нь тодорхойгүй байна.	
6.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.6, 3.2.5.3, 4.1.1.5, ЗГҮАХ-ийн 2.101 дэх заалт	Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг эхлүүлэх	220 кВ-ын "Багануур" дэд станцаас "Чойр" хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 178 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, Багануур дэд станцыг өргөтгөх төслийн санхүүжилтийг шийдвэрлэх ажлын явц, хувиар	100.0	-	220 кВ-ын Багануур дэд станцаас Чойр хүртэл 220 кВ-ын хоёр хэлхээт 178 км ЦДАШ барих, дэд станц өргөтгөх ажлын хөрөнгө оруулалтыг Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Сангийн яам хооронд байгуулсан 300 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх боломжийг судлан, дэмжиж өгөх тухай албан тоотыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээд байна.	30
			Багануур-Өндөрхааны 2 хэлхээт 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Өндөрхаан 220 кВ-ын дэд станцуудыг барих төслийн санхүүжилтийг шийдвэрлэх ажлын явц,	100.0	-	Багануур-Өндөрхаан чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт 202.4 км ЦДАШ, дэд станц барих ТЭЗҮ-ийг боловсруулан салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн, дэмжсэн. Төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын "Эдийн засгийн коридор"-ын төсөл, хөтөлбөрийн жагсаалтад оруулсан. Мөн Концессын зүйлийн жагсаалтад тусгахаар саналаа Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Сангийн яам хооронд байгуулсан 300 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх боломжийг судлан дэмжиж өгөх тухай албан тоотыг холбогдох байгууллагад хүргүүлээд байна.	

			хувиар			
			Тайшир-Есөнбулагийн 110кВ-ын 50 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам, Есөнбулаг дэд станц барих төслийн барилга угсралтын ажлын явц, хувиар	100.0	-	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 388 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалт"-д Эрчим хүчний сайдын багцаас Тайширын УЦС-аас аймгийн төв уруу татах 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээ тусгагдсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 онд уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан боловч тендерт оролцогчдоос маргаан үүсэж, шүүхэд шилжсэн ба шүүхийн маргаан 4 дүгээр улиралд эцэслэгдсэнээр төрийн худалдан авах ажиллагааны газраас дахин нээлттэй төндөрийг 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зарласан. Шүүхийн маргаанаас үүдэн уг төслийн хэрэгжилт хойшилсон.
			Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, Айраг, Сайншандын 220 кВ-ын дэд станц барих төслийн зураг төслийг хийж гүйцэтгэх ажлын явц, хувиар	100.0	-	Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын "Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр"-т хоёр тал 2019 оны 04 дүгээр сард гарын үсэг зурсан бөгөөд энэхүү хэлэлцээрийн 300 сая ам.долларын санхүүгийн эх үүсвэрээс Чойр-Сайншандын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийг санхүүжүүлэх асуудлыг Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Европын сэргээн босголт хөгжлийн банктай төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна. Тус банкнаас зөвлөхийг сонгон шалгаруулж, Чойр-Сайншандын 220 кВ-ын ЦДАШ, 220 кВ-ын дэд станцын техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн судалгааг хийлгэж байна. Мөн Техникийн туслалцааны хүрээнд төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэхээр зөвлөхийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулаад байна. Чойр-Сайншандын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зураг төслийн ажлыг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-иас зохион байгуулж, хийж гүйцэтгэсэн.



			220 кВ-ын Дархан дэд станцыг өргөтгөх, шинэчлэх төслийн барилга угсралтын ажлын явц, хувиар	20.0	-	Монгол, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн хүрээнд Дархан дэд станцын 220, 110 кВ-ын хуучирсан ашиглалтын хугацаа хэтэрсэн реле хамгаалалт, автоматик, хяналт, удирдлагын систем (НМ/SCMS)-г шинэчлэхээр төлөвлөөд байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжийг 2020 оны 03 дугаар сард байгуулсан. Төслийн гадаад зөвлөх багийг сонгон шалгаруулах Зөвлөх үйлчилгээний тендерийг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ХБНГУ болон Монгол Улсад нэгэн зэрэг олон улсын нээлттэй тендер зарласан. Дэлхий дахиныг хамарсан цар тахлын улмаас тендерийн материалыг хүлээн авах хугацааг 3 удаа сунган 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр дуусгавар болгон хааж, тендерийн үнэлгээний ажлыг 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлээд байна. Эхний шатны тендерд 10 компани санал ирүүлснээс хураангуй жагсаалтад 3 компанийг сонгон хоёр дахь шатны тендерийг 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зарлаж, 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нээсэн, үнэлгээ хийгдэж байна.
			Төвийн бүсийн дамжуулах сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн барилга угсралтын ажлын явц, хувиар	20.0	-	Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын 2014 оны 9 дүгээр сарын хэлэлцээрийн дагуу "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл"-ийн санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, зээлийн болон төслийн гэрээг соёрхон батлах тухай хуулийг УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан. ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/08 тоот тушаалаар төслийн гадаад зөвлөх багийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог, Эрчим хүчний сайдын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 35 тоот тушаалаар Төслийн удирдах хороог тус тус байгуулсан. "ЦДҮС" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор "ЦДҮС" ТӨХК дээр байгуулах Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог баталсан. "ЦДҮС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/03 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг "Төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийн төслийн зохицуулагч, төслийн ахлах инженер, төслийн инженер, худалдан авах болон санхүүгийн ажилтны албан тушаалын ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулж, 2020 оны 03 дугаар сараас эхлэн томилсноор

						төслийн нэгжийн үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн. Төслийн гадаад зөвлөх багийг сонгон шалгаруулах Зөвлөх үйлчилгээний төндөрийг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ХБНГУ болон Монгол Улсад нэгэн зэрэг олон улсын нээлттэй төндөр зарласан. Дэлхий дахиныг хамарсан коронавирусын цар тахлын улмаас төндөрийн материалыг хүлээн авах хугацааг 3 удаа сунган 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр дуусгавар болгон хааж, төндөрийн үнэлгээний ажлыг 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлсэн. Төслийн "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-г Сангийн яам, Эрчим хүчний яам болон "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн хооронд 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан.	
6.6	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.1.4 дэх заалт, ЗГҮАХ-ийн 2.102 дахь заалт	Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Аймгийн төвүүдийн дулааны станцын барилгын ажлын явц, хувиар	30.0	7.6	Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын "Экспорт-Импорт банк"-ны хооронд 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан. Зээлийн хэлэлцээрийн Хавсралт С-д заасан төсөл хэрэгжүүлэх хуваарьт төслийн барилга угсралтын ажил 2020 оны 3 дугаар сард эхлэхээр төлөвлөгдсөн. Зөвлөх үйлчилгээний "KDHEC" (Korea District Heating Engineering Co.) түншлэл 2019 онд төслийн ерөнхий зураг төслийг боловсруулсан бөгөөд цаашид барилга угсралтын ажлын явцад хяналт тавина. ЭХЯ-наас Зөвлөхтэй хамтран 10 аймгийн төвд ТЭЗҮ-д тусгагдсан төсөл хэрэгжих газар, дулаан дамжуулах шугам сүлжээний трасс, дулааны станц, дулаан дамжуулах төвийг дэд бүтцэд холбох боломжийг газар дээр нь нягталж ажлын эзлэхүүн, ашиглагдах технологи, зураг төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг /design criteria/ зөвшилцөж, баталгаажуулав. Дулааны станц, дулаан дамжуулах төвүүд баригдах газар эзэмших гэрчилгээг аймгуудаар гаргуулах, шинэчлэх ажлыг зохион байгуулав. Шинээр баригдах дулааны станц, дулааны шугам сүлжээний барилгажилтын төлөвлөгөөг аймгуудын Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зөвшилцөж батлуулав. Дулааны станцад ашиглах цахилгааны техникийн нөхцөл, зургийн даалгавруудыг боловсруулав. Дулааны станц, дулаан дамжуулах төвүүдийг холбоо мэдээлэл, цэвэр ус, түр болон байнгын цахилгаан хангамж, ариутгах татуургын системд холбох техникийн нөхцөлүүдийг холбогдох байгууллагуудаар гаргуулав. 2020 онд хэрэгжүүлэх Байгаль орчны мөнөжмөнтийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газраар хянуулж, батлуулав. Одоогийн дулаан хангамж хариуцсан зарим компанитай маргаантай асуудлыг шийдвэрлэх	30

					<p>чиглэлээр ажиллаж байна. Төслийн Зээлийн гэрээнд заасны дагуу барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг БНСУ-ын компаниудын дунд 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр 60 хоногийн хугацаатай зарласан боловч хорио цээрийн дэглэмийн улмаас тендер нээх хугацаа 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл сунгагдсан. Монгол Улсад тендерийг хүлээн авах боломжгүй байсан тул БНСУ-ын "Экспорт-Импорт" банканд компаниудын тендерийн материалыг 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авч, Үнэлгээний хороонд цахим хувилбарыг ирүүлэхээр зохион байгуулсан боловч, дурдсан хугацаанд тендерийн материал ирүүлээгүй. Тендер амжилтгүй болсон шалтгааныг судлан үзэхэд Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаа хэт богино, улс орнуудад тогтоосон хөл хорионы улмаас төсөл хэрэгжүүлэх талбайтай танилцах боломж байгаагүйгээс төслийн технологи сонгох, үнийн санал гаргах боломжгүй, тоног төхөөрөмж худалдан авах компаниудтай гэрээ хэлцэл хийх боломжгүй, хөл хорионы дэглэм цаашид хэр удаан үргэлжлэх нь тодорхойгүй тул барилга угсралтын ажлыг хэзээ эхлүүлэх нь тодорхойгүй гэж үзсэн байна. 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр 30 хоногийн нээлттэй тендерийг дахин зарлаад байна. БНСУ-ын "Экспорт-Импорт" банк 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дахин тендер зарлах зөвшөөрөл ирүүлсний дагуу тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлтүүдийг оруулан боловсруулж байна.</p>
		Улаанбаатар, Багануур, Эрдэнэт болон бусад хотуудын дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл хийх ажлын явц, хувиар	100.0	1.8 Улсын төсөв	<p>Халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хүрээнд Улаанбаатарын дулааны 7И магистралийн 3.7 км Ф700 мм голчтой шугамын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй. Дулааны 4-р цахилгаан станцаас Яармагийн гэр хороолол дундуур шинэ төлөвлөлтийн бүс рүү Ф600 мм голчтой 1,2 хос.км 3,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий дулааны магистраль шугам шинээр татаж ашиглалтад оруулсан. Дорноговь аймгийн дулааны станцын зуух шугам сүлжээний шинэчлэлт төсөл арга хэмжээний Багц-1: Зуухны шинэчлэлт, Багц-2: Дөрвөн дулаан дамжуулах төвийн барилга, тоноглолын ажил хийгдэж 2020 онд ашиглалтад орсон. Мөн Дархан-Уул аймгийн төв Дархан сумын 5,6,7,8 дугаар багийн нутаг дэвсгэрт гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн инженерийн хангамжтай болгох төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 16 ус, дулаан дамжуулах төв, 1 насос станц, халаалт халуун усны нийт 11.2 хос км шугамын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай, он</p>



				<p>дамжин хэрэгжинэ. Дархан сумын 13 дугаар багийн гадна дулаан хангамжийг шинэчлэх ажил 100 хувь гүйцэтгэгдсэн. Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт хөгжлийн банктэй байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Улаанбаатарын дулаан хангамж” төслийг санхүүжүүлэхээр зээлийн 10 сая ам.долларын тусгайлсан гэрээнд 2020 оны 01 дүгээр сарын 10-ний өдөр гарын үсэг зурагдсан. 2020 онд Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсан. Төслийн зөвлөхийг сонгон шалгаруулах төндөрийг ЕСБХБ-тай зөвшилцсөнөөр олон улсын нээлттэй төндөрийг зарласан, санхүүгийн саналын үнэлгээний тайланг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Европын сэргээн босголт хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны цахим системд илгээсэн. Төслийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх барилга угсралтын ажлын төлөвлөгөөг гаргаж банктэй зөвшилцсөн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төндөрийг 2021 оны 2 дугаар сард зарлаж, ажлыг 2021 оны хоёрдугаар улиралд эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p>Дэлхийн банкны санхүүжилтээр дулааны 5А, 3 дугаар магистралуудыг өргөтгөн шинэчлэх төслийг эхлүүлж, зээлийн гэрээг 2020 оны 04 дүгээр сард Улсын Их хурлаар соёрхон батлуулсан. Төсөл хэрэгжүүлэх нэгж болон Төслийн удирдах хороог 2020 оны 11, 12 дугаар сард байгуулан төслийг албан ёсоор эхлүүлээд байна.</p>
	Хот суурин газрын 0.4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх айл өрхийн тоо	20000	5.8 Улсын төсөв	<p>“Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт” төсөл арга хэмжээний хүрээнд нийт 17 багцын барилга угсралтын ажил гүйцэтгэж, улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан.</p> <p>“Сумдын 0.4, 0.22 кВ-ын модон тулгууртай цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон тулгууртай СИП утсаар солих, дэд станцын өргөтгөл” төсөл арга хэмжээний хүрээнд 6 багцад хуваан төндөр шалгаруулалтыг явуулсан. Дээрх 6 багцын барилга угсралтын ажил бүрэн дуусаж, улсын комисс ажилласан. Дэлхийн банкны хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд Булган аймгийн төвийн 10-0.4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, Архангай аймгийн төвийн 10-0.4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, Говьсүмбэр аймгийн төвийн 6-0.4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх ажлуудын дэд станц, шугам сүлжээний ажлууд бүрэн хийгдсэн. Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн хүрээнд нийт 17 аймгийн 100 гаруй сум суурин газарт 22000 гаруй айл өрхийн цахилгаан</p>



						хангамжийг дээшлүүлсэн.	
6.7	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.5.3 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.103.1 дэх заалт	Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд холбох ажлын хүрээнд цахилгаан түгээх сүлжээнд ухаалаг төхөөрөмж, тоолуур нэвтрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Хот суурин газрын цахилгаан түгээх сүлжээнд ухаалаг төхөөрөмж, тоолуур нэвтрүүлэх ажлыг Дэлхийн банкны Эрчим хүчний төсөл-2-ын хүрээнд хэрэгжүүлж байна. 1 фаз ба 3 фазын ухаалаг тоолуур, өгөгдөл цуглуулагч, гүйдлийн трансформатор, программ хангамжуудыг нийлүүлэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2019 онд зарлан нээлтийг хийсэн боловч Улсын нууцад хамааралтай гэсэн үндэслэлээр тагнуулын байгууллагаас үнэлгээний ажлыг түр зогсоосон. Улмаар үнэлгээний ажил эхлэх зөвшөөрлийг тагнуулын байгууллагаас 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр өгсөн. Дээрх шалтгаан болон цар тахлын үеийн онцгой байдал зарласантай холбогдуулан Тендерийн үнэлгээний ажил хугацаа хоцорсон тул тендерийн хүчинтэй хугацааг Дэлхийн банкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр 2 удаа 90 болон 45 хоногоор тус тус сунгасан. "ЕСМ" ХХК-тай хийсэн гэрээний дагуу борлуулалт, арилжааны программ нэвтрүүлж, түгээх сүлжээний шинэчлэлттэй уялдуулан ухаалаг тоолуурыг үе шаттайгаар нийлүүлж эхэлсэн.	70
6.8	ТЭХТББ-ын 3.2.5.2, 3.2.5.3 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.103.1, 2.104.5, 2.104.6, 2.104.10 дахь заалт	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, цахилгаан түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт хийх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, алдагдлыг бууруулах, шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Багануур, эүүн өмнөд бүс, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	50.0	2.4 Гадаад эх үүсвэр	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээний шинэчлэл, Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээний шинэчлэл, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Хэнтийн шугам сүлжээг шинэчлэх ажил, Баруун бүсийн эрчим хүчний систем Мянгад 10 МВт-ын нарны станц, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний алдагдлыг бууруулах, ухаалаг тоолуур суурилуулах, ухаалаг тоолуур, борлуулалтын нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх ажил хийгдэж байна. Борлуулалт, арилжааны программ нэвтрүүлэх ажлын хувьд "ЕСМ" ХХК-тай хийсэн гэрээний дагуу программыг нийлүүлж, хэрэгжүүлж, хүлээн авсан. Орхон, Булган, Өвөрхангай, Хархорин, Архангай салбаруудад мэдээллийн бааз хөрвүүлж сургалт хийгдэх ажлын гүйцэтгэл 85 хувь болж борлуулалтын үйл ажиллагаа шинэ бүтцээр ажиллах боломж бүрдсэн. Төслийн барилга угсралтын ажлуудаас Говьсүмбэр аймгийн төвийн шугам сүлжээг шинэчлэх ажил 92.7 хувь, Багануур дүүргийн шугам сүлжээг шинэчлэх ажил 89.0 хувь, Өвөршандын 35/10кВ-ын 10 МВА дэд станцын барилга угсралтын ажил 100 хувь, Булган аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 84.4 хувь; Архангай аймгийн төвийн шугам сүлжээний шинэчлэлт 86.4 хувь; Эрдэнэтийн 35/6кВ-ын	100

						2*10 МВА дэд станц 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Булган, Архангай, Говьсүмбэр аймгийн төвүүдийн цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлууд тоолуур суурилуулалтаас бусад ажил хийгдэж дууссан. Ухаалаг тоолуурын тендерийн ажил хоцорч байгаагаас шалтгаалан гэрээг сунгах шаардлага гарсан. Өвөрхангай, Хархорин, Дундговь, Дорноговь аймгийн Сайншанд, Замын Үүд сумдын гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж, хэлэлцээр хийгдэж дууссан. Ховд аймгийн Мянгад суманд барих 110/35/6 КВ-ын 2*25МВА "Мянгад" дэд станцын өргөтгөл шинэчлэлт ажил бүрэн дууссан, гүйцэтгэл 100 хувь, 10 МВ-ын нарны станцын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулаад байна.	
6.9	ТЭХТББ-ын 4.1.1.6 дахь заалт	Гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуурт шилжих боломжийг бүрдүүлэх, шөнийн хөнгөлөлттэй тарифыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд агаарын чанарыг сайжруулах 1 ба 3-р бүсэд байрлах Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн айл өрхийг цахилгаан халаагуурт шилжүүлэх ажлыг 2 ээлжээр зохион байгуулж, нийт 52 багц ажлыг бүрэн ашиглалтад оруулснаар гэр хорооллын 41,964 айл өрхийг 4 кВт-ын чадалтай цахилгаан халаагуур хэрэглэх техникийн боломжийг бүрдүүлэв. Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу Төв, Зүүн, Өмнөд, Баруун бүс болон Алтай Улиастайн бүсийн эрчим хүчний системийн нэгдсэн сүлжээнд холбогдсон тарифт тоолууртай, гэр хорооллын 139 орчим мянган айл өрхийн 2020 оны 1, 2, 3, 11, 12 дугаар саруудын оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цагт хэрэглэсэн цахилгааны тарифт хөнгөлөлт үзүүлэхээр заасны дагуу 2020 онд 12.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлдэг байна.	100
6.10	ТЭХТББ-ын 3.2.1.3 дахь заалт	Шөнийн цагаар эрчим хүч хуримтлуулж, оргил ачааллын цагаар нийлүүлэх зориулалттай 50-100 хүртэлх МВт-ын том чадлын цэнэг хураагуурын систем барих	Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын явц, хувиар	100.0	-	Азийн хөгжлийн банктэй байгуулсан санхүүжилтийн өрөнхий хөтөлбөрт 2020 оны 02 дугаар сард нэмэлт өөрчлөлтийг оруулж, УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганаар соёрхон батлуулсан. "Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл"-ийн зээлийн тусгайлсан гэрээнд 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан. Төслийн ТЭЗҮ, Байгаль орчны үнэлгээний болон бусад холбогдох тайлангууд хийгдэж батлагдсан. Төсөл хэрэгжих газрын эзэмшлийг шийдвэрлэсэн. 2020 оны 09 дүгээр сард төслийн бие даасан 2 зөвлөхийг нээлттэй сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, Төслийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах болон Түлхүүр хүлээлгэн өгөх	100

		төслийн бэлтгэл ажлыг хангах				гэрээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулсан ба төслийн зөвлөх компанийн сонгон шалгаруулалт хийгдэж байна. 2021 оны 03 дугаар сард гэрээ байгуулагдана. Түлхүүр хүлээлгэн өгөх гэрээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021 оны 02 дугаар сард зарлах ба гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажил 2021 оны 05 дугаар сард хийгдэж, барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.	
<b>Зорилт 7. Бүтээн байгуулалт, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн суурь дэд бүтэц, зам тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.</b>							
7.1	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ын 2.107, 2.121 дэх заалт	Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто зам, гүүрний сүлжээг өргөтгөн хөгжүүлэх	Шинээр ашиглалтад оруулах авто замын урт, км	301.1	88.9  Улсын төсөв,  86.8  Гадаад эх үүсвэр	-Ховд-Булган-Үенч чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг 10/01/20 дугаар дүгнэлтээр, -Баянгол дүүрэг 5 дугаар хороо Хорооллын доторх авто замыг 10/03/20 дугаар дүгнэлтээр, -Сонгинохайрхан дүүрэг 3, 26-р хороо Их нарангаас Халуун усны гудамж, Их нарангаас-Буяны зам хүртэлх 1.2 км хатуу хучилттай авто замыг 10/04/20 дугаар дүгнэлтээр, -Баянзүрх дүүрэг 11 хороо Туул зөрлөг орчмын автомашины нүхэн гарцыг 10/5/2020 дугаар дүгнэлтээр, -Орхон-Хишиг-Өндөр сум чиглэлийн хатуу хучилттай 12.82 км авто замыг 06/01/20 дугаар дүгнэлтээр, -Баянхонгор-Арвайхээр чиглэлийн авто замын огцом эргэлтийг өөрчлөх 4.4 км хатуу хучилттай авто замыг 10/07/20 дугаар дүгнэлтээр, -Гэр хорооллын дундах хатуу хучилттай авто зам, 1.3 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1, 2, 22 дугаар хороо/ авто замыг 06/05/20 дугаар дүгнэлтээр, -Хорооллын доторх зам тохижилтын ажил /УБ, Сонгинохайрхан дүүрэг/, /3.45 км хатуу хучилттай авто зам/, авто замыг 10/04/20 дугаар дүгнэлтээр, -Баян-өлгий, Өлгий сумын төвийн авто замыг 10/14/20, зогсоолыг 10/13/20 дугаар дүгнэлтээр, -Ховд, Жаргалант сумын төв 1,972 км авто замыг 06/06/20 дугаар дүгнэлтээр, -Хэнтий, Хэрлэн сумын төвийн авто замыг 52/2020 дугаар дүгнэлтээр, -Увс, Улаангом сумын 2.8 км авто замыг ашиглалтад авсан, дүгнэлт албажих шатанд, -Дархан, Шарын гол чиглэлийн 17.2 км авто замыг ашиглалтад авсан, дүгнэлт албажих шатанд,	70

					<p>-Өмнөговь, Ноён сумаас Сухайт чиглэлийн 20 км авто замыг 06/03/20 дугаар дүгнэлтээр,  -Сайншанд-Хамрын хийд чиглэлийн авто замаас Ханбаянзүрх хүртэлх 6.85 км авто замыг АЗ-05/2020 дугаар дүгнэлтээр,  -Хэнтий, Өмнөдэлгэр сумын 2.5 км авто замыг 06/14/20 дугаар дүгнэлтээр,  -Ховд, Цэцэг сумын 4.6 км авто замыг 01/2020 дугаар дүгнэлтээр,  -Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Мандал сум хүртэлх авто замтай холбох 28.7 км хатуу хучилттай авто замд орон нутгаас улсын комисс ажиллаж ашиглалтад авсан. Дүгнэлт албажих шатанд,  -Төв, Алтанбулаг сумын 13.7 км авто замыг замыг ашиглалтад авсан, дүгнэлт албажих шатанд,  -Хархорин, Цэцэрлэгээс сумын төв хүртэл 8.5 км авто замыг ЗТХЯ/11/2020 дугаар дүгнэлтээр,  -Наадамчдын гудамжнаас Яармаг хүртэл 0.8 км авто замыг 10/16/20 дугаар дүгнэлтээр,  -Хан-Уул дүүргийн 9-р хорооны 2.8 км авто замыг 10/12/20 дугаар дүгнэлтээр,  -Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын 30 км-ыг 10/10/20 дугаар дүгнэлтээр,  -Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын 66.7 км авто замд 2020.12.19-ний өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад авсан. Комиссын дүгнэлт албажих шатанд байна.  -Улаанбаатар паласын хойд талын үерийн далан дагасан авто замыг 3 дугаар эмнэлгийн арын замтай холбох хатуу хучилттай авто замын барилгын ажил 1.291 км /УБ хот, БГД, 6-р хороо/ авто замд 2020.12.21-ний өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад авсан. Комиссын дүгнэлт албажих шатанд байна.  -Хороодын дундах хатуу хучилттай авто зам, чулуун замын барилгын ажил 1.473 км / УБ хот, БЗД, 4, 5, 14-р хороо/ авто замд 2020.12.21-ний өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад авсан. Комиссын дүгнэлт албажих шатанд байна.  -Аймгийн төвийн авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Сүмбэр сум/ ашиглалтад оруулсан дугаар 01/20 дугаар дүгнэлтээр,  -Хүдэрийн замаас Ерөө сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.7 км /Сэлэнгэ, Ерөө сум/ авто замыг 2020.12.16-ны өдрийн 111/2020 дугаар дүгнэлтээр,  -Баруун босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км</p>
--	--	--	--	--	---



		<p>ХАРИУЦАГЧ ЭХЭВЭЛ ХАРИУЦАГЧ ЭХЭВЭЛ ХАРИУЦАГЧ ЭХЭВЭЛ ХАРИУЦАГЧ ЭХЭВЭЛ</p>	<p>ХАРИУЦАГЧ ЭХЭВЭЛ ХАРИУЦАГЧ ЭХЭВЭЛ</p>	<p>370</p>		<p>хатуу хучилттай авто замыг 10/11/20 дугаар дүгнэлтээр, Хороолол доторх авто замын засвар, 1.1 км /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо/ авто замыг 06/11/20 дугаар дүгнэлтээр, Хороолол доторх авто замын засвар, 2.024 км /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 7 дугаар хороо/ авто замыг 06/10/20 дугаар дүгнэлтээр, нийт 323.58 км авто замыг ашиглалтад оруулсан.</p>	
			<p>Шинээр ашиглалтад орох гүүрний урт, метр</p>	<p>100.0</p>		<p>-Хан-Уул дүүрэг 12 дугаар хороо Сонгинын Туул гол дээрх 205.1 урт метр төмөрбетон гүүрийг 10/02/20 дугаар дүгнэлтээр, -Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Онон голын 150 урт метр төмөрбетон гүүрийг 10/08/20 дугаар дүгнэлтээр, -Хэнтий аймгийн Дадал сумын Дадал сумын 238.9 урт метр төмөрбетон гүүрний их засвар, шинэчлэлтийн ажлыг 10/09/20 дугаар дүгнэлтээр, нийт 594 у/м гүүрийг ашиглалтад авсан.</p>	
			<p>Улсын чанартай авто зам, гүүрний байнгын засвар арчлалтын явц, хувиар</p>	<p>100.0</p>		<p>Улсын төсөвт улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд 52.0 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд 2020 оны төлөвлөгөөг замын чиглэл, хариуцагч компани бүрээр хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулан гаргаж Зам, тээврийн хөгжлийн сайдын А/20 дугаар тушаалаар батлуулж зам хариуцагч төрийн өмчит 20 хувийн хэвшлийн 12 нийт 32 компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа бөгөөд Сайдын тушаалаар батлагдсан нийт 43 цэгт өвлийн арчлалтын "Шуурхай ажлын хэсэг" 2020.04.01-ний өдөр хүртэл ажилласан. Замын засвар арчлалтын ажлын 30 хувийн урьдчилгаа санхүүжилтийг олгуулсан бөгөөд засвар арчлалтын ажил батлагдсан төлөвлөгөөний 99.2 хувьтай хэрэгжиж байна. Үерийн улмаас улсын чанартай авто зам, замын байгууламжид ихээхэн хэмжээний эвдрэлүүд үүсэж зам хариуцагч компаниудаар тухай бүр засварлуулсан бөгөөд сэргээн засварлахад гарсан хөрөнгийг Засгийн газарт хүсэлт гаргаж Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмж 5.8 тэрбум төгрөг шийдвэрлүүлсэн. Олон улсын болон улсын чанартай 14918.7 км авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг 2020 оны туршид ханган ажиллаж байна.</p>	

ЭХЭВЭЛ  
ХАРИУЦАГЧ  
ЭХЭВЭЛ  
ХАРИУЦАГЧ

			Өргөтгөл, шинэчлэл хийх замын урт, км	282.9		Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг АХБ-ны МОН3679/3786 зээлийн хөрөнгөөр 2019.06.21-ний өдрөөс эхлүүлэн хэрэгжүүлж байна. Барилгын ажлын хэрэгжилтийн хувь 2019 оны жилийн эцсийн байдлаар 25.1 хувьтай. 2020 оны зам барилгын ажлын бэлтгэл хангах хүрээнд зам барилгын ажилд ажиллах гадаад ажиллах хүчний зөвшөөрөл, гаалиар оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийн холбогдох зөвшөөрлийг шийдвэрлүүлэх хүсэлтийг эрх бүхий байгууллагад тавьж, шийдвэрлэн ажилласан. 2020 оны зам барилгын ажлыг 03.01-ний өдөр эхлүүлэхээр төлөвлөсөн боловч "Ковид-19" өвчний тархалт, дэгдэлтийн улмаас гадаад ажиллах хүчин Монгол Улсад төлөвлөсөн хугацаандаа ирж чадаагүй. Эхний ээлжийн гадаад ажиллах хүчин 2020.07.09-ний өдөр орж ирсэн ба тайлант хугацаанд 51 гадаад ажилтан ажиллаж байна. Зам барилгын ажлыг 5 багц хэсгээр гүйцэтгэж байгаа ба Багц 1, Багц 3, Багц 5 хэсгийн 2020 оны зам барилгын ажлыг дотоодын туслан гүйцэтгэгч компаниуд 03.20-ны өдрөөс эхлүүлсэн. Жилийн эцсийн байдлаар Багц 1 хэсгийн ажил-85.431 хувь, Багц 3 хэсгийн ажил-69.76 хувь, Багц 5 хэсгийн ажил-70.46 хувийн хэрэгжилттэй байна. Багц 2, Багц 4 хэсгийн гүйцэтгэгч компани нь БНХАУ-ын Шинжиан Уйгарын өөртөө засах оронд байрладаг бөгөөд тус бүс нутагт "Ковид-19" өвчний тархалт дэгдэлт, хорио цээрийн улмаас гадаад ажиллах хүчийг Монгол Улсад ирүүлэх боломжгүй болсонтой холбогдуулан гэрээ цуцлах хүсэлтийг 2020.08.16-ны өдөр ирүүлсэн. Гэрээ цуцлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Гэрээ цуцлагдаж байгаатай холбогдуулан дахин тендер зарлах бэлтгэл ажлыг хангаж байна. Өвлийн улиралд төслийн авто зам дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, саадгүй зорчих хүрээнд авто замын үндсэн трассаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр нээсэн.	
7.2	Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 6.1.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн	Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын 4С зэрэглэлд хүргэх	Ховд, Хөвсгөл, Дорнод аймгийн нисэх буудлыг өргөжүүлэх ажлын явц, хувиар	70.0	-	1. Ховд аймгийн "Ховд" нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд аэродромын болон зорчигч үйлчилгээний цогцолборын ажлын зураг төслийг хийлгэсэн. -Аэродромын өргөтгөлийн ТЭЗҮ, зураг төслийг 2018 онд "ЭЗТ" ХХК-аар гүйцэтгүүлж, экспертизээр батлуулан хүлээж авсан. Аэродромын өргөтгөлийн төсөвт өртөг 28.3 тэрбум төгрөг. -Зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төслийг "Алтайн газрын хүч" ХХК-аар гүйцэтгүүлж, экспертизээр баталгаажуулан хүлээж авсан. Зорчигч үйлчилгээний барилга	30

2.114 дэх заалт						<p>байгууламжийн төсөвт өртөг 21.6 тэрбум төгрөг.          Коронавируст цар тахлаас шалтгаалан иргэний нисэхийн салбар санхүүгийн хүндрэлд орсон тул нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх санхүүжилтийг шийдвэрлэх боломжгүй болсон. Зам, тээврийн салбараас ЕСББ-ны зээлийн санхүүжилтээр хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтад Ховд нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх төслийг оруулах саналыг холбогдох танилцуулга мэдээллийн хамт хүргүүлсэн.          Нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр гадаадын хөрөнгө оруулагч санхүүгийн байгууллагуудад хүсэлт хүргүүлээд байна.</p> <p><b>2. Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын үерийн хамгаалалтыг сэргээх, аэродромын хүчитгэл, өргөтгөлийн ажлын тоо хэмжээний хяналтын төсвийг шинэчлэх ажлыг "ЭЗТ" ХХК-аар хийж гүйцэтгүүлж, Автозамын хөгжлийн төвөөр хянуулан баталгаажуулан хүлээж авсан.</b>          -Нисэх буудлыг өргөтгөх төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг "Эхмонголын байгаль" ХХК-аар гүйцэтгэж, 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр ИНЕГ-т хүлээлгэн өгсөн.          Тус нисэх буудлын аэродромыг өргөтгөхөд шинэчилсэн төсвөөр 18.9 тэрбум төгрөг шаардагдана. Санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байна.</p> <p><b>3.Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг өргөжүүлэх ажлын хүрээнд зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болгох мөн зурвасыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай болгох, өргөтгөх зураг төслийг хийлгэсэн.</b>          - ИНЕГ болон "Некстстеп инженеринг" ХХК хооронд "Зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх болон бусад инженерингийн барилга байгууламжуудын ажлын зураг төсөл, төсвийг хийж гүйцэтгэх" ИНЕГ/ХОЛТББ/ЗҮ-07/19-163/19 дугаар гэрээг 2019.10.25-ны өдөр байгуулсан. Гүйцэтгэгч зураг төсвийг боловсруулж, Барилгын хөгжлийн төвийн экспертизээр батлуулан 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр ИНЕГ-т хүлээлгэн өгсөн. Зорчигч үйлчилгээний цогцолборыг өргөтгөх төсөв 4.5 тэрбум төгрөг.          - ИНЕГ болон "ЭЗТ" ХХК хооронд "Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадал бүхий нисэх буудал болгох, өргөтгөх зураг, төсөл</p>
-----------------	--	--	--	--	--	---

					<p>боловсруулах ажлыг гүйцэтгэх” зөвлөх үйлчилгээний ИНЕГ/ХОӨЛББ/Б-01/ 2088/20 дугаар гэрээг 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан. Гүйцэтгэгч зураг төслийг боловсруулж дуусгасан бөгөөд экспертизээр батлуулахаар ЗТХТ-д хүргүүлсэн.</p> <p>Нисэх буудлын байгаль орчны нарийвчилсан үнэлгээг “Эхмонголын байгаль” ХХК-аар гүйцэтгүүлж, 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр ИНЕГ хүлээн авсан.</p>		
7.3	ЗГҮАХ-ийн 2. 120 дахь заалт	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх	1-р үе шатны барилгын ажлын явц, хувиар	100.0		<p>“Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн санхүүжилтийг АХБ-наас зогсоох болсноо мэдэгдэж төсөл хэрэгжих боломжгүй болсон.</p>	0
7.4	МУТХҮБ-2030- ын 2.1.5, Зорилт 3,	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын	Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын барилгын ажлын явц, хувиар	100.0		<p>Засгийн газрын 2018 оны 242, 2019 оны 304 дүгээр тогтоолууд гарч 2014 оноос барилгын ажил нь зогссон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан. 2020 оны 03 дугаар сараас барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2020 оны 04 дүгээр улирлын байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явц газар шорооны ажил 99.29 хувьтай, хоолойн ажил 100 хувь, гүүрний ажил 85.34 хувьтай, өртөө, зөрлөгийн барилгын ажил 8.8 хувьтай, төмөр замын дээд бүтцийн ажил 189 км буюу 70.6 хувьтай, бетон дэр үйлдвэрлэл: 100 хувь, балласт үйлдвэрлэл 71.06 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.</p>	30
			Нарийнсухайт – Шивээхүрэн чиглэлийн 45.3 км төмөр замын барилгын ажлын явц, хувиар	100.0		<p>Нарийнсухайт-Шивээхүрэнгийн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг “Мөнгөн зөрлөг” ХХК 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан шинэчилсэн. Тус чиглэлийн төмөр замын шугамын чигийг Засгийн газрын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 57 дугаар тогтоол</p>	



	ЗГҮАХ-ийн 2.108, 2.112 дахь заалт	төслүүдийг үргэлжлүүлэх				<p>батлагдсанаар тус чиглэлийн төмөр замын царигийн хэмжээг тодорхойлсон.</p> <p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.5 км төмөр замын барилгын ажлыг 2023-2024 онд эхлүүлэхээр тусгуулсан.</p> <p>Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд Шивээхүрэн-Сэхээ боомтыг төмөр замын ангиллаар олон улсын зэрэглэлтэй байнгын ажиллагаатай байх саналыг ГХЯ-нд хүргүүлж, 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр БНХАУ-ын Төрийн эөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ноот бичиг" солилцох замаар энэхүү хэлэлцээрийг албажуулсан. Цаашид санхүүжилт шийдвэрлэгдсэнээр энэхүү чиглэлийн боомт орчмын төмөр замыг барих нөхцөл бүрдэнэ.</p>
			Эрдэнэт – Овоот чиглэлийн 547.7 км төмөр замын төслийн ажлын явц, хувиар	10.0		<p>Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг СМЕК компани боловсруулж, Концесс эзэмшигч "Нортерн рейлвэйс" ХХК-д хүлээлгэн өгсөн.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын 2017 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан. УИХ-ын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор Эрдэнэт-Арцсуурь чиглэлийн 780 км төмөр замыг Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэмэлтээр оруулсан.</p> <p>"Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" нөхцөлтэй концессоор хэрэгжих Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийн концесс эзэмшигч "Нортерн Рэйлвэйс" ХХК нь уг төмөр замын төслийн олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх, цаашид хамтран ажиллахаар БНХАУ-ын "Чайна гэжуба групп" корпорацтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.</p> <p>Санамж бичгийн дагуу "Чайна гэжуба групп" корпорац нь тус төмөр замын төслийн олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Эрдэнэт-Овоотын 547.7км төмөр замын нарийвчилсан</p>

						<p>ТЭЗҮ-г боловсруулан.</p> <p>"Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замын трасс нь УИХ-аар "Зарим газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах тухай" тогтоолоор Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авснаар батлагдсан чигээс 100 гаруй км дайран давхацсан, мөн Ханжаргалантын байгалийн нөөц газарт төмөр замын чиг давхацсанаар тухайн чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, санхүүжилт татах ажил удааширсан.</p> <p>УИХ-ын 2020 оны намрын чуулганаар Төмөр зам тээврийн тухай хууль хэлэлцэх эсэх асуудлаар УИХ-ын гишүүд Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын талаар санал асуулга тавьж, хууль зөрчин хийгдсэн концессын гэрээг шалгах, хүчингүй болгох асуудлыг тавьсан. Мөн нутгийн иргэд, "Уул уурхайгүй Хөвсгөл" ТББ-аас уурхай байгуулах, төмөр зам тавихыг эсэргүүцсэн. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замыг Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаагүйгээс цаашид хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй байгаагаас концесс эзэмшигч чигийн судалгааг дуусгаагүй.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын чиг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дахин судалгаа хийх, ТЭЗҮ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг шинэчлэх зэрэг ажилд дахин санхүүжилт шаардлагатай болсон.</p>	
--	--	--	--	--	--	---	--

**ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО**

**Зорилт 8. Байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн онцлогт тулгуурлан хүн амын нутагшил, суурьшил, хот суурингийн оновчтой тогтолцоог бий болгож, иргэдийн аюулгүй ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.**

8.1	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.79 дэх заалт	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулах	Төсөл боловсруулах ажлын явц, хувиар	80.0	2.8 Улсын төсөв	<p>Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах зөвлөх үйлчилгээний 119 тоот гэрээг 2018 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-тай байгуулан төслийн судалгааны ажлыг монгол орны нутаг дэвсгэрт бүсчилсэн байдлаар гүйцэтгэсэн. Төсөл боловсруулах аргачлал, арга зүйг боловсруулж, Архитектур, хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, салбарын Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хуралдаанаар 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдөр тус тус хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Төсөл боловсруулах аргачлал, арга зүйн дагуу, төслийн судалгаанд үндэслэн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ болон төслийн төлөвлөлтийн эхний хувилбарыг</p>	100
-----	--	--	--------------------------------------	------	--------------------	---	-----

					<p>боловсруулсан. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үүрэг бүхий зөвлөх багийг Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 162 дугаар тушаалаар байгуулсан. Мөн "Урбан лаб" танхим байгуулж, энэхүү төсөлтэй холбоотой уулзалт, хэлэлцүүлгийг салбарын мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдыг оролцуулан зохион байгуулсан. Төсөл боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын архитекторуудын эвлэлтэй 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. Төсөл боловсруулах ажлын явц 80.0 хувьтай байна. Энэхүү төслийг улсын төсвийн 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэсэн.</p>	
8.2	<p>МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.81 дэх заалт</p>	<p>Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох</p>	<p>Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын явц, хувиар</p>	10.0	<p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь өөрийн нөөц боломжид тулгуурлан байр зүйн зургаар зурагжуулах ажлын хүрээнд судалгааны ажлууд хийсэн. Үүнд: Азербайжан улсын Азеркосмос байгууллагатай хамтран ажиллах "Санамж бичиг" байгуулж, Зүүнбаян-Цогтцэций чиглэлийн төмөр зам, Дархан-Улаанбаатар чиглэлийн автозам, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум /газар тариалан/, Улаанбаатар хот /барилга/, Дорноговь аймгийн Даланжаргалан сум /уурхай/ байршлыг сонгон, Спот 7 хиймэл дагуулын зургийг 2020 оны 5-6 дугаар сард GEOMATICA программ ашиглан 85.6 мянган га талбайд DTM буюу гадаргуун тоон загвар боловсруулж, ортофото зураг үүсгэсэн. Эдгээр мэдээллийг агаарын зураглалын аргаар боловсруулсан өгөгдөл мэдээлэлтэй харьцуулан судлах, нарийвчлалын шаардлага хангаж байгаа талаар судалгаа хийсэн.</p> <p>Энэ арга хэмжээг гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх боломжийг судлан, ОХУ-ын Кадастр, зураг зүйн улсын бүртгэлийн холбооны алба болох Росреестер байгууллагатай санал солилцон, хамтран ажиллаж, Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийн төслийг ОХУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдаас Гадаад харилцааны ямаар дамжуулан тус яаманд ирүүлсэн. Хэлэлцээрийн төслийг судалж, уг ажил нь нууцын зэрэглэлтэй тул Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зөвлөмж авахаар 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр албан бичгээр /нууцын зэрэглэлтэй/ хүргүүлсэн.</p>	50

				Хэлэлцээрийн төсөлд холбогдох бусад байгууллагуудаас санал аван Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. /Нууцын зэрэглэлтэй ажил/
	Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах цэгийн тоо	1	-	“Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг барьж байгуулахад зориулан Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байрлах 0.21 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, талбайн хэмжээ, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг баталсан. 2019 онд Геодезийн сүлжээний эхлэл цэг байгуулах ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын урсгал төсвөөс 35 сая төгрөгийг эхлэл цэгийн төвийг суурилуулах ажилд, 55 сая төгрөгийг хэмжилт хийх судалгааны ажилд тус тус зарцуулсан. Геодезийн сүлжээний эхлэл цэг дээр гравиметрийн хэмжилт хийх ажлыг гүйцэтгэх санхүүжилт 2020 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд багтаагүй ба Япон Улсын Геодезийн албатай хамтран 2020 оны 9 дүгээр сард гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч “Ковид-19” цар тахал гарч, Япон мэргэжилтнүүд ирэх боломжгүй болсон тул уг хэмжилтийг 2022 онд хийхээр хойшлуулсан болно.
	Шинээр байгуулах GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станцын тоо	7	-	Тус ажлын хүрээнд “Чандмань сүрвэй” ХХК-тай 2020/121 дугаартай гэрээ байгуулж, байнгын ажиллагаатай 35 станц холбох эрхтэй АНУ-ын “Subcarrier Systems” корпорацийн SNIP программ хангамжийг 20 сая төгрөгөөр худалдан авсан. Гүйцэтгэгчээс ирүүлсэн SNIP программ хангамжийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын серверт суулгаж, 35 станцыг холбож, программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлснээр шинээр суурин станц байгуулах бэлтгэл ажил хангагдаад байна.
	Газар зүйн нэрийн тодруулалтыг хийх, хувиар	30.0	0.225 тэрбум төгрөг Орон нутгийн төсөв	2020 онд 50 мянган газар зүйн нэрийн 30 хувийг тодруулахаар төлөвлөсөн боловч санхүүжилт төсвийн тухай хуульд тусгагдаагүй ба орон нутгийн төсвийн хөрөнгөөр Булган, Дорнод, Дундговь, Хэнтий аймгийн төсвөөс нийт 235 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн, дээрх 4 аймгийн 15 суманд 14663 газар зүйн нэрийн тодруулалт хийж, мэдээллийн сан үүсгэсэн. Үүнд: Булган аймгийн 7 суманд 75 сая төгрөгөөр 4633 нэрийн тодруулалт, Дорнод аймгийн 2 суманд 20 сая төгрөгөөр 1730 нэрийн тодруулалт, Дундговь аймгийн 5 суманд 130 сая төгрөгөөр 7273 нэрийн тодруулалт, Хэнтий аймгийн 1 суманд 10



					сая төгрөгөөр 1027 газар зүйн нэрийн тодруулалт тус тус хийж, мэдээллийн сан үүсгэснээр 2020 оны зорилт бүрэн биелсэн.	
			Өндрийн II дугаар ангийн сүлжээний хайгуул судалгаа, давтан хэмжилт хийх шугамын урт, км	3400	0.105 тэрбум төгрөг ГЗБГЗЗГ-ын урсгал зардал	<p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2020 оны урсгал төсөв (105 сая төгрөг) – өөр “Өндрийн II ангийн 1 шугамыг өндрийн I ангийн сүлжээ болгон шинэчлэн байгуулах” ажлыг гүйцэтгэж байна. Батлагдсан ажлын даалгаврын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан “Бэйс Пойнт” ХХК-тай 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр гэрээг байгуулсан. Хэмжилт хийх шугамын цэгийн мэдээлэл болон судалгаанд үндэслэн “Өндрийн I ангийн сүлжээний хэмжилт, боловсруулалт хийх” ажлын цэгийн судалгаа, суулгалтын ажил 100% хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэгийн хайгуул, судалгаа, суулгалт,</li> <li>- GNSS-ийн сүлжээний хэмжилт, боловсруулалт, нийт 80 цэг дээр хэмжилт хийсэн.</li> <li>- Гравиметрийн сүлжээний хэмжилт, боловсруулалт. нийт 94 цэг дээр хэмжилт хийсэн.</li> </ul> <p>Өндрийн сүлжээний хэмжилт, боловсруулалт. Өндрийн I ангийн сүлжээний 2 шугам /5, 6 дугаар шугам/-нд нийт 790 км шугаманд хэмжилтийг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан, байгууллагын урсгал зардлаас хөрөнгө гарган, хийж гүйцэтгэсэн.</p>
			Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлын явц, хувиар	100.0	1.18 тэрбум төгрөг Улсын төсөв	<p>Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн стандартыг боловсруулан, Стандарт, хэмжил зүйн газарт 2019 оны 12 дугаар сард хүргүүлсэн. Стандарт, хэмжил зүйн газар стандартын төсөлд санал авах ажлыг албан ёсны цахим хуудсаараа дамжуулан зохион байгуулж байна.</li> <li>2. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор баталсан 214805 газар зүйн нэрийг мэдээллийн санд оруулан боловсруулж, цахим үйлчилгээнд нэвтрүүлээд байна.</li> </ol> <p><a href="https://geoportal.nsd.gov.mn/alagac/apps/webappviewer/map.html">https://geoportal.nsd.gov.mn/alagac/apps/webappviewer/map.html</a></p> <p>2. Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг улсын хэмжээнд бий болгох ажлын санхүүжилтийг 2020 оны улсын төсвийн 1,180.0</p>

					<p>сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Барилга хот, байгуулалтын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 15 дугаар тушаалаар “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2023 он/-г батлуулан, нийслэл болон 21 аймаг, 330 сум, 54 суурин газрын хаягийн зураг, мэдээллийн санг хаягийн мэдээллийн нэгдсэн системд оруулах, замчлах системд зориулж орон зайн өгөгдөл, мэдээллийг бэлтгэх ажлыг Геомастер ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж байна.</p> <p>2. “Газар зүйн нэрийг тогтоох, хадгалах, хамгаалах, ашиглах” барилгын дүрэм /БД/-ийн төслийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Газар зүйн нэрийн зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцэж, энэхүү асуудал нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.4.1 дэх хэсэгт заасан “биет бус соёлын өвийг хамгаалах” асуудалд хамаарах тул Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>3. Геодезийн 7 төрлийн сүлжээний 12500 цэг, тэмдэгтийн мэдээллийг агуулсан геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг байгуулж, цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.</p> <p>4. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын цахим системийн үйлчилгээ бий болгох ажлын хүрээнд <a href="http://egazar.gov.mn">/http://egazar.gov.mn</a>, <a href="https://egazar.gov.mn/plan/">https://egazar.gov.mn/plan/</a> порталыг хөгжүүлж засаг, захиргааны хилийн цэсийн мэдээллийг байршуулсан бөгөөд уг системд “Хилийн цэс” гэсэн шинэ категори үүсгэн хилийн цэсийн маргаантай холбоотой асуудлыг урьд нь цаасан хэлбэрээр авдаг байсныг цахим хэлбэрт шилжүүлэн хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Засаг захиргааны хилийн цэсийн мэдээллийг цахим системд оруулах үйлчилгээ нэвтрээд байна.</p>		
8.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.81 дэх заалт	Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд	Геопортал хөгжүүлэх, орон зайн мэдээлэл бүрдүүлэгч, хэрэглэгч байгууллагууд мэдээллээ цахимаар солилцох ажлын явц, хувиар	70.0	1.3 тэрбум төгрөг Улсын төсөв	Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг 2020 оны улсын төсвийн 2,682.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Энэхүү ажил нь нууцын зэрэглэлтэй ажил тул Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 29 дүгээр тушаалын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу Тагнуулын ерөнхий газраас зөвшөөрөл аван зохион байгуулсан. Эрх олгогдсон гүйцэтгэгчтэй Газар зохион байгуулалт, геодези, зураг	100

		нэвтрүүлэх				зүйн газрын дарга 2020 оны 05 сарын 05-ны өдрийн 2020/128 тоот гэрээ байгуулан, эхлэлийн болон дунд шатны ажлын тайланг хянан, хүлээн авч, гүйцэтгэлийн явцад захиалагчийн техникийн хяналт хийж ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. /Нууцын зэрэглэлтэй ажил/	
8.4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.80, 2.81 дэх заалт	Монгол Улсын газар нутгийг газар ашиглалтын зориулалтаар нь тооллого явуулах, мэдээллийн санд бүртгэх	Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулах ажлын явц, хувиар	100.0	1.0  Улсын төсөв	"Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн, газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах" ажлын даалгаврыг боловсруулан, Төрийн нарийн бичгийн даргаар 2020 оны 01 дүгээр сард 2020/10 дугаартай батлуулсан. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/59 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, "Газар дэлхий", "Ланд овнер" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг нууцын зэрэглэлтэйгээр байгуулан, гэрээт ажил бүрэн хийгдэж дуусаад байна. /Нууцын зэрэглэлтэй ажил/	100
8.5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.80, 2.81 дэх заалт	Газрын төлөвлөлт, бүртгэл, бирж, үнэлгээ, мониторингийн нэгдсэн тогтолцоог бий болгох	Газрын нэгдсэн цахим систем бий болгох ажлын явц, хувиар	100.0	1.9  Улсын төсөв	"Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах", "Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагчийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх", "Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох", "Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар ханган, эдийн засгийг эрчимжүүлэх" гэсэн багц ажлуудыг 2018-2020 онд гүйцэтгэсэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн цахим системийн үйлчилгээ бий болгох ажлын хүрээнд / <a href="http://egazar.gov.mn">http://egazar.gov.mn</a> , <a href="https://egazar.gov.mn/plan/">https://egazar.gov.mn/plan/</a> засаг, захиргааны хилийн цэсийн мэдээллийг бүрэн байршуулсан. "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем", "Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагчийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх", "Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш	70



						<p>байдлаар ханган, эдийн засгийг эрчимжүүлэх” цахим сангийн нээлтийн ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, “Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох” ажлын нээлтийн ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр тус тус зохион байгуулсан. Дээрх ажлуудын үр дүнд Газрын нэгдсэн цахим систем бий болгох ажил 100 хувь хийгдсэн байна.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд “Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах” гэрээт ажлыг 2019-2020 онд гүйцэтгэсэн. 21 аймаг, нийслэлийн 2000-2004, 2008-2010, 2016 оны бэлчээрийн, 2005, 2011-2012, 2016, 2017-2018 оны тариалангийн, 2004, 2012-2016, 2016, 2018 оны хот, суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тоон мэдээллийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэх ажлыг хийсэн. 400 орчим захиалгат хянан баталгааны ажлын тоон мэдээллийг авч нэгтгэн 5000 орчим мониторингийн сүлжээний цэг байгуулсан.</p>	
			Мониторингийн сүлжээний цэгийн тоо	15000			
8.6	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /цаашид ЗГҮАХХАХТ гэх/-ийн 4.1.1.7 дахь заалт	Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Барилгын материалын лабораторид нийлүүлэх тоног төхөөрөмжийн нэр, төрөл	5	0.124  Орон нутгийн төсөв	<p>Засгийн газрын 2014 оны 308 дугаар тогтоолоор баталсан “Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 21 аймгийн төвд металл хийц эдлэхүүний, цонх хаалганы, цементийн лабораториудын тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч байна. Үүнд: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 08-18-ны өдрүүдэд Арабын Нэгдсэн Эмират Улсад хийсэн айлчлалын хүрээнд 21 аймгийн барилгын материалын лабораторийг өргөжүүлэх, 5.0 сая ам.долларын тоног төхөөрөмж ханган нийлүүлэх төсөл хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p>2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгө болон барилга захиалагчийн зардлаас дор дурдсан аймгуудад барилгын материалын лабораторийн багаж, тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн байна. Үүнд:</p> <p>1. Завхан аймаг: Бетон зуурагч, чичиргээд ширээ, жин, аналитик жин, шатаах зуух, цементийн агууламж тодорхойлогч, цилиндр сав, бетоны сорьцын хэв, хуванцар хэмжээт мөнзурк, асгаасны нягт тодорхойлогч, хайрганы үзүүрлэгч шинж тодорхойлогч, хайрганы бутрамтгай чанар тодорхойлогч зэрэг нийт 33 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 10.0 сая төгрөгөөр</p>	100



					<p>нийлүүлсэн.</p> <p>2. Дорноговь аймагт: цементийн зуурагч, чийгшүүлэгч, гулзайлтын бат бэх тодорхойлогч пресс, шахалтын пресс, нунтаглалтын шигшүүр, уурын тогоо, доргиур, хувийн гадаргуу тодорхойлогч зэрэг 23.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>3. Архангай аймагт: Бетон сорь хэвлэх 10*10*10 шооны хэв, термометр, цементийн шахалтын бат бэхийг тодорхойлох ялтас 4*4*16 металл хэв, тоосгоны шахалтын бат бэх тодорхойлох тулгуур зэрэг 2.6 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>4. Говь-Алтай аймагт: цемент зуурагч, асгаас үзэх цилиндр /элсний сав/, аналитик жин, хатаах шүүгээ, лабораторийн плитк, пикнометр, дүүргэгчийн асгаас үзэх юүлүүр, шилэн колбо, шаталейн багаж, хайрганы бат бэх тодорхойлох плунжер, шанкэн циркуль, тоосгоны гулзайлт тодорхойлогч пресс, төмөр поднус, хөлдөөх камер /хөлдөөгч/, усан банн, цементийн гулзайлт тодорхойлогч, уурын банн, цементийн дээж нягтруулах доргиур, викийн багаж, цементийн хэв /4*4*16/, цементийн бат бэх тодорхойлох суурь, элс хайрганы шигшүүр, бетоны бат бэх тодорхойлох пресс зэрэг 24 төрлийн 15,7 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>5. Ховд аймагт: цемент зуурагч, цемент зуурагч, цементийн гулзайлтын бат бэх тодорхойлох багаж, цементийн шахалтын бат бэх тодорхойлох пресс, цементийн зуурмагийн дээж нягтруулах доргиулагч, ус нэрэгч аппарат, цементэн сорьц хадгалах чийгшүүлэгч камер, цемент чанах тогоо, эзлэхүүний өөрчлөлт үзэх багаж, хувийн гадаргуу тодорхойлох багаж, викийн багаж, хүйтэн тэсвэрлэлт тодорхойлогч хөргөгч зэрэг 15 төрлийн 23.0 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>6. Увс аймагт: шахалтын бат бэх шалгагч пресс, гулзайлтын бат бэх тодорхойлогч, доргиурын ширээ, уурын камер, 3,5 литрийн зуурагч, ус нэрэгч, уурын ван, хувийн гадаргуу тодорхойлогч эзлэхүүний өөрчлөлт үзэх багаж, авто замын корын өрөм хөлдөөгч бетоны агаар агууламж тодорхойлох багаж зэрэг 50.0</p>
--	--	--	--	--	---

						сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлсэн. Дээрх ажлын үр дүнд аймгуудын барилгын материалын лабораториудад орон нутгийн төсвийн хөрөнгө болон захиалагчийн зардлаас 124.5 сая төгрөгөөр давхардсан тоогоор 50-аад нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг ханган нийлүүлж, барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлсэн байна.	
8.7	ЗГҮАХ-ийн 2.72 дахь заалт	Дотоодын гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Арматурын үйлдвэрлэлийн өсөлт, хувиар	20.0	0.009 ТХХТ	Барилгын гол нэрийн материал болох арматур, ган туйвангийн 2019 оны нийт хэрэгцээ 288.4 мянган тонн байсны 80 хувь буюу 232.7 мянган тонн арматурыг импортоор хангасан үзүүлэлттэй байна. Иймээс импортын хэмжээг багасгах, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2020 оныг "Ган туйвангийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх жил" болгон ажиллах төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар 2020 оны 01 дүгээр сард батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу эхний ээлжид дотоодын гангийн үйлдвэрүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор арматур үйлдвэрлэгч 12 жижиг, дунд компаниудын төлөөлөлтэй БХБЯ-аас энэ оны 1 дүгээр сарын 22-нд уулзалт зохион байгуулж, тулгамдсан асуудлын талаар хэлэлцсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/144 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2020 оны 1 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК, Эрдэнэтийн "Бэрэн металл" ХХК, "Хөх ган" ХХК-ийн үйлдвэрүүдийн өнөөгийн нөхцөл байдалтай танилцан, цаашид авах арга хэмжээний санал боловсруулсан. "Бэрэн металл" ХХК-ийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд тус үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийг шийдвэрлэх талаар санал боловсруулж Хөгжлийн банканд 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01/537 тоотой уламжлан, дэмжигдсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02/529 тоотой гангийн үйлдвэрүүдэд гадаад ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэх талаар албан хүсэлт хүргүүлсэн боловч COVID 19 цар тахлын улмаас гадаадаас ажиллах хүч орж ирээгүй. Мөн арматур импортлогч аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийх ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 94 дүгээр тушаалаар байгуулан, шалгалтын ажлыг зохион байгуулж, дүгнэлт, санал зөвлөмж гаргасан боловч COVID-19	30

8.8 МУТХУБ-2030-ын 2.1.5, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 2.76, 3.4.3 дахь заалт	Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх бодлого, хэрэгжүүлэх, гэр хороололд амины орон сууц барихад урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох	Ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэдийн тоо	12000	814.6 Монголбанк  Арилжааны Банкны эх үүсвэр	<p>цар тахлаас шалтгаалан дотоодын барилгын үйлдвэрлэлийн хэмжээ буурснаар гангийн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдээгүй. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10.6-д "Барилгын салбарын зээлийн чанар муудахаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Төв банкнаас олгосон санхүүжилтийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээгээр орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжүүлнэ" гэж заасан. Үүний дагуу 2020 онд ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй зээлд Монголбанкнаас 240.0 тэрбум төгрөг, арилжааны банкнуудын өөрийн эх үүсвэрээс 120.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу 2020 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарыг дуустал хугацаанд 285.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 3703 зээлдэгчид жилийн 8 хүүтэй зээл олгосон. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгон бууруулах зорилт тавьсны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 142 дугаар тушаалаар энэхүү зорилтыг хэрэгжүүлэх урьдчилсан санал боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр "МИК ОССК" ХХК-тай болон 2020 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр хөтөлбөрт оролцогч банкнуудтай зөвшилцөж ипотекийн зээлийн хүүг 6 хувиар олгож эхлэх тооцооллыг хийж 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулан, дэмжигдэж, хэрэгжүүлэх ажлыг 2020 оны 10 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулах чиглэл өгсөн. 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд нийт 1022 зээлдэгчид 6 хувийн хүүтэй 72.7 тэрбум төгрөгийн зээл олгосон. 5503 зээлдэгчид Монгол банкны эх үүсвэрээс, 5513 зээлдэгчид арилжааны банкны эх үүсвэрээс ипотекийн зээл олгосон байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 814.6 тэрбум төгрөгийн ипотекийн хөнгөлөлттэй зээлийг 11043 зээлдэгчид олгоод байна. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2017-2019 онд авах зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Ерөнхий хэлэлцээрийн хугацааг сунгах тухай Солилцох захидалд 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан. Мөн өдөр Солонго 1, 2 орон</p>	70
		Солонго 1, 2 төслийн хүрээнд шинээр ашиглалтад орох орон сууцны тоо	2436			

					<p>сууцны хороолол барих төслүүдийн зээлийн хэлэлцээрийг байгуулсан. Уг 2 төсөлд 266.8 сая ам.долларын санхүүжилтийг зарцуулах бөгөөд энэ санхүүжилтээр Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Буянт-Ухаа 2 хорооллын хажууд 9.8 га, 7.8 га газарт 2712, 2290, нийт 5002 айлын орон сууцны хорооллыг барина. Энэхүү төсөл нь зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гэсэн 2 үе шаттайгаар 2020-2024 онд хэрэгжинэ.</p> <p>Уг төслийг эхлүүлэх бэлтгэл ажлыг Эксим банкттай хамтран зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг БНСУ-ын 8 компанид зөвлөх үйлчилгээний тухай зарлалыг цахимаар илгээж, 3 компанийг хураангуй жагсаалтад бүртгэж, БХБЯ-ны 2020.03.26-ны 04/1082 тоот албан бичгээр БНСУ-ын Эксим банкинд хүргүүлсэн. 2020.04.13-ны өдөр БНСУ-ын Эксим банк хураангуй жагсаалтыг баталгаажуулсан. 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төслүүдийн зээлийн хэлэлцээрийг байгуулсан.</p> <p>Зураг төсөл боловсруулах, барилгын ажлын явцад хяналт тавих зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, үнэлгээний тайланг Эксим банканд хүргүүлж, 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр үнэлгээний үр дүнг баталгаажуулж, гэрээ байгуулах хэлцэл хийхийг зөвшөөрсөн. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/132 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гэрээний хэлцлийг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан "SAMOO JV" компанитай гэрээ байгуулах ажил явагдаж, төслийг эхлүүлээд байна. Гэвч гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээний компаниуд КОВИД-19 цар тахлаас шалтгаалан орж ирж чадахгүй байна. Монголын талаас хүлээх үүргээ бүрэн биелүүлсэн.</p>		
8.9	ЗГҮАХХАХТ-ний 2.48.16 дахь заалт	Дотоодод үйлдвэрлэсэн цементийг экспортлох бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх	Цементийн экспортын хэмжээ, хувиар	10.0	-	<p>Дотоодод үйлдвэрлэсэн цементийг экспортлох бизнесийн таатай орчныг бүрдүүлэхийн тулд холбогдох үйлдвэр, ТББ-уудыг хамруулсан хэлэлцүүлгийг 2019 оны 12 дугаар сард зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгийн мөрөөр ОХУ-ын импортын орчныг судлан санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гадаад харилцаа хариуцсан менежерээр ахлуулан холбогдох үйлдвэрүүдийн төлөөллийг оролцуулан байгуулж, 2020 онд авч</p>	0



					<p>хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргасан.</p> <p>"Ковид-19" цар тахлаас шалтгаалан дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ багасаж, цемент экспортлох боломжгүй болж, цементийн үнэ өссөнтэй холбогдуулан аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:</p> <p>1.Импортын цементийг гааль болон НӨАТ-аас цар тахлын үед түр чөлөөлөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 55 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, ОБЕГ-т 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 03/1717 тоотой хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, шийдвэрлэсэн.</p> <p>2.Цементийн үндэсний үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа шалтгааны нэг нь эрчим хүчний хангамжаас шалтгаалж байгаатай холбогдуулан ЭХЯ-тай хамтран эрчим хүчний асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>2019-2020 онд Стандарт хэмжил зүйн газрын Бетоны стандартын техникийн хороогоор цементийн 14 евро-стандартыг үндэсний стандарт болгон батлуулсан.</p>		
8.10	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 6, ЗГҮАХХАХТ-ний 2.77.2 дахь заалт	"Ногоон сууц" загвар төслийн зураг төслийг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх	Зураг төслийг боловсруулах ажлын явц, хувиар	100.0	0.1172 НҮБХХ	<p>"Ногоон сууц" загвар төслийн архитектур төлөвлөлтийн даалгавар, техникийн нөхцөлүүдийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авч, зураг төсөл боловсруулах уралдааныг нээлттэй зарласан. Уг уралдаанд "Эн Эс Партнерс" ХХК шалгарсан бөгөөд тус компанитай 2019 оны 4 дүгээр 26-ны өдөр гэрээг байгуулж, ажлыг эхлүүлсэн. Гэрээт хугацаанд "Эн Эс Партнерс" ХХК нь 80 айлын ногоон сууцны хотхоны зураг төслийг боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр тус яаманд хүлээлгэн өгсөн. Төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулахад шаардлагатай 117.2 сая төгрөгийн санхүүжилтийг НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр шийдвэрлүүлж, зураг төсөл боловсруулах гэрээг 2020 оны 01 оны 06-ны өдөр "Эн Эс Партнерс" ХХК-тай байгуулж, ажлыг эхлүүлсэн. Тус компани зураг төслийг боловсруулж, 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдөр магадлалаар хянуулан баталгаажуулж, хүлээлгэн өгсөн. Уг төслийн хүрээнд Олон улсын хүүхдийн "Найрамдал" зуслангийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг нэмэлтээр гүйцэтгэхээр 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, иж бүрэн зураг төслийг 2020 оны 08 дугаар сард хүлээн авсан.</p>	100

8.11	ЗГҮАХХАХТ-ний 2.91.1, 4.2.3 дахь заалт	"Дархан хотын бохир усны менежментийн төсөл"-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт, хувиар	60.0	17.7 Гадаад эх үүсвэр	<p>"Дархан хотын бохир усны менежментийн төсөл"-ийг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. 2020 онд төслийн 3 багцын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>А1 багц: Дархан хотын бохир усны цэвэрлэх байгууламж болон насос станцуудын шинэчлэх. Үйлдвэрийн насос станцын барилга 71 хувьтай, захиргааны барилга 88 хувьтай, ахуйн бохир ус хүлээн авах байгууламж 73 хувьтай, хоёрдогч тунгаагуур 87 хувьтай, био-цөөрөм 39 хувьтай, агааржуулах станц 60 хувьтай, барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 68 хувьтай байна.</p> <p>А2 багц: Дулааны болон бохирын шугам хоолой шинэчлэх. Дархан сумын 5, 6, 13, 14-р багуудын А5, В1, В2 хэсэгт 2030 м шугам хоолой шинэчлэгдсэн, цэвэрлэх байгууламжийг төвлөрсөн дулаанд холбосон, Дулааны насос станц №3-ын барилга байгууламж, 320/640 м3цаг хүчин чадалтай насос тоног төхөөрөмж бүхий хаалттай дэд өртөөг бүрэн ашиглалтад оруулсан, Бохир усны шугамын А5 хэсэгт ф300мм голчтой, 260м урттай, В1 хэсэг ф300мм голчтой, 400м урттай, В2 хэсэгт ф300мм голчтой, 211 м урттай, шугам хоолойн угсралтын ажлыг гүйцэтгэж комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 91 хувьтай байна.</p> <p>А3 багц: Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхыг бэхжүүлэх.</p> <p>-Байгаль орчны менежментийн 2020 оны төлөвлөгөөг холбогдох журмын дагуу бэлтгэн БОАЖЯ-аар батлуулсан.</p> <p>-Байгаль орчны анхан шатны үнэлгээг төслийн явцтай уялдуулан шинэчилж АХБ-нд хүргүүлсэн ба 2020 оны 6 дугаар сард АХБ-аас зөвшөөрөгдсөн.</p> <p>-Бохир усны насос станцын ашиглалт, хяналт, засвар үйлчилгээ, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа сэдэвт сургалтыг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулсан.</p> <p>- "Ариутгах татуургын шугам сүлжээний ашиглалт засвар үйлчилгээ, ашиглалтын үеийн Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалтуудыг УБ хотын Ус сувгийн Удирдах газрын инженерүүдийг оролцуулан цахимаар зохион байгуулсан нь үр дүнтэй сургалт болсон. Ажлын гүйцэтгэл 91 хувь.</p> <p>Төслийн хэрэгжилт 2020 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай байна.</p>	100
8.12	ЗГҮАХХАХТ-ний 2.91.2, 4.2.3 дахь	"Зүүн өмнөд говийн хот байгуулалт,	Төслийн хэрэгжилт, хувиар	60.0	63.9 Гадаад эх	<p>АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн МОН-3388, МОН-3713</p>	100

	заалт	хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл"-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх			үүсвэр	<p>төсөл"-үүдийн хүрээнд аймгийн төвүүдэд хоногт 3000 м3 ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байна. Үүнд:</p> <p>А. МОН 3388 төслийн хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Өвөрхангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг барилга угсралтын "Комфорт Импекс" ХХК гүйцэтгэж, 2018 оны 11 дүгээр сарын 15-нд байнгын ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл 100 хувь.</li> <li>2. Архангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг барилга угсралтын "ЧММ" ХХК гүйцэтгэж, 2019.10.15-нд байнгын ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл 100 хувь.</li> <li>3. Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг гүйцэтгэгч "Н Эй Би" ХХК, "Эс энд Эй трейд" ХХК, "Сан" ХХК, "Байгууламж" ХХК-ний түншлэл гүйцэтгэж байгаа бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувь.</li> <li>4. Дорноговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг "Эйч Эн Си барилга" ХК тус тус гүйцэтгэж байна. Гүйцэтгэгчээс гэрээний үүргээ биелүүлээгүй учир Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 03/2554 тоот албан бичгээр гэрээг цуцалсан. Барилгын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.</li> <li>5. Өвөрхангай аймгийн Хужирт суманд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг "Санжат" ХХК-тай 3,298,500,000 төгрөгийн дүнтэй гэрээг 2020 оны 6 дугаар сарын 18-нд байгуулсан. Цэвэрлэх байгууламжийн захиргааны барилгын өрлөгийн ажил хийгдэж дууссан. Механик цэвэрлэгээний барилгын багана суурийн цутгалтын ажил хийгдэж дууссан. Биологи цэвэрлэгээний тунгаагуурын хэсгийн цутгалтын ажил дууссан. Төвийн бохир усны шугамын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Ил явах төмөр бетон тулгуурын цутгалтын ажил хийгдэж байна. Нийт барилгын ажлын гүйцэтгэл 35 хувь.</li> </ol> <p>Төслийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 83.0 хувь.</p> <p>Б. МОН 3713 төслийн хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Булган аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр "Заг инженеринг" ХХК, "Престиж Инженеринг" ХХК, "Жиангсу Зэюү Энв Протекшн" түншлэл шалгарч, 2019 оны 05 дугаар сарын 07-нд ажил эхэлсэн, 2020 оны 10 дугаар сарын 28-нд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувь.</li> </ol>
--	-------	--	--	--	--------	---

					<p>2. Хөвсгөл аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр "Набсан" ХХК, "Эс энд Эй Трэйд" ХХК-ний түншлэл шалгарч, 2019 оны 06 дугаар сарын 11-нд ажил эхэлсэн 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар цэвэрлэх байгууламжийн барилгын ажил дууссан, гадна цэвэр ус, дулааны шугамын угсралт, Дулааны станц доторх узелийн нэмэлт тоног төхөөрөмжийн ажлууд хийгдэж дуусаад, дулаан авах бэлтгэлээ ханган ажиллаж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90 хувь.</p> <p>3. Хэнтий аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламж барих төслийн гүйцэтгэгчээр "Комфорт импекс" ХХК шалгарч, 2019 оны 08 дугар сарын 22-нд тус тус гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн. Захиргаа аж ахуйн барилга, харуулын байр, дэд өртөө, механик, үйлдвэрийн барилгуудын угсралтын ажлууд бүрэн дууссан. Механик цэвэрлэгээний блок болон үйлдвэрийн барилгын салхивчийн ажил, талбай доторх шугам сүлжээний угсралтын ажлууд тус тус хийгдэж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 65 хувьтай байна.</p> <p>4. Сүхбаатар аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг 2019 оны 12 дугаар сарын 30-нд байгуулсан. Дэд өртөөний барилга, үйлдвэрийн, захиргааны барилга, лаг боловсруулах цехийн барилгын угсралт, өрлөг, хучилтын цутгалтын ажил бүрэн дууссан. Бохир усны, дренажийн насос станцын <math>\pm 0,00</math> түвшнээс доош барилгын болон шугамын угсралтын, ханын дулаалгын ажил хийгдэж дууссан бөгөөд <math>\pm 0,00</math> түвшнээс дээших өрлөгийн ажил эхэлж байна. Цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралт, холбооны шилэн кабелийн ажил бүрэн дууссан. Лагийн талбай, элсний талбайн бетон цутгалтын ажил хийгдэж дууссан. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувь.</p> <p>5. Дундговь аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг 2019 оны 12 дугаар сарын 30-нд тус тус байгуулсан. Цэвэрлэх байгууламжийн бисологи цэвэрлэгээний блок, хонгилын барилгын хана, хучилтын цутгалт, захиргаа аж ахуй, сараалжийн барилгуудын угсралтын ажил, лаг, элсний талбайн бетон цутгалтын ажлууд дууссан. Бохир усны шугамын угсралтын ажил хийгдэж байна. Цэвэр усны 3.2 км шугамын угсралтын ажил дууссан. Бис-цөөрмийн далангийн газар шорооны ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна. Төслийн хэрэгжилт 70 хувьтай байна.</p>
--	--	--	--	--	---



8.13	ЗГҮАХХАХТ-ний 2.79.4 дэх заалт	Орон нутгийн хөгжлийг дэмжих бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах	Шинээр боловсруулж, батлуулах бодлогын баримт бичиг	1		<p>“Бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулах ажлын хүрээнд Үндэсний хөгжлийн газрын даргын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А-20 дугаар тушаалаар байгуулагдсан “Бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 165 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр А-56 дугаар тушаалаар Аргазүйн зөвлөл байгуулагдан “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын төслийг боловсруулсан.</p> <p>Улмаар Монгол Улсын Ерөнхий сайдын 52 дугаар захирамж, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 65 тушаалаар “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-2050”, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний төсөл” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж Бүсчилсэн хөгжлийн бодлогыг “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д “Бүс, орон нутгийн хөгжил” нэртэй нэг бүлэг болгон оруулсан. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлж, 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан.</p>	100
8.14	ЗГҮАХХАХТ-ний 2.91.5, 4.2.3 дахь заалт	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг дэвшилтэт технологиор шинэчлэх	Барилга угсралтын ажлын хувь	30.0	<p>199.8</p> <p>Гадаад эх үүсвэр</p> <p>14.0</p> <p>Улсын төсөв</p>	<p>Улаанбаатар хотод баригдах шинэ төв цэвэрлэх байгууламжийн эх загвар зураг батлагдсан. Нийт 35 объектын зураг төсөл боловсруулахаас барилгын 1 дүгээр ээлжийн 21 зураг хүлээн авсан. Зураг төслийн ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.</p> <p>Цэвэрлэх байгууламжийн орц, гарцын газар чөлөөлөх асуудлыг Сонгинохайрхан дүүргийн газрын албатай хамтран бүрэн шийдвэрлэсэн.</p> <p>Шинэ төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, барилгын материалыг татахтай холбогдуулж эхний ээлжид БНХАУ-ын төслийн удирдлага, инженер техникийн 45 мэргэжилтнийг ирүүлэх асуудлыг ЗГ-ын дэмжлэгтэй шийдвэрлүүлэн, барилгын ажлыг 2020 оны 12 сар хүртэл гүйцэтгүүлсэн. Барилгын талбайд барилга байгууламжийн суурийн бэлтгэл болох 11000 м3 хөрс хуулалтын ажил хийгдсэн.</p> <p>Төслийн барилга угсралтын бэлтгэл ажлын хүрээнд нийт 4000 гаруй тонн арматурыг БНХАУ-аас таталт хийгдэн барилгын талбай дээр буулгасан. Барилгын ажил эхэлснээс хойш 166.0</p>	100

						<p>мянган/м3 газар шорооны ажил хийгдэж, бетон зуурмагийн үйлдвэрт 3500 тонн цемент, 5000 м3 хайрга, 4300 м3 дайрга бэлтгэн барилга угсралтын ажилд ашиглаад байна. Нэгдүгээр аеротенк биологи цэвэрлэгээний сангийн хөрсний нягтруулалтын ажил /13000 м3/, ул бетоны цутгалтын ажил / 2170 м3 / бүрэн дуусгаад байгаа бөгөөд хавтан суурийн хийцлэлд 2560 тонн арматурчлал, суурийн бетоны цутгалтын нийт 16504.6 м3 бетоны ажил хийгдэж бетон цутгалт 100% хийгдээд байна. Хавтан суурийн арматурчлалын хийцлэлтэй хамт хана, далд багана, гадна худаг, хэв гажилтын заадас, ханын залгаасны хийцлэлийг угсарсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна.</p> <p>Төв цэвэрлэх байгууламжийн цахилгаан хангамжийн 35/10 кВ-ын 2х10 МВА-ын чадалтай дэд өртөөний зураг төслийг боловсруулах ажлын гэрээг ерөнхий гүйцэтгэгч "Чайна тисижу сивил инженеринг групп" ХХК, зураг төслийн "Ингүүмэл-Эрчим" ХХК-нуудын байгуулсан гэрээгээр зураг төслийн ажил хийгдэж байна. 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/-ын ажлын зураг дуусаж, төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн баталгаажуулах ажил хийгдэж байна.</p> <p>Эрчим хүчний яамны хөрөнгө оруулалтаар "Цэвэрлэх" дэд станцыг өргөтгөхөөр шийдвэрлэсэн. "ИХБ-4" болон 110/35/10 кВ-ын Борнуур дэд станцуудыг холбосон 110 кВ-ын 117 дугаар ЦДАШ-ын 24, 25, 26-р тулгуурууд төслийн нэгжийн барилгажих талбайд орсныг шилжүүлэн зөөх зураг төсөв боловсруулах ажил гүйцэтгэж байна.</p> <p>"Цахилгаан дамжуулах агаарын шугамын №24, №25, №26 завсрын тулгууруудыг өндөрлөгтэй анкер тулгуураар солих, трассыг зөөн шилжүүлэх ажлын зураг, төсөв боловсруулах" зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах тендер зарлан ажиллаж байна.</p>	
8.15	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 6, ЗГҮАХ-ийн 2.96 дахь заалт	Нийслэл, аймгийн төвийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил	Шугам сүлжээний урт, км	100.0	58.3 Улсын төсөв	<p>Аймаг, нийслэлийн инженерийн шугам сүлжээний хувьд: Нийслэл, аймгийн төвийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд улсын төсөвт нийтдээ 72.9 тэрбум төгрөг батлагдсанаас аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн он дамжин хэрэгжих 30 төсөл, арга хэмжээ арга хэмжээнд 48.3 тэрбум төгрөг санхүүжигдэхээр тусгагдсан. Шинээр барьж байгуулах 33 төсөл, арга хэмжээнд 16.7 тэрбум төгрөгийг тусгуулан, хэрэгжүүлэн ажиллалаа.</p>	100

					<p>Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад үүссэн (шугамын трасс өөрчлөх, газар чөлөөлөх, өмнөх жилүүдээс үлдсэн ажлуудыг дуусуулах, зураг төслийн шийдлээр зөвшөөрөлцөх зэрэг) асуудлаар бодлогын түвшинд шийдэл гаргаж, чиглэл, зөвлөмж өгч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80-90 хувьтай байна.</p> <p>Аймаг, нийслэлийн үерийн хамгаалалтын ажлын хувьд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр нийт 12 төсөл арга хэмжээ, 17.8 тэрбум төгрөг тусгагдсан. Үүнээс 7 аймагт 15.9 тэрбум төгрөгийн 8 төсөл арга хэмжээ, нийслэлийн 4 дүүрэгт 1.85 тэрбум төгрөгийн үерийн хамгаалалтын далан сувгийн 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа ба Баянзүрх 21, 27; Сүхбаатар 13, 14; СХД 21 дүгээр хороо; Налайх дүүрэгт үерийн хамгаалалтын далан, сувгийн барилга угсралтын ажил гэрээний дагуу гүйцэтгэж байна. Өвөрхангайн Хархорин, Орхон аймаг, Алтай хотын үерийн хамгаалалтын барилгын ажил бүрэн дуусаж ашиглалтад оруулсан. Үерийн далангийн барилгын ажлын гүйцэтгэл 80-90 хувьтай байна.</p> <p>Дээрх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 280 км инженерийн шугам сүлжээ /дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан, үерийн/-ний барилга угсралтын ажлыг гүйцэтгээд байна.</p>	
--	--	--	--	--	---	--

**Зорилт 9. Агаар, орчны бохирдлыг бууруулан, экосистемийн тэнцвэрт байдлыг хангаж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.**

9.1	МУТХҮБ-2030-ын 2.3.1, 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.6.1, 4.1.6.2, 4.1.6.5, 4.1.6.6 дахь заалт	"Агаар, орчны бохирдлыг бууруулах" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн сайжруулсан түлшний үйлдвэрлэл болон шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлын явц, хувиар	100.0	58.3 Улсын төсөв	2020 онд гэр хорооллын айл өрхөд шөнийн цахилгааны үнийн урамшуулалд 15.8 тэрбум төгрөг, сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж, хэрэглээнд хяналт тавихад 25.4 тэрбум төгрөг, нам даралтын усан халаалтын зууханд технологийн шинэчлэл хийх, зуухны янданд утааны шүүлтүүр суурилуулахад 1.8 тэрбум төгрөг, гэр хорооллын цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг сайжруулахад 0.6 тэрбум төгрөг, хог хаягдлын менежментийг сайжруулахад 3.3 тэрбум төгрөг, хог хаягдлыг бууруулах, сайжруулсан шахмал түлшний хэрэглээнд хяналт тавихад 2.8 тэрбум төгрөг, гэр хорооллын нүхэн жорлонг шинэчлэхэд 2.4 тэрбум төгрөг, нийтийн тээврийн автобусны утааг багасгах арга хэмжээ авахад 0.19 тэрбум төгрөг, мэдээлэл, сургалт сурталчилгаа хийхэд 0.87 тэрбум	90
-----	--	---	---	-------	------------------	--	----

				<p>төгрөг, дэвшилтэт техник технологийг дэмжихэд 0.89 тэрбум төгрөг, Улаанбаатар хотод агаарын бохирдлыг хянах 2 иж бүрэн автомат ажиллагаатай станц байгуулахад 1.8 тэрбум төгрөг, хоггүй цэвэрхэн Монгол аяныг өрнүүлэх арга хэмжээнд 1.5 тэрбум төгрөг, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах ТЭЗҮ болон барилгын ажилд 0.75 тэрбум төгрөг, зарим аймгуудын хог хаягдлын бууруулах арга хэмжээнд 0.2 тэрбум төгрөг нийт 24 арга хэмжээнд 58.3 тэрбум төгрөг зарцуулсан байна.</p> <p>Улаанбаатар хотын зүүн бүсэд сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж ашиглалтад оруулахаар Засгийн газрын 2020 оны 35 дугаар тогтролоор баталсан. "Тавантолгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний Зүүн бүсийн үйлдвэр 2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр ашиглалтад орсон. Жилд 600 мянган тонн сайжруулсан түлш үйлдвэрлэх тус үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг Тавантолгой ордоос төмөр замаар тээвэрлэхээр төлөвлөж байна. Тус үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэн нийслэлд хүргэх зорилгоор Төв аймгийн Баянзөрлөгийн өртөөнөөс 8.4 км төмөр замыг барьж байгаа бөгөөд барилга угсралтын ажил 70 хувьтай байна.</p> <p>"Байгалийн хийгээр цэнэглэх компрессорын станцын аюулгүй ажиллагаанд тавих шаардлага" MNS 6729:2018, "Байгалийн хийгээр ажилладаг автотээврийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага" MNS 6730:2018, "Автотээврийн хэрэгслийг байгалийн хийгээр цэнэглэх компрессорын станцын техник ашиглалтад тавих шаардлага" MNS6731:2018 үндэсний стандартыг боловсруулан батлуулж мөрдүүлснээр Байгалийн шахсан хий (CNG)-гээр ажилладаг автобусны тоо нэмэгдсэн.</p> <p>Шахмал түлшийг 10 хоногийн нөөцтэйгээр зорчигчийн вагоны халаалтын системийг хэвийн ажиллуулж байна.</p> <p>Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), азотын давхар исэл (NO<sub>2</sub>), PM 2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O<sub>3</sub>) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлж байна. Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын 2020 оны жилийн дундаж агууламжийг өмнөх оны дундаж агууламжтай харьцуулахад PM 10 тоосонцор 34 м<sup>3</sup>-ээр буюу 27 хувиар, PM2.5 тоосонцор</p>
		Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцрын агууламжийн бууралт, хувиар	20.0	



						<p>11мкг/м<sup>3</sup>-ээр буюу 18 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Улаанбаатар хотын нийтийн тээврийн их багтаамжийн автобусанд суурилуулсан Япон улсад үйлдвэрлэсэн DPF МОКОБИ СТ-3 шүүлтүүр нь автобуснаас ялгарах /PM/ тортогжилтийг 98 хувиар, БНСУ-д үйлдвэрлэсэн "ACTIVE DPF" шүүлтүүр 79.6 хувиар, "HYBRID DPF" шүүлтүүр 93.2 хувиар тус тус багасгаж байгааг туршилтаар тогтоогоод байна.</p> <p>Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр 2020 онд нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа дизель хөдөлгүүртэй их багтаамжийн 400 автобусанд утаа бууруулах төхөөрөмжийг ННТҮГ, "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТГ, "АТҮТ" ТӨҮГ-ууд хамтран суурилуулсан.</p> <p>Автомашин дизель хөдөлгүүрийг утааны тортогтийн шүүлтүүр (DPF)-ээр тоноглох, ашиглах, Техникийн ерөнхий шаардлага, MNS 6757: 2019 стандартыг боловсруулж батлуулсан. Одоогоор дизель хөдөлгүүртэй их багтаамжийн 24 автобусанд дээрх стандартын шаардлагыг хангасан шүүлтүүрийг суурилуулан ашиглаж байна. Эдгээр автобус нь Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд өдөр бүр ажиллаж, хөдөлгүүрээс ялгарах утааны PM 2.5 тоосонцрын агууламжийг 98 хувь хүртэл бууруулж байна.</p> <p>"Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга" MNS 5013:2009, "Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009" стандартуудад нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна.</p>	
9.2	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 1,  ЗГҮАХ-ийн 4.1.3, 4.1.4, 4.2.7 дахь заалт,  Төрөөс ойн	Ой хамгаалал, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулан ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Ойжуулалт, нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ, га	12000-аас багагүй	0.68  Улсын төсөв	<p>Улсын төсвийн хөрөнгөөр 930 га ойжуулалт, ойг нөхөн сэргээх, 350 га талбайд хомсдол доройтолд өртсөн ойд ойн цэвэрлэгээ хийх замаар нөхөн сэргээх, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 725 га, олон улсын төслийн хөрөнгөөр 3000 га, нийт 5005 га ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн.</p> <p>Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үр дүнд 15 аж ахуйн нэгжтэй 500 га ойжуулалтын ажил (Завхан аймагт 80 га, Хэнтий аймагт 80 га, Төв аймагт 50 га, Дорнод аймагт 140 га, Булган аймагт 20 га, Архангай аймаг 30 га, 12 аж ахуйн нэгжтэй 80 га ойн зурвас (Завхан аймагт 10 га, Төв аймагт 10 га, Ховд аймагт-40 га, Хөгнө-Тарнийн байгалийн цогцолборт газар-5 га, Өмнөговь аймагт 10 га, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт</p>	70

	талаар баримтлах бодлогын 3.1, 3.2, 3.3 дахь заалт					газар 5 га, Увс аймагт 5 га), 13 аж ахуйн нэгжтэй 500 га байгалийн сэргэн ургалтын ажил (Дорнод аймагт 100 га, Завхан аймагт 200 га, Хэнтий аймагт 40 га, Төв аймагт 80 га, Архангай аймагт 70 га, Булган аймагт 20 га) хийхээр ажил гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хөвсгөл аймагт-21.5 га талбайд, Завхан аймагт 30 га талбайд, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 70 га талбайд, Баян-Өлгий аймагт 5 га талбайд, Булган аймагт 150 га талбайд, Дархан-Уул аймаг 29 га талбайд, Говьсүмбэр аймаг 5 га талбайд, Дорнод аймаг 50 га талбайд, Хэнтий аймаг 20 га аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 140 га талбайд, Дундговь аймаг 5 га талбайд, Сэлэнгэ аймаг 280 га талбайд тус тус ойн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн байна.				
						Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мянган га		30-аас багагүй	0.33 Улсын төсөв	2020 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/602 дугаар тушаалаар ойн сан бүхий аймаг, сумын ойн санд ойн цэвэрлэгээний арга хэмжээг 31.5 мянган га талбайд хэрэгжүүлэхээр батлан аймаг, орон нутагт хүргүүлсэн. Үүний хүрээнд аймаг, сумын ИТХ-аас тогтоосон хэмжээнд ойн цэвэрлэгээг 31.5 мянган га талбайд хийхээр гэрээ байгуулан, талбайн тусгаарлалт хийн, ойн цэвэрлэгээ хийсэн. Мөн "Ойн цэвэрлэгээ хөтөлбөр"-ийн хүрээнд 450 га талбайд ойн цэвэрлэгээ хийсэн. Нийт 32 мянган га талбайд ойн цэвэрлэгээ хийгдсэн байна.
						Ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га		50-аас багагүй	0.41 Улсын төсөв	Ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг 2020 онд 416.1 сая төгрөгөөр нийт 65.8 мянган га талбайд хийж гүйцэтгэсэн. Үүнд: Тэмцлийн ажлыг хийсэн арга тус бүрээр авч үзвэл: Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Цагаан-Үүр, Түнэл сумд, Булган аймгийн Тэшиг сумдын ойн санд механик аргаар 41.7 мянган га талбайд, гэрлэн урхиар 19.2 мянган га талбайд, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Халиун, Өвөрхангай аймгийн Хархорин, Увс аймгийн Баруунтуруун, Хэнтий аймгийн Биндэр сумдын ойн санд үүргэн шуршигч багаж ашиглан микробиологийн аргаар тэмцлийн ажлыг 4900 га талбайд хийж, ажлыг бүрэн дуусгаад байна.
9.3	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 1,	Биологийн олон янз байдлын тухай болон цөлжилттэй тэмцэх	Биологийн олон янз байдалд чухал ач холбогдол бүхий газруудад	2-оос доошгүй	0.73 Улсын	2020 онд улсын төсвийн хөрөнгөөр газрын доройтлыг бууруулах, цөлжилтийг сааруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1."Монгол Улсын газрын доройтол, цөлжилтийн атлас зураглал" хийх ажлыг 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр гэрээг	100			

	ЗГҮАХ-ийн 4.2.9, 4.2.9.1, 4.2.9.3 дахь заалт	үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах	хамгааллын болон доройтлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо		төсөв,  0.2  Гадаад эх үүсвэр	<p>байгуулсан. Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрөөс 110.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Монгол Улсын газрын доройтол, цөлжилтийн 1:100000 масштабтай зураглалыг шинэчлэн боловсруулсан.</p> <p>2. Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд “5 га талбайд ойн зурвас” байгуулах ажлыг аймгийн сум дундын ойн ангитай 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 20/272 тоот гэрээг байгуулсан. Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрөөс 10.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сүмбэр суманд 5 га талбайд ойн зурвасыг байгуулж аймгийн Ойн ангид хүлээлгэн өгсөн.</p> <p>3. Өндөр уул, говийн бүсийн ашиглалтад өртөмтгий, устгах аюулд орсон зүйл ургамлын үрийн нөөц бий болгох ажлын гүйцэтгэгчээр Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн шалгарч 20/218 тоот гэрээ байгуулсан. Нийт 20 сая төгрөгийн санхүүжилтээр 113 зүйл ургамлын үрийн цуглуулга, нөөцийг бий болгосон.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах” төсөл Архангай, Говь-Алтай, Завхан аймгийн 13 суманд хэрэгжиж, 70.0 мянган долларын санхүүжилтээр бэлчээрийг зохистой ашиглах 48 малчдын бүлэг байгуулж, бэлчээрийн менежментийн сургалт явуулж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулан ашиглаж, зэрлэг амьтдын амьдрах газрыг малаас чөлөөлж, биологийн олон янз байдлыг хамгаалах ажлыг зохион байгуулав. Сумдын малчдын малын чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлж, малын тоог бэлчээрийн даацад тохируулах зорилгоор тус бүр 1 малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулж, тухайн орон нутагт үржүүлж буй батлагдсан үүлдэр, омгийн малын стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой үржлийн малыг өсгөн бойжуулж, малчдад нийлүүлэх, мал үржлийн ажил үйлчилгээ үзүүлэх, сүргийн эргэлтийг зөв төлөвлөж, орлогыг нэмэгдүүлнэ. Аймгууд 2020 онд 4.9 сая га доройтсон бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулав.</p> <p>“Тариалангийн талбайн хөрсний үржил шим, чийгийг нэмэгдүүлэх экологижсон арга, туршлага нэвтрүүлэх” зөвлөх</p>
--	--	---	---	--	---	---

					<p>үйлчилгээний ажлыг Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэнгээр гүйцэтгүүлэв. Хөрсний үржил шимийг сайжруулах ногоон бордуурт ашиглах 12 төрлийн таримал ургамлын харьцуулсан туршилт судалгааны ажлыг гүйцэтгэсний зэрэгцээ биологийн олон янз байдлыг хамгаалах, байгаль орчинд ээлтэй аргаар хөрсний чийг, агаар нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, хог ургамалтай тэмцэх технологийн зөвлөмж боловсруулсан. Төслийн туршилтын талбайд "Хөрсний үржил шим, чийгийг нэмэгдүүлэх ногоон бордуур сэдэвт" үзүүлэх 200 хүний сургалт зохион байгуулж хөрс хамгаалах, газрын доройтлыг экологичсон аргаар сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалахын ач холбогдлын талаар танилцуулга хийсэн. Тариалангийн талбайн хөрсний үржил шим, элэгдэл эвдрэлийг хянах зорилтын хүрээнд тариалангийн хөрсний мониторингийн сүлжээ байгуулах, сүлжээний байршлын болон агрохимийн картограммын зураглалыг боловсруулан www.monsoil.mn цахим хуудсанд байршуулав.</p>		
9.4	МУТХУБ-2030-ын 2.3.1, Зорилт 1, 2, ЗГҮАХ-ийн 4.2.3, 4.2.4, 4.2.5 дахь заалт	Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах,	Хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлын тоо	5	<p>0.6</p> <p>Улсын төсөв</p> <p>0.24</p> <p>Гадаад эх үүсвэр</p>	<p>"Майдар хот төсөл"-ийн ус хангамжийн эх үүсвэрийг илрүүлэн тогтоох газрын доорх усны ордын хайгуулын ажлыг "Майдар эко хот төсөл" хэрэгжих талбайд "Дунар Од" ХХК, "Грандэлектротехноком" ХХК-иуд амжилттай хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажилд хяналт тавьж, үр дүнгийн тайланг 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ТНБД-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны А/466 тоот тушаалаар "Майдар хот"-ын унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт Туул голын хөндийн "Өтгөрүүгийн тохой"-н газрын доорх усны ордын нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр 85.0 л/с буюу 7344.0 м<sup>3</sup>/хоногоор нөөцийг баталсан. Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс 608.7 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Өвөрхангай аймгийн Хужирт суманд Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж байгаа L388-MON төслийн нэмэлт санхүүжилтээр /243.0 сая төгрөг/ хийгдэж байгаа Хужирт сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажилд хяналт тавьж, үр дүнгийн тайланг усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, усны нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр 18.0 л/с-ээр баталсан.</p>	50



		булаг, шандын эхийг хашиж хамгаалах	Шинээр хийх гидрогеологийн зураглалын тоо /1:200000 масштаб/	1	-	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй тул хэрэгжих боломжгүй.	
			Шинээр байгуулах хөв, цөөрмийн тоо	3-аас доошгүй	0.56 Улсын төсөв	2020 онд 123.9 мянган м3-ийн эзлэхүүнтэй 6 хөв, цөөрмийн барилга угсралтын ажлыг Хэнтий, Говь-Алтай, Өмнөговь болон Улаанбаатар хотын Налайх дүүрэгт хийж гүйцэтгээд байна. Хөв, цөөрөм барих ажилд нийт 562.5 сая төгрөг зарцуулсан. Эдгээрээс Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд баригдсан 56.0 мянган м3 эзлэхүүнтэй хөвийг улсын төсвийн 98.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Говь-Алтай аймгийн Баян-Уул сум, Тайшир сум болон Өмнөговь аймгийн Номгон сум дахь хөв цөөрмүүдийг барихад 230.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн. Говь-Алтай аймгийн Дарви суманд баригдсан хөвийг Дэлхийн байгаль хамгаалах сангаас 58.4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн бол Улаанбаатар хотын Налайх дүүрэгт 174,8 сая төгрөгийг Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн зардлаас гаргаж 3700 м3 эзлэхүүнтэй хөв цөөрөм барьсан.	
			Эхийг хамгаалах булаг, шандын тоо	100-аас доошгүй	0.45 Улсын төсөв	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан "Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх тухай" 2020 оны гэрээнд нийт 120-иос доошгүй булаг, шандын эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг тусгуулсан. Үүний үр дүнд 21 аймагт нийт 120 булаг шандын эхийг улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөрөөс нийт 453.1 сая төгрөг зарцуулан хашиж хамгаалсан байна. Үүнээс 18 сая төгрөгийг улсын төсвөөс, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 106.3 сая төгрөг, хувийн хэвшил төсөл хөтөлбөр, хандиваар 92.3 сая төгрөг, 236.4 сая төгрөгийг сум, орон нутгийн төсвөөр санхүүжүүлсэн байна.	
9.5	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.4.1 дэх заалт	Аялал жуулчлалын дэд бүтэц, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлж, тог	Жуулчдын тооны өсөлт, хувиар	15.0-аас доошгүй	2.1 Улсын төсөв	"Ковид-19" цар тахал гарсан тул Монгол Улс өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, гадаад жуулчдын урсгалыг бүрэн зогсоосон. Цар тахлын нөлөөгөөр дотоодын аялал жуулчлалын урсгал 2020 оны 5-10 дугаар саруудад 50 гаруй хувиар нэмэгдэж, нийт аялсан жуулчдын тоо давхардсан тоогоор 800 гаруй мянга байна. Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан дотоодын жуулчдын гол урсгал төвлөрсөн Өгий нуур, Тэрхийн цагаан нуур, Чух нуур, Онон балжийн ТХГН, Отгонтэнгэрийн ТХГН, Хар ус нуур, Увс нуур, Хяргас нуур зэрэг нийт 17	0

		твортой аялал жуулчлалыг хөгжүүлэх				байршилд нэгдсэн зогсоол, стандарт хангасан ариун цэврийн газар бүхий отогдох цэгүүдийг байгууллаа. Мөн жуулчдын аюулгүй аялах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд аялал жуулчлалын замын тэмдэглэгээ, самбаруудыг Архангай аймгийн, Булган, Ихтамир, Өндөр-Улаан, Цахир, Тариат, Хангай, Чулуут, Жаргалант сумдад нэгдсэн стандартын дагуу хийх ажлын гүйцэтгэлийг 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/727 дугаар захирамжаар самбар угсралтын ажлыг хүлээж авлаа. Үйлчилгээний чанарыг сайжруулах хүрээнд Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг нийслэл хот болон 21 аймгийн хэмжээнд зөөгч, бар тендер, бариста, өрөөний болон гэрийн үйлчлэгч, тогооч, жолооч, ачаа зөөгч хаалгач, удирдах ажилтан зэрэг 10 мэргэжлээр 2020 оны 9 дүгээр сарын 14-өөс 11 сарын 26-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус сургалтад улсын хэмжээнд нийт 16 мянга гаруй иргэдийг “үнэ төлбөргүй” хамруулж, амжилттай хамрагдсан иргэдэд гэрчилгээ олгож, <a href="http://www.travelhubmongolia.com">www.travelhubmongolia.com</a> цахим хүний нөөцийн системд бүртгэв. Азийн Хөгжлийн Банкны 38 сая ам.долларын зээл “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Хөвсгөл аймагт жуулчдад зориулсан мэдээллийн төв, нэвтрэх цэг, автобус болон авто машины зогсоол, хатуу, шингэн хог хаягдлын цэвэрлэх байгууламж, жуулчны гудамж болон 37.9 км замыг барих бол Хэнтий аймагт Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор, цогцолборыг холбох явган хүний зам болон авто машины зогсоол, цогцолборын дагалдах байгууламжууд, шингэн хог хаягдлын цэвэрлэх байгууламж барина.	
--	--	------------------------------------	--	--	--	---	--

**Зорилт 10. Гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гамшгийн үеийн бэлэн байдлын түвшинг дээшлүүлнэ.**

10.1	МУТХҮБ-2030-ын 2.3.2, Зорилт 1, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө /цаашид	Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах салбар, бүлгийн чадавхыг бэхжүүлэх	Шинээр байгуулах салбар, нэгжийн тоо	1	4.8  Улсын төсөв	Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах салбар, бүлгийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд: - Увс аймгийн Онцгой байдлын газрын Баруунтуруун сум дахь аврах, гал түймэр унтраах 60 дугаар ангийн барилгын ажлыг “Нью сувагт констракшн” ХХК гүйцэтгэж, 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдөр улсын комисс ашиглалтад хүлээн авсан. - Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, 2020 онд 2.4 тэрбум төгрөгийг санхүүжилтийг олгосон бөгөөд 27.0 хувийн гүйцэтгэлтэй байна.	50
------	--	--	--------------------------------------	---	------------------------	---	----

	ГХТББХХТ гэх/-ний 5.10, ЗГҮАХ-ийн 4.3.3 дахь заалт					<ul style="list-style-type: none"> <li>- Алба хаагчдын ажлын байр, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Онцгой ерөнхий газрын завсар, соёлын төв, шалган нэвтрүүлэх байр, зарим өрөөний засварыг хийж гүйцэтгэсэн.</li> <li>- ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төв-113 дугаар ангийн тохижилт, СХД-ийн гал түймэр унтраах, аврах 26 дугаар анги, Багануур дүүрэг, Дундговь, Хөвсгөл, Өвөрхангай гал түймэр унтраах, аврах анги, онцгой байдлын газрын барилгын засварыг хийж гүйцэтгэсэн.</li> <li>- Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Өвөрхангай, Хэнтий аймгийн эрэн хайх аврах салбарын барилгын цэвэр бохир усны холболтын ажил, төв орон нутгийн онцгой байдлын анги байгууллагын тавилга, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн засварыг гүйцэтгэсэн байна.</li> </ul>	
10.2	Гамшгийн эрсдэлийг бууруулах сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн 2.5.1, ГХТББХХТ-ний 1.12, 5.4, 5.10, ЗГҮАХ-ийн 4.3.3, Гамшга ас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.2.5 дахь заалт	Онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах	Техник, тоног төхөөрөмжийг сайжруулах төслийн тоо	3-аас багагүй	3.4 Улсын төсөв 134.3 Гадаад эх үүсвэр	<p>Онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг түргэн шуурхай гүйцэтгэх, тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын нийт 27 нэгжид 254 ширхэг амьсгалын бие даасан төхөөрөмж, 24 нэгжид 35 ширхэг аврах ажиллагааны иж бүрэн багаж, 18 нэгжид Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн тоног төхөөрөмж, 40 ширхэг амьсгалын бие даасан төхөөрөмж цэнэглэх шахуурга болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулсан.</li> <li>- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний дагуу 14 нэр төрлийн нийт 71 автомашин 3 үе шаттайгаар нийлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр гал түймэр унтраах, аврах тусгай тоноглол бүхий 56 автомашин нийлүүлэгдсэн.</li> <li>- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн зээлийн хэлэлцээрийн хүрээнд гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин, техникийг нийлүүлэх гэрээг 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Бүгд Найрамдах Франц Улсын "Десотел сас" компанитай байгуулсан. Уг төслийн хүрээнд 2021-2022 онд 4 нэр төрлийн 42 нэгж автомашин нийлүүлэгдэх бөгөөд 2020 оны 4 дүгээр</li> </ul>	100



						<p>сарын 30-ны өдөр автомашин, техник нийлүүлэх гэрээ хүчин төгөлдөр болсон. Дээрх хэлэлцээрийн дагуу "Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх" төслийн хүрээнд ЕС-145 маркын 3 нисдэг тэрэг, сургалтын 1 кабри нисдэг тэрэг нийлүүлэх бөгөөд 16 нисгэгч, 15 инженер, техникийн ажилтныг сургаж ажлыг 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс эхэлсэн. Төслийн хүрээнд нийлүүлэх нисдэг тэрэг 2020 оны 11 дүгээр сард Монгол Улсад тээвэрлэгдэж ирэх төлөвлөгөөтэй байсан боловч коронавирус цар тахлын улмаас хойшлогдсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>- НҮБ-ын Дэлхийн Хүнсний Хөтөлбөр (ДХХ) байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн "Ган зудын эрсдэлийн мониторингийг сансраас ажиглалтын мэдээлэл ба технологийн платформын тусламжтай сайжруулах нь" төслийн үйл ажиллагаа 2020 оны 5 дугаар сарын 30-ны өдөр дууссан бөгөөд төслийн хүрээнд ДХХ байгууллагын боловсруулсан бодит цаг хугацаанд суурилсан мэдээллийн платформ (PRISM)-ыг ОБЕГ-т нэвтрүүлсэн. Төслийг хэрэгжүүлснээр хөдөө аж ахуй, ус цаг уурын мэдээллийг орон нутагт олдоц сайтай байдаг нийгэм-эдийн засгийн мэдээлэлтэй уялдуулан гамшгийн нөлөөг үнэлэх, хянах боломжтой болсон.</li> <li>- Дэлхийн зөн ОУБ нь НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас санаачилсан "Гамшигт тэсвэртэй хотуудыг бий болгоё" санаачилгын хүрээнд хот, суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн мөнөжмөнтийг сайжруулах, даван туулах чадавхыг бэхжүүлж, "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцотой бууруулах" үндэсний хөтөлбөрт хувь нэмрээ оруулах үүднээс "Гамшигт тэсвэртэй хотууд" төслийг 2016-2020 онд Улаанбаатар хот болон Орхон аймагт амжилттай хэрэгжүүлсэн.</li> </ul>
--	--	--	--	--	--	---

**ДӨРӨВ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО**

**Зорилт 11. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтын орчин болон дэд бүтцийг бүрдүүлнэ.**

11.1	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, чанар	Хамран сургалтын бохир жин, хувиар	86.0	98.9	Монгол Улсын хэмжээнд 2-5 насны сургуулийн өмнөх боловсролын 309.6 мянган хүүхэд байгаагаас 2020-2021 оны хичээлийн жилд 1454 цэцэрлэгт нийт 247,040 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 79.7 хувь болж өмнөх оноос 4.5 хувиар буурсан дүнтэй байна. "Ковид-19"-өөс шалтгаалан өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалт эхэлсэн ч, 9 дүгээр сарын 21-ний өдрөөс цэцэрлэгт 2 настай хүүхдийг элсүүлсэн нь 2020-2021 оны	70
					Улсын төсөв		



	3.2.2.1 дэх заалт	хүртээмжийг дээшлүүлэх	Шинээр ашиглалтад оруулах цэцэрлэгийн тоо	42		хичээлийн жилд хамран сургалт буурахад нөлөөлсөн. 2020 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт 5265 хүүхдийн хүчин чадал бүхий 42, нийслэлд 4050 хүүхдийн хүчин чадал бүхий 21, нийт 63 цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон. Барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 89 цэцэрлэг байгаагаас 70-95 хувийн гүйцэтгэлтэй 27 цэцэрлэг, 50-69 хувийн гүйцэтгэлтэй 6 цэцэрлэг, 30-49 хувийн гүйцэтгэлтэй 18 цэцэрлэг, 10-29 хувийн гүйцэтгэлтэй 13 цэцэрлэг, 10 хувиас доош гүйцэтгэлтэй 25 цэцэрлэг байна.	
11.2	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.3, 3.2.6 дахь заалт	Ерөнхий боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, сурагчдын ая тухтай сурах орчныг бүрдүүлэх	Шинээр ашиглалтад орох сургуулийн тоо	66	68.6 Улсын төсөв	2020 оны жилийн эцсийн байдлаар 10680 хүүхдийн хүчин чадалтай 31, гадаадын тусламжаар 6, нийт 37 сургууль ашиглалтад орсон байна. Мөн Хятадын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 3, Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 3 нийт 6 сургууль ашиглалтад бүрэн орсон. Барилга угсралтын ажил нь үргэлжилж байгаа 92 сургуулийн барилга байна. Үүнд 70-95 хувийн гүйцэтгэлтэй 25 сургууль, 50-69 хувийн гүйцэтгэлтэй 14 сургууль, 30-49 хувийн гүйцэтгэлтэй 22 сургууль, 5-29 хувийн гүйцэтгэлтэй 26 сургууль, 4-өөс доош хувийн гүйцэтгэлтэй 5 сургуулийн барилга байна. 2020 онд 22 дотуур байрыг ашиглалтад оруулсан бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцаас 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай дотуур байрыг 30-аар нэмэгдүүлсэн.	50
			Стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай дотуур байрын тоо	46			
11.3	МУТХҮБ-2030-	Ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд тохирсон	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан багшийн тоо	60	0.1 Улсын төсөв 1.3 Гадаад эх үүсвэр	2019-2020 оны хичээлийн жилд Тэгш хамруулан сургах боловсрол онлайн курст 2137 багш, сургалтын байгууллагын удирдах ажилтан мэргэжил арга зүйн сургалтад хамрагдсан. Мэргэжил дээшлүүлэх танхимын сургалтаар 10 дахь жилдээ ажиллаж буй нийт 14 мэргэжлийн 1200, 5 дахь жилдээ ажиллаж буй 13 мэргэжлийн 722, эхний жилдээ ажиллаж буй 13 мэргэжлийн 1360, нийт 3291 багш ажилтнуудад тэгш хамруулан сургах боловсролын агуулга сэдвээр 112 цагийн хичээл бэлтгэн зааж, мэдлэг ойлголт, арга зүйн хөгжлийг нь дэмжлээ.	70

	ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.14, 3.3.29 дэх заалт	сургалтын орчин болон дэд бүтцийг бүрдүүлэх	Тохирох орчин бүрдүүлсэн сургуулийн тоо	63		Японы хүүхдийг ивээх сангаас Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Өвөрхангай, Ховд аймгийн 12 сургууль, 3 насан туршийн боловсролын төвд, НҮБ-ын хүүхдийн сангаас Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгийн 9 сургуульд, "Жайка" олон улсын байгууллагаас Улаанбаатар хотод 12 сургуульд тус тус хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн танхим байгуулсан. Мөн нийслэлийн 10, 186 дугаар тусгай цэцэрлэгүүдэд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, цэцэрлэг тус бүрд автобус олгосон. Дэлхийн банкны санхүүжилттэй хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29, 116 дугаар сургуульд сургалтын тусгай хэрэгсэл нийлүүлсэн байна. Мөн нийслэлийн 25, 29, 55, 63, 70 дугаар сургуулиудад дээрх төслийн хүрээнд тайвшруулах өрөө, өдөр өнжүүлэх анги, хөдөлмөрийн хичээлийн дадлагын танхимыг байгуулсан.	
11.4	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.10 дахь заалт	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Нөхөн хангалтаар хэвлүүлэх сурах бичгийн төрөл	138	3.3 Улсын төсөв 7.4 Гадаад эх үүсвэр	2020-2021 оны хичээлийн жилд 110 нэрийн 1,366,277 ширхэг сурах бичиг хэвлэн ерөнхий боловсролын сургуулийн номын санд нийлүүлсэн. Мөн Азийн хөгжлийн банкны туслалцаатай хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-ийн санхүүжилтээр нийт 98 нэрийн 2,735,000 ширхэг дунд, ахлах ангийн сурах бичгийг хэвлүүлэн ерөнхий боловсролын сургуулийн номын санд нийлүүлсэн. Мөн тусгай хэрэгцээт боловсролын сургуулийн номын санд брайл сурах бичиг, цахим /daisy-e-pub/ сурах бичиг, цахим /daisy-e-pub/ ном уншигчийг нийлүүлэх ажлыг зохион байгуулсан.	90
11.5	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.2.18 дахь заалт	Судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлж, дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийг дэмжих	Мэргэжил дээшлүүлэх багшийн тоо	700		Судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлж, дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийг дэмжих зорилгоор 2020 онд 7 төрлийн сургалт зохион байгуулж, нийт 1225 багшийг хамруулсан. Монгол Улсын их, дээд сургуулиудын судалгаа, инновацын чадавхыг хөгжүүлэх зорилготой "ЕХ-ны Ерасмус+" хөтөлбөрийн санхүүжилттэй "ARROW" төслийн хүрээнд МУИС, АШУУИС, МУБИС, ХААИС, СЭЗИС, ХУИС, УБИС, ОТИС, Шинэ Монгол Технологийн Дээд Сургууль, Хэл Иргэншлийн Дээд Сургууль, Цэцээ Гүн Менежментийн Дээд Сургууль, Хангай Дээд Сургууль гэсэн 12 их, дээд сургууль тус бүрээс 15 багш, судлаач буюу нийт 180 багшийг хамруулан "Их сургуулийн мэдлэгийн дамжуулалт" цахим сургалтыг 2020 оны 02 дугаар сарын 17-ноос 03 дугаар сарын 17-ны хооронд зохион байгуулсан. Сургалтаар Мэдлэг дамжуулалтын үндсэн ойлголт, их сургууль, бизнесийн түншлэл ба инновацын хөгжүүлэлт, Оюуны өмчийн хамгаалалт, Испани	100

						улсад ашиглаж буй хамтын ажиллагааны хэлбэрүүдийн туршлага гэсэн сэдвийн хүрээнд зохион байгуулав. Мөн АХБ-ны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл ба Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын олон улсын сүлжээтэй хамтран "Чанарын дотоод баталгаажуулалт" сэдэвт цахим сургалтыг 05 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд их, дээд сургуулийн 300 багшийг оролцуулан зохион байгуулсан.	
11.6	ЗГҮАХ-ийн 3.2.20 дахь заалт	Хөдөө орон нутгийн их, дээд сургууль, салбар сургуулиуд түүнд элсэгчдийг дэмжих	Хөдөө орон нутгийн их, дээд сургууль, салбар сургуульд суралцагчдын тооны өсөлтийн хувь	5.0		2020-2021 оны хичээлийн жилд хөдөө орон нутгийн их, дээд сургууль, салбар сургуульд 3700 оюутан суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилээс 32.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд, АШУУИС-д 3202, СУИС-д 292, ХААИС-д 206 оюутан суралцаж байна.	100
11.7	МУТХҮБ-2030-ын 2.2. 3, Зорилт 1, 2, 3, ЗГҮАХ-ын 3.2. 10 дахь заалт	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын сургуулийн багшийг зөврийн компьютертэй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	6.0 Улсын төсөв	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад тендерт шалгарсан "Саммит компьютер технологи" ХХК, "Ай ти зон" ХХК-тай гэрээ байгуулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/266 дугаар бүхий тушаалаар баталсан хуваарийн дагуу 21 аймаг, 9 дүүргийн нийт 1534 байгууллагын 3275 үндсэн багшид зөврийн компьютер олгосон.	100
<b>Зорилт 12. Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын салбарт техник, технологийн ололтыг нэвтрүүлнэ.</b>							
12.1	ЗГҮАХ-ийн 3.2.47, 3.2.49, 3.2.53, 3.2.54 дэх заалт	Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Шинээр ашиглалтад оруулах соёлын төв, музей, театрын тоо	41	90.4 Улсын төсөв	2020 оны жилийн эцсийн байдлаар 39 соёлын төв, 2 театр, 2 музей нийт 43 барилга байгууламж бүрэн ашиглалтад орж, 6 соёлын төв, 1 театр, 4 музей 11 барилгын ажил үргэлжилж байна.	70



			Шинээр ашиглалтад оруулах спорт цогцолбор, ордон, заал, усан бассейны тоо	15		2020 оны жилийн эцсийн байдлаар Дорноговь аймгийн Өргөн сумын, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын, Булган аймгийн Хангал сумын, Дорнод аймгийн Чулуунхороот сумын спорт заалны барилга, Завхан, аймгийн Улиастай сумын спорт цогцолборын барилга, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Усан бассейны барилга, Сайншанд сумын 1000 хүний суудалтай соёл, спортын цогцолбор, Улаанбадрах сумын соёл, спортын төвийн 200 хүний суудалтай барилга, Хөвсгөл сумын 200 хүний суудалтхай соёл, спортын төвийн барилга, нийт 9 барилга тус тус ашиглалтад орсон байна. Мөн 70-90 хувийн гүйцэтгэлтэй 7 барилга, 50-69 хувийн гүйцэтгэлтэй 14 барилга, 30-49 хувийн гүйцэтгэлтэй 5 спорт цогцолбор, ордон, заал, усан бассейны барилга байна.	
12.2	ЗГҮАХ-ийн 3.2.43 дахь заалт	Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан Байгалийн түүхийн музейг шинээр барих	Ашиглалтад орох музейн барилгын тоо	1	-	Засгийн газраас Байгалийн түүхийн музейн барилгыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Их тэнгэрийн аманд баригдаж байсан "Үндэсний хурлын танхим, аялал жуулчлал, зочид буудлын цогцолбор"-ын дуусаагүй барилгыг музейн зориулалтаар ашиглах шийдвэрийг гаргаж, зураг төсвийг шинэчлэн боловсруулсан. Дуусаагүй барилгын гүйцэтгэл музейн зураг төслийн харьцуулсан дүнгээр 25 орчим хувийн гүйцэтгэлтэй юм.	30
12.3	ЗГҮАХ-ийн 3.2.59 дэх заалт	Үндэсний соёл урлагийг дэмжих хүрээнд Үндэсний урлагийн Их театр шинээр байгуулах	Ашиглалтад орох их театрын тоо	1	-	Үндэсний урлагийн их театр барих газрын зөвшөөрөл, барилгын зураг төслийн эскиз гарч, нийт 42.000 кв талбайтай, 2500 хүний их танхим, 1500 хүний дуулалт жүжгийн танхим, 800 суудал бүхий хөгжмийн танхим, 400 хүний суудалтай олон зориулалтын заал бүхий хүчин чадалтай Үндэсний урлагийн цогцолбор баригдахаар төлөвлөсөн. Нийслэлийн засаг даргын захирамжаар газар эзэмших зөвшөөрөл гарсан, барилгын зураг төслийг Бьюлдингс Технологи ХХК хийж, загвар зургийг Соёлын яаманд батлуулахаар хүргүүлсэн. УСУГ-аас цэвэр бохир ус, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-аас холбооны техникийн нөхцөлүүд авч, Эрчим хүчний яамнаас цахилгаан дулааны техникийн нөхцөлүүдийн бэлтгэл ажил хангагдсан.	0



12.4	ЗГҮАХ-ийн 3.2.46 дахь заалт	Үндэсний бажархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхэн сэдэвтэй кино, бүтээл туурвихад төрөөс дэмжлэг үзүүлэх	Түүхэн сэдэвт уран бүтээл туурвих ажлын явц, хувиар	100.0	0.015  Улсын төсөв	Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн, дипломатч, Төрийн шагналт Цэндийн Намсрайн амьдрал үйл хэргийг мөнжүүлэх зорилгоор "Цэндийн Намсрай" баримтат кино бүтээхэд Боловсрол, соёл, шинжлэх ухаан сайдын 2020 оны А/183 дугаар тушаалаар 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Баримтат киног "Монгол кино нэгтгэл" ТӨААТҮГ-р гүйцэтгүүлэн акт үйлдэж хүлээн авсан. Мөн Үндэсний урлагийн их театрын 70 жилийн ойн арга хэмжээнд зориулж ардын урлаг болон театрын уран бүтээлийн танилцуулга 64 богино хэмжээний контент, бүрэн хэмжээний 10 цуврал тоглолтуудыг хийж, цахимаар болон өргөн нэвтрүүлгийн телевизийн 11 сувгаар түгээсэн.	100
12.5	ЗГҮАХ-ийн 3.2.52 дахь заалт	Эх орноо төлөөлөн Токио-2020 олимпын наадамд оролцох баг, тамирчдын бэлтгэл, үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	20  Улсын төсөв	"Ковид-19" цар тахлын улмаас "Токио-2020" зуны олимп, паралимпийн наадам зохион байгуулагдах хугацаа хойшилсон бөгөөд Улсын онцгой комиссын зөвшөөрлийн дагуу халдвараас хамгаалах урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэм, шаардлагыг ханган Үндэсний шигшээ багийн бэлтгэл дасгалжуулалтын үйл ажиллагааг явуулж, олимпын наадмын эрх олгох болон эрхийн оноо цуглуулах тэмцээнүүдэд оролцож байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар олимпын 11 эрх, паралимпийн 5 эрх аваад байна. Олимпын наадамд оролцох баг тамирчдын спортын хувцас хүлээн авсан, харин ёслолын хувцсыг олимпын наадамд оролцох эрх авсан тамирчид нэрс баталгаажих хүртэл хүлээгдэж байна.	100
12.6	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.44, 3.2.48 дахь заалт	Соёлын баримтат өвийг хамгаалах, музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалтын ажлыг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.048  Улсын төсөв	2020 онд Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлах газар, Монголын Үндэсний музейн сэргээн засварлах лабораторид нийт 300 орчим дурсгалт зүйл, археологийн олдворыг сэргээн засварласан.	100
12.7	МУТХҮБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.44, 3.2.47 дахь заалт	ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн бүртгэлд бүртгэгдсэн Монгол Улсын соёлын өвийг хамгаалах, Бурхан Халдун	Шинээр байгуулах менежментийн захиргааны тоо	1	0.158  Улсын төсөв	Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Бурхан Халдун уулын түүний хүрээлсэн тахилгад газар нутгийн хамгаалалтын захиргааны дүрмийг баталж, 2020 оны 4 дүгээр сард уг захиргааг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан. БСШУС-ын сайдын 2020 оны 04 сарын 03-ны өдрийн Б/30 тушаалаар хамгаалалтын захиргааны даргыг томилж, 2020 онд улсын төсвөөс хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд зориулан 158.0 сая	100

		уулын соёлын өвийн менежментийн захиргааг байгуулах				төгрөгийг баталж, менежментийн захиргааны үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	
<b>Зорилт 13. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааг өргөжүүлнэ.</b>							
13.1	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 3.2.19, 3.2.30 дахь заалт	Шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлж, судалгаа боловсруулалтын ажлын эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	Технологи бүтээгдэхүүний загварын тоо	300	4.0 ШУТС	2020 оны жилийн эцсийн байдлаар судалгаа боловсруулалтын нийт 145 ажлын тайланг хүлээн авсан. Эдгээр судалгаа боловсруулалтын ажлуудын үр дүнд 211 ном, 57 шинэ бүтээл, 48 шинэ технологи, 27 тоног төхөөрөмж, 59 зөвлөмж, 83 заавар, 12 патент, 4 ТЭЗҮ, 21 ашигтай загвар, 1405 эрдэм шинжилгээний өгүүлэл, 33 стандарт, 89 аргачлал боловсруулагдсан байна. Нийт хүлээн авсан үр дүн 2049 байгаагаас технологи, бүтээгдэхүүний загвар 406 байна. 2020 онд нийт 490 төсөл хэрэгжсэнээс 159 нь шинээр эхэлсэн байна.	100
13.2	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 3.2.29 дэх заалт	"Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийг боловсруулж, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоох	Батлагдсан хөтөлбөрийн тоо	1		Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 33 дугаар тогтоолоор "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дүгээр сарын 18-ны өдрийн 95 дугаар тогтоолоор "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-ийг тус тус батлуулан хэрэгжүүлж байна.	100
13.3	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1, 4.3 дэх заалт	Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний гено банканд	Ботаникийн цэцэрлэгийн тохижилтын ажлын гүйцэтгэл, хувиар	100	0.02 Улсын төсөв	Ботаникийн цэцэрлэгийн гүний худгийг сэргээн засварлах ажлыг 2019 онд хийж гүйцэтгэсэн. 2020 онд нэн ховор, ховор 20 зүйл ургамлыг нэмж тарималжуулсан. Байгалийн ургамлын үндэсний гено банкны ургамлын дижитал гер барын сан үүсгэх ажлын гүйцэтгэгчээр Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн шалгарч 20/178 тоот гэрээ байгуулсан. Нийт 29.9 сая төгрөгийн санхүүжилтээр 9000 ургамлын дижитал гер барын санг үүсгэсэн.	30

		шаардлагатай барилгыг барих	Байгалийн ургамлын үндэсний гено банкны барилгын ажлын гүйцэтгэл	100		Шинжлэх ухаан инновацын кластер" цогцолборын 4 давхарт 250м2 талбайд Гено банк байршуулахаар зураг төсөл батлагдсан. 2020 онд барилгын ажлын шав тавих ёслол болсон.	
13.4	МУТХҮБ-2030-ын 2.3.3, Зорилт 5, ЗГҮАХ-ийн 3.2.33 дахь заалт	Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэн, төвүүдийн техник, тоног төхөөрөмж, компьютерийг шинэчлэн нийлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	1.3 Улсын төсөв	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинжлэх ухааны байгууллагуудад 200 ширхэг суурин компьютер нийлүүлэх 405.9 сая төгрөгийн гэрээг "Ай ти зон" ХХК-тай байгуулж, шинжлэх ухааны салбарын нийт 25 байгууллагад нийлүүлэв. Шинжлэх ухааны академи өөрийн харьяа хүрээлэнгүүдийн лабораторийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг сайжруулахад 889.1 сая төгрөгийг төлөвлөн зарцуулсан байна.	100
<b>Зорилт 14. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, шуурхай байдлыг хангана.</b>							
14.1	ЗГҮАХ-ийн 5.2.10 дахь заалт	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим сумдад төрийн цахим үйлчилгээний Хур системийг нэвтрүүлэх	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх төв	257	8.6 Улсын төсөв	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим сумдад төрийн цахим үйлчилгээний Хур системийг нэвтрүүлэх хүрээнд 2020 онд дараах 4 чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 1. "Цахим үйлчилгээний тоног төхөөрөмж болон хаяг дотор заслыг хийж, нийлүүлэх, суурилуулах, хүргэх ХХМТГ-201912003-3" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 270 сумын Засаг даргын Тамгын газарт ХУР системийг нэвтрүүлэх тоног төхөөрөмжийг төрийн үйлчилгээний ажилтанд хүлээлгэн өгч 2020 оны 6 дугаар сарын 1-ээс үйл ажиллагааг эхлүүлсэн. 2. "Нөөц тэжээлийн үүсгүүр нийлүүлэх, хүргэх" төслийн хүрээнд 243 сумын холбооны байруудад нөөц тэжээлийн үүсгүүрийг нийлүүлж, суурилуулсан. 3. "Үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ барилга, их засварын ажил" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 132 сумын их засварын ажил болон 24 шинэ барилгын ажил бүрэн хийгдэж дууссан. 4. Харилцаа холбооны цамхаг угсарч, суурилуулах төслийг хэрэгжүүлж 62 цамхгийг холбогдох гэрээний дагуу угсарч, суурилуулсан.	100
14.2	ЗГҮАХ-ийн 5.1.18 дахь	Алслагдсан сумдыг өргөн	Шилэн кабелийн сүлжээнд	3	0.2 Улсын	Алслагдсан сумдыг өргөн зурвасын шилэн кабелийн сүлжээнд холбох хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:	100



	заалт	зурвасын шилэн кабелийн сүлжээнд холбох	холбогдох сум		төсөв  0.28 Бүх нийтийн үйлчилгээн ий үүргийн сан	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасны дагуу “Үүрэн телефоны сүлжээ дамжуулах станц /Ховд, Дөргөн сум/, “Харилцаа холбооны дахин дамжуулах станц /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/, “Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ төслийг гүйцэтгэж, барилга, байгууламжийг ашиглалтад оруулсан.</li> <li>- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр “Өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг холбох” ажлын нээлттэй тендер шалгаруулалтыг Багц 1 /Сэлэнгэ аймаг Сайхан сум, Номгон тосгон/, Багц 2 /Хэнтий аймгийн Мөрөн сум Өлзийт тосгон/ 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зарлаж, нэгдүгээр багцад шалгарсан “Комтех солюшн” ХХК-тай 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 144.4 сая төгрөгийн гэрээ, хоёрдугаар багцад шалгарсан “Нью Оптик” ХХК-тай 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 124.0 сая төгрөгийн гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгон, Хэнтий аймгийн Мөрөн сумын Өлзийт тосгоныг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлыг 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хийж дуусгасан. Төсөл хэрэгжсэнээр сумдын түвшин дэх иргэдийн интернэт болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээг иргэдэд ойртуулах, цахимжуулах интернэтийн үйлчилгээг өрх бүрд хүргэх боломж бүрдсэн.</li> <li>- Түүнчлэн харьяа байгууллагууд болох “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК нь өөрийн хөрөнгөөр шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох хүрээнд “Говь-Алтай аймгийн Алтай сумыг Цээл сумаас шилэн кабелийн сүлжээнд холбох (210 км)”, “Сэлэнгэ аймгийн Баянгол сумыг Төв аймгийн Баянчандмань сумаас шилэн кабелийн сүлжээнд холбох (90 км)” ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</li> </ul>	
14.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 7, ЗГҮАХ-ийн 5.1.17, 5.2.8, Төрөөс мэдээлэл, харилцаа	Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, цахим албан	Цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний нэр төрөл	100	-	<p>Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг хөгжүүлэх хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд төрийн бүхий л төрлийн үйлчилгээг үйлчилгээний ажилтнаар дамжуулан авах, үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн “Төрийн үйлчилгээний операторын систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлж, системийг</li> </ul>	100



	<p>холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын 3.9.3 дахь заалт</p>	<p>хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг хөгжүүлэх</p>	<p>Нэгдсэн системд нэвтрүүлсэн төрийн байгууллагын тоо</p>	<p>15-аас багагүй</p>		<p>ашиглах 330 сум суурин газрын үйлчилгээний ажилтанд сургалт зохион байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулах үйлчилгээг үзүүлсэн. Цахим үйлчилгээний нэгдсэн <a href="http://www.e-mongolia.mn">www.e-mongolia.mn</a> портал, e-mongolia гар утасны аппликейшныг 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж 232 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж байна. Үүнээс порталаар 156 үйлчилгээ, төрийн үйлчилгээний операторын системээр 181 үйлчилгээ, гар утасны аппликейшнээр 86 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж байна. Үр дүнгээс дурдахад 2020 онд 112.3 мянган иргэн гар утасны аппликейшн өөрийн гар утсандаа суулгаж, 217.8 мянган үйлчилгээг цахим хэлбэрээр уг платформоор дамжуулан авсан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ийг Соёлын яам, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар, Үндэсний дата төв УТҮГ, Мэдээллийн технологийн үндэсний парк ТӨААТҮГ, Монголын цахилгаан холбоо ХК, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Нислэгийн цаг уурын төв, Монгол шуудан ХК, Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Туул голын сав газрын захиргаа, Харилцаа холбооны зохицуулах хороо, Барилгын политехник коллеж, Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал зэрэг 14 байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.</li> <li>- Мөн 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, 330 сумын Засаг даргын Тамгын газарт дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ашиглах эрхийг нээж, холбогдох сургалтыг зохион байгуулсан.</li> </ul>	
<p>14.4</p>	<p>ЗГҮАХ-ийн 3.2.40 дэх заалт</p>	<p>Хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх</p>	<p>Шинээр нэвтрүүлэх систем</p>	<p>1</p>	<p>-</p>	<p>Хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх хүрээнд Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан үнэгүй, бүрэн функцээр ажиллах боломжгүй программ хангамжийг тооцоололд үнэгүй ашиглаж байгаагаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хиймэл дагуулын сүлжээний хувьд Радио давтамжийн тооцооллын үндсэн гарын авлага болох Олон улсын цахилгаан холбооны байгууллагын "Дэлхийн Радио холбооны Дүрэм" 4 боть номыг англи хэлнээс монгол хэлнээ хөрвүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэхүү дүрмийн 4 дүгээр ботийн Зөвлөмж, тооцооллын аргачлалд үндэслэсэн</li> </ul>	<p>30</p>

						<p>программаар тооцоолол хийдэг бөгөөд хүчин төгөлдөр байгаа 30 гаруй тооцооллын цахим файлыг ашиглаж одоогийн хэрэгцээг хангаж байна.</p> <p>- Газрын сүлжээний хувьд программ хангамжгүй тул Харилцаа холбооны зохицуулах хорооны худалдан авсан спектр менежментийн газрын сүлжээний программ хангамжаар газрын сүлжээний радио давтамжийн тооцооллыг хийлгэж, хөрш орнуудын хил орчмын радио давтамжийн зохицуулалтад хамаарах асуудлаар хамтран ажиллаж байна.</p>
<b>Зорилт 15. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлнэ.</b>						
15.1	<p>МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /цаашид "ТЭМТББ" гэх/-ын 2.4.2.10, 2.4.10.11, ЗГҮАХ-ийн 3.1.2, 3.1.13 дахь заалт</p>	<p>Зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх</p>	<p>Хүн амын дунд эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь</p>	25.0	9.0 ЭМДС	<p>Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах арга хэмжээний хүрээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 290,527 хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсанаас Улаанбаатар хотод 111,614 хүн, хөдөө орон нутагт 178,913 хүн байна. Үзлэгт хамрагдсан байдлыг насаар нь авч үзвэл 18-34 насны 79,611 хүн, 35-45 насны 75,015 хүн, 46-64 насны 110,095 хүн, 64 дээш насны 22,722 хүн байна. Харин артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 900,571 хүн хамрагдсан нь зорилтот бүлгийн 44.1 хувийг хамруулсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 835,823 хүн хамрагдсан нь зорилтот бүлгийн 40.9 хувийг хамруулсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 216,975 хүн хамрагдсан байна. Хүн амын дунд эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь 31.1 хувь байна.</p> <p>"Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь" төсөл хэрэгжиж буй 61, орон нутгийн санаачилга, санхүүжилтээр 73 эрүүл мэндийн анхан шатны байгууллага, нийт 134 байгууллагад тус бүрд мобайл тоног төхөөрөмж болох зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, зөөврийн ЭХО, "Омгон" цусны даралт хэмжигч аппарат, сахар, холестрин хэмжигч, халдварт болон халдварт бус өвчний 8 төрлийн хурдавчилсан оношлуур, шинжилгээ авахад хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл, зөөвөр хэрэглэж болох жижиг оврын центрифуг, зөөврийн жин, өндөр хэмжигч, Самсунг таблет 2, Ipad 1, зөөврийн компьютер 1 зэрэг нийт 28 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгслээр хангасан. Эдгээр зөөврийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглан сум, өрхийн эрүүл мэндийн төв буюу анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас явуулын тусламж, үйлчилгээ</p>
			<p>Явуулын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа алслагдсан сум, дүүргийн эрүүл мэндийн төвийн тоо</p>	20		100

			Амны хөндийн үзлэг, шүдний өвчний эмчилгээнд хамрагдсан 2-12 насны хүүхдийн хувь	25.0		<p>үзүүлж байна. Төсөл хэрэгжсэн анхан шатны байгууллагууд зорилтод бүлгийн 200,000 гаруй иргэнийг хүн төвтэй эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээнд хамруулсан байна.</p> <p>2020 онд 02-12 насны нийт 60,319 хүүхэд хамруулж, үзлэгт хамрагдах хүүхдийн 59.4 хувийг хамруулсан байна. Улсын хэмжээнд 2020 онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нийслэлийн 66, орон нутгийн 81 нийт 147 шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулж, амын хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн байна.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/253 дугаар тушаалаар "Цэцэрлэгийн хүүхдийн болон сургуулийн бага ангийн хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж" батлагдаж, цэцэрлэгийн эрхлэгч, эмч, багш, сургуулийн захирал, эмч, ангийн багш, эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хүүхдийн эзэмшсэн байх дадал, хүүхдийн шүд угаах аргачлалыг тодорхой зааж өгч, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлж ажиллах үүрэг өгч ажилласан.</p>	
15.2	МУТХУБ-2030-ын 2.2.2, Зорилт 2, ТЭМТББ-ын 2.4.1.8, ЗГҮАХ-ийн 3.1.8, 3.15.10 дахь заалт	Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах	Шинээр ашиглалтад оруулах хүүхдийн эмнэлгийн тоо	6	0.2 Улсын төсөв	2020 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга 100 хувийн гүйцэтгэлтэй, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилга 100 хувийн гүйцэтгэлтэй, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилга 95 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Увс аймгийн Улаангом сумын 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилга 100 хувийн гүйцэтгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сумын 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилга 100 хувийн гүйцэтгэлтэй, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 100 ортой хүүхдийн эмнэлгийн барилга 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
			Нярайн сурфактант эмчилгээг бүрэн нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	100.0	ЭМДС	2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 21 аймаг, Улаанбаатар хотын Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-д нийт эрүүл мэндийн байгууллагын 100 хувь сурфактант эмчилгээ бүрэн нэвтрүүлж, 473 дутуу нярайг хамруулж эмчилгээний үр дүн 75.7 хувьтай байна.	
15.3	МУТХУБ-2030-ын 2.2.2,	Хүн өвчлөл, амын нас	Харвалт шигдээсийн нэгж байгуулах эмнэлгийн тоо	7	9.1	2020 оны жилийн эцсийн байдлаар Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул дүүргийн ЭМТ, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, Дорнод болон Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд харвалт, шигдээсний нэгжийг байгуулан	70



	Зорилт 3, ТЭМТББ-ын 2.4.1.11, 2.4.2.12, ЗГҮАХ-ийн 3.1.10.7 дахь заалт	баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа зүрх судас, хавдар, түүнтэй холбоотой хүндрэлээс үүдэлтэй нас баралтыг бууруулах	"Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100.0	ЭМДС	ажиллуулж байна. "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд нийт 15-аас дээш насны 1,181,807 даатгуулагч элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдсан байна. Энэ нь хамрагдвал зохих 15-аас дээш насны хүн амын 77.1 хувийг эзэлж байна. Элэгний В вирусийн илрүүлэх шинжилгээнд 1,155,533 хүн хамрагдсанаас 9,6740 хүн В вирус эерэг илэрсэн бөгөөд 8.4 хувийг эзэлж байна. Элэгний С вирусийн илрүүлэх шинжилгээнд 1,154,868 хүн хамрагдаж, 115,160 хүн С вирус эерэг илэрсэн бөгөөд 10.0 хувийг эзэлж байна.	
15.4	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 4, ТЭМТББ-ын 2.4.1.11, 2.4.2.12, ЗГҮАХ-ийн 3.1.10.7 дахь заалт	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх	Улирлын томуугийн эсрэг вакцинжуулалтад хамрагдах хүн амын эзлэх хувь Умайн хүзүүний хорт хавдрын вакциныг нэвтрүүлсэн аймаг, нийслэлийн тоо Эмнэлгийн мэргэжилтнийг элэгний В вирус эсрэг дархлаажуулалтад хамруулах хувь	40.0  УБ хот, 5 аймаг  100.0	2.4  Улсын төсөв	2020 онд томуугийн эсрэг эсрдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулахаар нийт 580,997 хүнийг хамруулж, зорилтот бүлгийн хамралтын хувь 95.3, нийт хүн амын 19.0 хувийг хамруулсан байна. Хүний хөхөнцөр вирус (папилломавирус) эсрэг дархлаажуулалтын вакцины захиалга Дэлхийд тархсан коронавирусын халдвартай холбоотой тээвэрлэлт, үйлдвэрлэлт хугацаандаа бус, хожуу ирсэн байна. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хүний папилломавирус /ХПВ/-ийн эсрэг вакциныг ХӨСҮТ-ийн сайн дурын дархлаажуулалтын кабинетээр дамжуулан зөвхөн Улаанбаатар хотод 10 эмэгтэйг хамруулсан. 2020 онд эрүүл мэндийн 18 байгууллагад 5,640 хүн тун хөпатит В вирус эсрэг вакциныг түгээж, шинээр ажилд орсон болон өмнө нь вакцинд хамрагдаагүй 1,800 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хөпатит В вирус эсрэг вакцинаар дархлаажуулсан.	70
15.5	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.2.128, 2.4.4.3, 2.4.6.8, ЗГҮАХ-ийн	Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ үйлчилгээний	Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протезийн нэр төрөл, хэмжээний өсөлт, хувиар	20.0	108.3  ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 05, 07 дугаар тогтоолоор "Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам, жагсаалт" батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ, дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбоотой шинээр нийт 251 нэр төрлийн эмнэлгийн хэрэгслийг	90



3.1.16.2, 3.1.17.1, 3.3.20.4 дэх заалт	хамрах хүрээг нэмэгдүүлэх			өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд нэмсэн. Ингэснээр нийт 650 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний жагсаалтад орж, өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протезийн нэр төрөл 38.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 2020 онд нийт 32 мянган даатгуулагчид 41.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.
		ЭМДС-гаас санхүүжиж байгаа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хувь	70.0	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2020 онд төв, орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн 2,071 эрүүл мэндийн байгууллагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд төрийн өмчийн 127, хувийн хэвшлийн 1,931 эрүүл мэндийн байгууллага, 13 спорт клуб байна. Үүнд хувийн хэвшлийн 177 эмнэлэг, сувилал 58, эмийн сан 964, өрхийн эрүүл мэндийн төв 64, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 149 эмнэлэг, элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох лаборатори 28, гемодиализийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 11 эмнэлэг, амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн 141 шүдний эмнэлэг хамтран ажиллаж байна. Энэ хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 93.2 хувь юм.
		Нэн шаардлагатай болон ахмад настанд олгох эмийн хөнгөлөлтийн хувь	80.0	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажилласнаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Licemed программд бүртгэгдсэн зайлшгүй шаардлагатай эмийн улсын бүртгэлийн дугаараар эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмүүдийг коджуулан жагсаалтыг судалгаанд суурилан шинэчлэн боловсруулж, ерөнхий жагсаалтын 605 эм, 0-5 настай хүүхдийн эмийн жагсаалтын 155 эм, нийт 760 эмийг улсын бүртгэлийн дугаараар бүртгэлжүүлж, эмийн хөнгөлөлт 50-80 хувьтай олгогдож байна. Нэн шаардлагатай болон ахмад настанд олгох зүрх судас, хоол боловсруулах тогтолцооны өвчний эмчилгээнд хэрэглэдэг эмийн хөнгөлөлтийн 14 төрлийн 101 эмийн үнийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 50-80 хүртэл хувиар хөнгөлж олгож байна. Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлсэн эмийн сангуудад гүйцэтгэлээр нь сард 2 удаа санхүүжилтийг олгодог байхаар цахим системд холбогдох хөгжүүлэлтийг хийж, 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 1,982 байгууллагад санхүүжилтийг олгосон байна.

			Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс ЭМД-ын сангаас санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээний төрөл	4		2019 оны 10 дугаар сараас эхлэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд сэргээн засах тусламж, үйлчилгээ; өдрийн эмчилгээ; гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ болон оношилгоо, шинжилгээ зэрэг 4 тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын шинэчлэл хийж, тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлж, сэргээн засах тусламж, үйлчилгээ 20 мянган төгрөгөөс 45 мянган төгрөг, өдрийн эмчилгээ 30 мянган төгрөгөөс 70 мянган төгрөг, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ 25 мянган төгрөгөөс 50-70 мянган төгрөг болгосон нь иргэдээс гарах зардлыг багасган, эмч, мэргэжилтнүүдийн ажил хөдөлмөрийн үнэлгээг нэмэгдүүлсэн.	
			Магадлан итгэмжлэгдсэн спорт клубын тоо	20		2020 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэсэн иргэний үйлчилгээний төлбөрт хөнгөлөлт үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн 13 спорт клубтэй 2020 оны 01 дүгээр сард гэрээ байгуулсан. Дээрх 13 спорт клубийг байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 2, Баянгол дүүрэгт 2, Хан-Уул дүүрэгт 2, Орхон аймагт 3, Сүхбаатар, Сэлэнгэ аймагт тус бүр 1 байна. Дэлхий дахинд "Ковид-19" цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Засгийн газрын тогтоол болон Улсын онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоож, спорт клубүүд ажиллаагүй тул 2020 онд санхүүжилт олгогдоогүй байна.	
15.6	МУТХУБ-2030-ын 2.2.2, Зорилт 3, ТЭМТББ-ын 2.4.3.4, ЗГҮАХ-ийн 5.6.12.6 дахь заалт	Эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсад одоогоор оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчилдэг болох	Гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцах эмнэлгийн мэргэжилтний тоо	10		"Ковид-19" цар тахлын улмаас 2020 онд гадаад сургалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тулгарсан хэдий ч олон улсын мэргэжлийн чиглэлийн нийгэмлэг, холбоодын нэр хүнд бүхий алсын зайн, цахим, төлбөртэй сургалтуудад эмч, мэргэжилтнүүдээ өргөнөөр хамруулахыг зорьж ажилласан бөгөөд энэ хүрээнд дээрх олон улсын чанартай алсын зайн цахим, цуврал модуль бүхий сургалтад давхардсан тоогоор 349 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд Австри Улсын Засгийн газрын нөхцөлт эзэлийн санхүүжилтээр төсөл хэрэгжиж байгаатай холбогдуулан төслийн хүрээнд Соронзон резонанст томографийн аппарат /MRI 1.5Tesla/ дээр ажиллах 8 эмч, мэргэжилтнийг Австри Улсад 2020 оны эхний сард сургасан байна.	50
			Гадаадад ажиллаж байсан мэргэжлийн ур чадвар бүхий	25		"Ковид-19" цар тахлын улмаас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолоор хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлаж, өндөржүүлсэн бэлэн байдлыг тогтоосон. Олон улсын тээврийн	

			эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эх орондоо ажиллуулах			хөдөлгөөнийг хязгаарласан тул 2020 онд гадаадаас эмч, мэргэжилтэн ирж ажиллаагүй болно.	
15.7	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.3.2, 2.4.8.3, ЗГҮАХ-ийн 3.1.6.7, 3.1.15.1, 3.1.15.2 дахь заалт	Эрүүл мэндийн салбарын дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Шинээр ашиглалтад орох эмнэлгийн тоо	31	64.2	2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 18 эмнэлгийн барилга ашиглалтад орсон байна. Коронавируст халдварын цар тахалтай холбогдуулан бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор 2020 оны 10 дугаар сарын дунд үеэс он дуустал барилга угсралтын ажил хийгдэхгүй хөл хорионы дэглэм сахисан, түүнээс улбаалж барилга угсралтын ажил төлөвлөгдсөн хугацаанд ашиглалтад ороогүй 9 барилга байна.	70
			Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	100.0	9.2		
					2.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх 39.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 42 тоног, төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулсан. Мөн Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/108 дугаар тушаалаар Вакцины хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хуваарь баталж, дархлаажуулах бэлдмэлийн чанар, хадгалалт тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах мөсөн хангатай хөргөгч, дагалдах хэрэгслийг 21 аймаг, 9 дүүрэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв зэрэг 31 эрүүл мэндийн байгууллагад нийлүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжийн гүйцэтгэл 95.0 хувьтай байна. Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс 40 ширхэг амьсгалын тоног төхөөрөмжийг худалдан авч 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, зарим төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/123, А/131 дүгээр тушаалаар хуваарилсан байна. "Ковид-19" цар тахал дэлхий дахинд өргөн тархсантай холбогдуулан Эрүүл мэндийн яамны зүгээс коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн салбарт зүрх, уушги орлуулах ЕСМО /Extra corporeal membrane oxygenation/ аппаратыг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/197 дугаар тушаалаар УНТЭ-т олгосон. Дэлхийн банкны санхүүжилттэй "Цахим эрүүл мэнд" төслийн хүрээнд "Шинэ коронавируст халдварын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай" суурин дижитал рентген аппаратууд болох 12 ширхэг зөөврийн рентген аппарат, 15 суурин рентген, 41 ширхэг зөөврийн ЭХО аппаратууд эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.	
					0.5	Улсын төсөв, Гадаад эх үүсвэр	
					ЗГНС		
					Бусад эх үүсвэр		



						Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгөөр нийт 9 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн байгууллага болон харьяа байгууллагуудад 3 удаагийн ханган нийлүүлэлт хийж угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгээд байна.	
--	--	--	--	--	--	---	--

**Зорилт 16. Нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.**

16.1	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2	Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжүүлэх	Хамрагдах хүний тоо	60.0 мянга	17.4 ХЭДС,  0.704  Гадаад эх үүсвэр	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 01 тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр", "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-т нэмэлт, өөрчлөлтийг оруулж гуравдугаар хавсралтаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. -Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2020 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр 17567 иргэн хамрагдаж, 9,313,008.4 мянган төгрөгийг зарцуулж, 14263 иргэн ажлын байраар хангагдсан байна. -Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 2020 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 812 ахмад хамрагдаж, 930,853.2 мянган төгрөг зарцуулж, 830 ажлын байр бий болсон байна. -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2020 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 2,651 иргэн хамрагдаж, 3,033,737.1 мянган төгрөг зарцуулж, 1064 ажлын байр бий болсон байна. -Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2020 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 1002 малчин өрхийн 1512 малчин иргэн хамрагдаж, 2,264,702.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. -Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт 2020 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 2419 иргэн хамрагдаж, 1,012,483.1 мянган төгрөг зарцуулж, 181 иргэн ажлын байраар хангагдсан байна. -2020 оны 11 сарын байдлаар Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрт өссөн дүнгээр 2492 иргэн хамрагдаж, 195,444.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.	50
			Шинээр бий болох ажлын байрын тоо	10 000 байнгын, 15 000 түр ажлын байр			
			Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ арга хэлбэрийн туршилтын хэрэгжилт, хувиар	100.0			



						<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр цахимаар хуралдлаа. Уг хуралдаанаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил аж ахуйн нэгжид ажиллагчдын ажлын байрыг хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд 2017-2020 онд хамрагдан, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэн, бичил аж ахуйн нэгж, байгууллагын эргэн төлөлтийн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хойшлуулах,</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019, 2020 онд жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан, 3 буюу түүнээс дээш сарын хугацаанд ажлын байр түрээсэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 2020 оны 11, 12 дугаар сарын ажлын байрны түрээсийн төлбөрийг нөхөн төлөх,</p> <p>-Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр болон Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2017-2020 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг авсан, эргэн төлөлт нь дуусаагүй байгаа иргэдэд өөрийн хүсэлтийг үндэслэн нэмэлт санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрт заасны дагуу эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгох гэсэн шийдвэрүүдийг тус тус баталлаа.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон түүний харьяа байгууллагууд арга хэмжээнд хамрагдах иргэн, бичил аж ахуйн нэгж, байгууллагад түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх бөгөөд Улсын онцгой комиссын шийдвэр, "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал"-ын холбогдох дүрэм, журмыг чанд сахиж, цахим болон утсаар холбогдох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллав.</p> <p>Дээрх хөтөлбөрүүдийг 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт хэрэгжүүлэхэд 2020 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 17.4 тэрбум төгрөгийг зарцуулж, 25276 иргэнийг хамруулж, 16459 ажлын байр бий болсон байна. Үүнээс байнгын ажлын байр нь 2633, түр ажлын байр 11619, цагийн ажлын байр 841 хүн хамрагдсан байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг</p>
--	--	--	--	--	--	--

						<p>дэмжих шинэ арга хэлбэрийн туршилтыг хэрэгжүүлж, дараах ажлуудыг хийлээ. Үүнд:</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх чиглэлээр:</p> <p>1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийг шинэчлэн засварлаж, ажилтны ширээ сандал, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд:</p> <p>-Засварын ажил бүрэн дууссан Баянгол, Сонгионхайрхан, Налайх дүүрэг, Завхан, Өвөрхангай, Дундговь, Орхон, Увс аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд оффисын тавилга хүргэгдэж угсралт, суурилуулалт бүрэн хийгдсэн.</p> <p>-Оффисын сандал, сургалтын өрөөний сандал, ганцаарчилсан зөвлөгөөний өрөөний сандлыг нийлүүлэгчээс тус тус хүлээн авч дээрх аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулав.</p> <p>-6 аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн оффисын байр, танхимын засварын ажлыг эхлүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, засварын ажил хийгдэж байна.</p> <p>2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг сайжруулах ажлын хүрээнд:</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах, арга хэрэгслийг нэвтрүүлэх чиглэлээр олон улсын зөвлөхтэй хамтран ажилласан.</p>	
16.2	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.17 дахь заалт	Бичил аж ахуйн нэгж, иргэдэд Итгэлийн зээлийг олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Зээл авах бичил аж ахуйн нэгж, иргэдийн тоо	2000	23.4 ХЭДС	<p>Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд зориулсан жижиг зээлийг 2018 онд Төрийн болон Хаан банкаар дамжуулан 15.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг байршуулан 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 18.3 тэрбум төгрөгийг 1973 иргэнд, мөн 2019 онд 8.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг дээрх банкуудад байршуулсан бөгөөд холбогдох хөтөлбөр, удирдамжид заасны дагуу 2019 оны 12 дугаар сараас иргэдэд олгож эхэлсэн ба 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 8.1 тэрбум төгрөгийг 916 иргэнд олгосон байна. Ингэснээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан нийт 26.4 тэрбум төгрөгийг 2889 иргэнд жижиг зээлийг олгоод байна.</p> <p>2020 онд 18 тэрбум төгрөгийн санхүүжилт улсын төсөв дээр</p>	100

						<p>тавигдсан хэдий ч, "Ковид-19" цар тахлаас шалтгаалан 11.5 тэрбум төгрөг улсын төсөвт буцаан татаж, 2020 оны жижиг зээлийн санхүүгийн эх үүсвэрт 7.4 тэрбум байршуулахаар болсон.</p> <p>Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд байгуулсан "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар олгох жижиг зээлийг 2020 онд 7,415,000,000,0 (долоон тэрбум дөрвөн зуун арван таван сая) төгрөгийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх банкаар Төрийн банк, Хаан банкныг сонгон шалгаруулж, 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулж, зээл олгож эхлээд байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож байгаа жижиг зээлийн тодорхой хувийг ажил олоход хүндрэлтэй, ажилгүй гэх мэт зорилтот бүлгийн иргэдэд олгох чиглэлийг баримтлан холбогдох удирдамж, гэрээнд тусган хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p>	
16.3	ЗГҮАХ-ийн 3.3.6 дахь заалт	Монгол залуусаа сургаж, дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авах ажиллагчдын тоог бууруулах	Гадаадаас авах ажиллагчдын тоог бууруулах хувь	50.0 хүртэл	-	<p>Дотоодын ажиллах хүчийг гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнийг дагалдуулан сургаж, ажлын байраар хангаж гадаадаас авдаг ажиллагчдын тоог бууруулах зорилтыг жил бүр хэрэгжүүлэн ажиллаж, 2012-2016 онд дунджаар 24269 гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байсан бол 2016-2020 онд дунджаар 9207 гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхэлж, Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо 2020 оны жилийн эцэст 62 хувиар буурсан байна. Мөн Засгийн газрын "Гадаадаас 2019 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" 2019 оны 377 дугаар тогтоолын дагуу 2483 гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхэлж, нийт 2020 онд 5310 гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхэлжээ.</p> <p>2019 онд 10357 гадаадын иргэн, 2020 онд 5310 гадаадын иргэн ажиллаж, өмнөх оноос 51.2 хувиар буурсан байна.</p>	100
16.4	ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт	Инфляцийн түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	302.5 Улсын төсөв	<p>Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс 8.0 хувиар нэмэгдүүлэн тогтоож, улсын төсвөөс 159.8 тэрбум төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 57.2.4 болон 77.2-т заасны дагуу төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар тооцон олгоход улсын төсвөөс 142.7 тэрбум төгрөг тус тус зарцууллаа.</p>	100

16.5	ЗГҮАХ-ийн 3.4.3, 3.4.4, 3.3.28 дахь заалт	Хүүхдийн хөгжил, хамгаалал, өсвөр залуучуудын хөгжлийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоо, хөгжлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх үе, эрх,	Боловсруулах хөтөлбөрийн тоо	1	-	<p>Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн II дахь шатны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2020 оны А/107, А/210, А/268 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллав.</p> <p>Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн II дахь шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн З/1536 дугаар албан бичгийг яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт хүргүүлсэн. ГБХЗХГ, НГБХЗХГ-г үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлэв.</p> <p>Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасан 5 чиглэлтэй уялдуулан 2022 он хүртэл хэрэгжүүлэхээр Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлуулсан.</p> <p>-Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/383 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтэд хариуцсан болон хамтран оролцох яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, харьяа газар, агентлагууд, холбогдох бусад төрийн, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудад 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/580 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. "Хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт залуучуудын хөгжлийг дэмжих тухай агуулга, хөтөлбөрийг тусгах журам"-ын төслийг эцэслэн боловсруулж, 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/1480 тоот албан бичгээр яамд болон бусад холбогдох талуудад хүргүүлж, саналыг тусгаж байна.</li> <li>2. "Оюутны цагийн хөдөлмөр эрхлэх журам"-ын төслийг эцэслэн боловсруулж, яамдын саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлээд байна.</li> <li>3. Донтолт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, урьдчилан сэргийлэх сургагч багшийн сургалтын</li> </ol>	100
			Хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо	2			



					<p>модуль хөтөлбөр боловсруулах тухай 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 3/80 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлж байна.</p> <p>4. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчлах видео контент бүтээх тухай 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 3/63 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлж байна.</p> <p>5. Залуучууд, оюутан, суралцагчдыг цахим орчны зохистой хэрэглээнд сургах, цахим гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургагч багшийн сургалтын модуль хөтөлбөрийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах, тус агуулгаар видео болон хэвлэмэл контент бүтээх тухай ажлын удирдамжийг боловсруулан батлуулаад байна.</p> <p>6. Хорио цээрийн дэглэм тогтоож, их, дээд сургууль, коллеж түр завсарласан, мөн хөдөлмөр эрхлэгч залуучуудыг ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагууд гэрээр ажиллуулахыг дэмжиж буй энэ үед залуучуудын сахилга баттай, хариуцлагатай, үр дүнтэй, бүтээлч байдлыг дэмжих үйл ажиллагааны чиглэлийг боловсруулж, ГБХЗХГ-ын даргын 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/252 тоот албан бичгээр аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвүүдэд хүргүүлэв. Тус чиглэлд төвийн ажилтнууд, үйлчлүүлэгчдийн аюулгүй, эрсдэлгүй байх нөхцөлийг хангах, төвийн тогтмол үйл ажиллагааг хорио цээрийн дэглэмтэй уялдуулах тодорхой арга хэмжээг тусгасан.</p> <p>7. Налайх дүүргийн Залуучуудын хөгжлийн жишиг төвийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил арга зүйгээр хангах арга хэмжээг 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулав.</p> <p>8. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шаардлагатай арга хэмжээний зөвлөмж, холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 3/172 дугаар гэрээг байгуулан зөвлөх үйлчилгээг эхлүүлэв.</p> <p>“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 321 дүгээр тогтоолоор батлан, “хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/116, А/304, А/197 тоот хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна.</p>
--	--	--	--	--	--

						Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2020 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичигт 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төслийг 2018 оны 8 дугаар сараас хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоог хангах талаар 14 багцын 16 гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлуулах, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг шинээр боловсруулж батлуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар салбар дундын ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.	
16.6	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 3.3.17, 3.3.18 дахь заалт	Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, тэт гэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх болон нийгмийн халамжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2	-	<p>2020 онд Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдаж, Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан "Алсын хараа-2050", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг дахин боловсруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 10 дугаар сарын 07-ны А/197 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.</p> <p>-Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 20 гаруй удаа хуралдаж хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, 12 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран батлаад байна.</p> <p>-Нийгмийн даатгалын ерөнхий (Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг дагалдах 10 хуулийн төсөл), Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиудын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж, хуулийн төслүүдийн үр нөлөөний, зардлын тооцооны судалгааг боловсруулав. Хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод</p>	100

						<p>байна.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.3-т заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлууллаа.</p> <p>"Нийгмийн халамжийн тухай" хуулийн төслийн үр нөлөөний судалгааг "Хууль тогтоомжийн тухай" хуулийн дагуу ерөнхий зүйл, шалгуур үзүүлэлтийг сонгох, хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох, шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх гэсэн аргачлалын дагуу үнэлж, судалгааг боловсрууллаа.</p> <p>"Нийгмийн халамжийн тухай" хуулийн төслийн зардлын судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу ерөнхий зүйл, хуулийн этгээдийн зардлыг тооцох, иргэний зардлыг тооцох, төрийн байгууллагын зардлыг тооцох гэсэн аргачлалын дагуу судалгааг боловсрууллаа.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад дагалдах 10 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.</p>	
16.7	ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт	Инфляцын түвшинтэй уялдуулан Нийгмийн даатгалын сан болон Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны жорэгжилт, хувиар	100.0	313.4 Улсын төсөв	<p>Засгийн газраас инфляцын түвшинтэй уялдуулан 2016 оноос хойш нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 38.9-39.4 хувиар, бусад тэтгэврийг 30.7 хувиар нэмэгдүүлээд байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 24 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн алба хаасны 500.0 мянга хүртэлх тэтгэврийг 30.00 мянган төгрөгөөр, 500.0 мянгаас дээш төгрөгийн тэтгэврийг 25.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 350.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 300.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>Энэхүү арга хэмжээний хүрээнд 421.7 мянга орчим тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлэхэд 150.6 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.</p>	100

						<p>2020 оны Төсвийн тухай хуульд нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулан 17,466.6 сая төгрөгийг баталсан.</p> <p>Хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 188.0 мянган төгрөг, асаргааны тэтгэмжийг 84.5 мянган төгрөг, байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эхчүүдэд олгох асаргааны тэтгэмжийг 123.1 мянган төгрөгт хүргэж тус тус нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 8-11 хувиар нэмэгдсэн.</p>	
16.8	ЗГҮАХ-ийн 3.4.9 дэх заалт	Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежид элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлж, төгсөгчдөд мэргэжил, ур чадварыг эзэмшүүлэн, суралцагчдад тэтгэлгийг сар бүр олгох	Мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх төгсөгчдийн тоо, мянга	20	45.7 ХЭДС	<p>Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад 2019-2020 оны хичээлийн жилд 24853 иргэн, залуучууд элсэн суралцаж, жил бүрийн элсэгчдийн тоо өсөн нэмэгдсээр байна.</p> <p>2020-2021 оны хичээлийн жилийн эхний хагас жилд мэргэжлийн болон техникийн боловсролын 75 сургалтын байгууллагад 40165 суралцагч 16 салбарын 205 мэргэжлээр суралцаж байгаагийн 50 орчим хувь нь буюу 20516 суралцагч төгсөх ангид суралцаж байна.</p> <p>Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор тэтгэлгийн хэмжээг 100.0 мянган төгрөг болгон, "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-ыг шинэчлэн баталсан.</p> <p>Мөн 2020 оны Засгийн газрын 44 дүгээр тогтоолоор "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам" болон тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг болгон шинэчлэн баталсан. "COVID-19" цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах болон суралцагчдын 2020 оны 2, 3 дугаар сарын тэтгэлгийг нөхөн олгох Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 133 дугаар тогтоол гарсан. Уг журмын 3.5.-д "Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх зохих шийдвэрийн хүрээнд сургалтын байгууллага цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан тохиолдолд</p>	100



						суралцагчдад тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно." гэж тусгасан. 2020 оны 1 дүгээр сараас эхлэн суралцагчдад олгох тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг болгон 54.9 тэрбум төгрөгийн төсөв батлуулсан.	
<b>ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО</b>							
<b>Зорилт 17. Цагдаагийн байгууллагын мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.</b>							
17.1	ЗГҮАХ-ийн 5.4.5 дахь заалт	Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбоог шинэчилж, мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.2 Улсын төсөв  0,029.8 Орон нутгийн төсөв	Цагдаагийн байгууллагын төсөв болон орон нутгийн захиргааны байгууллагын санхүүжилтээр 2020 онд нийт 812 /үүнээс "гар" буюу үүргийн 710, суурин 51, автомашины 51/ радио станцыг цагдаагийн байгууллагын төсвөөр, /ЦЕГ нь 2019 оны хөрөнгө оруулалтаар 700 ширхэг гар станц, 50 ширхэг автомашины станц, 50 ширхэг суурин станц бэлтгэж, 2020 онд төв, орон нутгийн нэгжүүдэд хуваарилан олгосон./ 130 станцыг аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын санхүүжилтээр тус тус олгож, давхардсан тоогоор 1717 радио станцыг засварлаж ажилласан.	70
17.2	ЗГҮАХ-ийн 5.4.1 дэх заалт	Дотоодын цэргийн хугацаат цэргийн албан хаагчдын нормын хангалтыг хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	1.4  Улсын төсөв	Дотоодын цэрэг болон хугацаат цэргийн алба хаагчдын 2020 оны хэрэгцээнд 1,054.76.5 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 64 нэр төрлийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг, ахуйн хэрэглэлийг бэлтгэхээр холбогдох сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан 20 аж ахуйн нэгж, байгууллагатай бараа бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулан ажиллаж, гүйцэтгэлийг ханган, хуваарилагдсан төсвийг бүрэн зарцуулсан. Дотоодын цэргийн 12 анги, байгууллагын 3390 алба хаагчдад нийт 1,162.816.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 56 нэр төрлийн 72.725 нэгж дүрэмт хувцас, ялгах тэмдгийн нэгдсэн болон нэг бүрчилсэн хангалтыг хийсэн. Энэхүү ажил, арга хэмжээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хуваарилсан 5,026.984.2 мянган төгрөгийг зарцуулаад байна. 2020 оны ХАА-ны тайлангаар урсгал төсвийн зардлаар Дотоодын цэргийн нормын хувцас, хоол, хүнсний хангалтад 1,386.1 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
17.3	ЗГҮАХ-ийн 5.4.5 дахь	Цагдаагийн байгууллагын	Улаанбаатар хотын хүрээний	100.0	0.2	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралт "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд	100

	заалт	автопарк шинэчлэл хийх	хөдөлгөөнт эргүүлийн автомашины хангалт, хувиар		Улсын төсөв 7.5 Орон нутгийн төсөв	санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын IX.6.3.5-д Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн парк шинэчлэлд 137.0 сая төгрөгийн төсвийг баталсантай холбоотойгоор 101.4 сая төгрөгийн өртөгтэй "Huandai Elantra" маркийн 2 ширхэг автомашиныг "Монгол Хьюндай Автомотив" ХХК-аас, "Уаз хантер" Маркийн 35,5 сая төгрөгийн өртөгтэй 1 ширхэг автомашиныг "Уаз Мега" ХХК-аас тус тус худалдан авахад нийт 136.9 сая төгрөгийг зарцуулсан. Мөн Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар 60.0 сая төгрөгөөр тусгай тоноглогдсон автомашин авсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2020-2021 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шуурхай үйлчилгээний автомашины парк шинэчлэлтэд 7.5 тэрбум төгрөгийн төсөв баталсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын тамгын газраас сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ажил гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу 90 автомашин худалдан авахаас 73 автомашиныг хүлээн авч, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа газар хэлтсүүдэд 2020 оны 10 дугаар сард хуваарилж олгосон.	
17.4	ЗГҮАХ-ийн 5.4.13 дахь заалт	Хилийн салбарын парк шинэчлэлийг хийх	Нийт автотехникийн шинэчлэгдэх хувь	18.0	7.1 Улсын төсөв	Хилийн салбарын парк шинэчлэлийн хүрээнд 61 нэгж Ланд круйзер 76, 78, 79 загварын автомашиныг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7150.0 сая төгрөгөөр худалдан авч, хилийн салбаруудыг хангасан. Ингэснээр хилийн салбарын парк шинэчлэл 40.6 хувьд хүрсэн.	100
17.5	ЗГҮАХ-ийн 5.4.13 дахь заалт	Хил хамгаалах байгууллагын барилга байгууламжийг сайжруулах	Шинээр барих барилга байгууламжийн тоо	2	3.7 Улсын төсөв	Хил хамгаалах байгууллагын тусгай бэлтгэл, нөхөн сэргээлтийн төвийн уурын зуухны барилга, халаалтын тогоо, гадна дулааны шугам угсрах зэрэг ажлыг 849,9 сая төгрөгөөр хийсэн. Хилийн салбаруудын цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангах зорилгоор Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Баян-Өлгий, Увс аймаг дахь хилийн 7 ангийн 14 салбарт 10 кВт нарны станцыг 2896.7 сая төгрөгөөр суурилуулсан. Говь-Алтай аймаг дахь хилийн 0214 дүгээр ангид 48 айлын орон сууцны засварыг 149.9 сая, Увс аймаг дахь хилийн 0245 дугаар ангийн төвийн барилгуудад их засварыг 99.9 сая төгрөгөөр хийж ашиглалтад оруулсан.	100
17.6	ЗГҮАХ-ийн 5.4.14 дэх заалт	Хилийн салбаруудыг радио станцаар хангах	Хэт богино болон богино долгионы радио станцаар хангах нэгжийн	1386 нэгж	0.045 Улсын төсөв	БНХАУ-ын тусламжаар хилийн дугаар ангиудын боомт тус бүрд суурин станц 1, гар станц 5, нийт 36 нэгж станц олгосон.  Урсгал санхүүжилтээс багаж хэрэгслийн зардлаар хилийн 0151	100

			тоо			дүгээр ангид 35 ширхэг, 0130 дугаар ангид 5 ширхэг, 0303 дугаар тусгай салбарт 15 шрхэг, нийт 55 ширхэг гар станцыг 20.9 сая төгрөгөөр, Хилийн 0165, 0130, 0168, 0129, 0184, 0285, 0311, 0277, 0257, 0286, 0287, 0151 дүгээр ангиудад дахин дамжуулагч 10 ширхгийг 17.0 сая төгрөгөөр, холбогч станц 8.0 сая төгрөгөөр тус тус худалдан авсан.	
17.7	ЗГҮАХ-ийн 5.2.8, 5.2.9, 5.2.10 дахь заалт	Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээний цогцолбор төв байгуулах	"Нэг иргэн- нэг бүртгэл" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30.0	0.5 Гадаад эх үүсвэр	Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд: - Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй үлдсэн сум, тосгоноос 2020 онд 92 сум, хороог холбосон. - Цахим үйлчилгээний систем /www.burtgel.mn/-ээр улсын бүртгэлийн 28 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна. 2020 онд иргэний үнэмлэх дахин авах үйлчилгээ 915, хуулийн этгээдийн оноосон нэрийн 371 хүсэлт баталгаажуулж, 30116 лавлагаа олгосон. - Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас хэрэгжүүлж буй төрийн цахим үйлчилгээний нэгдсэн /e-mongolia.mn/ системд Улсын бүртгэлийн ерөнхий газраас дээрх лавлагаанууд болон иргэний цахим үнэмлэх дахин авах, үндэсний энгийн гадаад паспорт дахин авах үйлчилгээнүүдийг нэвтрүүлсэн ба тус системээр нийт 83237 лавлагаа, үйлчилгээ олгоод байна. - Монгол Улсын харьяатаас гарсан бүртгэлийн сангийн 30922 хувийн хэргийн 68368 хуудас баримт, нас барсны бүртгэлийн сангийн 463454 хувийн хэргийн 2046724 хуудас баримт буюу нийт 2115092 хуудас баримтыг цахимжуулах ажлыг 100 хувь гүйцэтгэж, баталгаажуулалтын ажил 85 хувьтай хийгдэж байна. - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтыг улсын хэмжээнд бүрэн цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Тайлангийн хугацаанд шинэ хувийн хэрэг, баяжилтаар 30248 хуулийн этгээдийн 685105 хуудас баримт бичгийг цахимжуулан улсын бүртгэлийн цахим санд оруулсан бөгөөд улсын бүртгэлийн өдөр тутмын болон мэдээлэл, лавлагаанд ашиглаж байна. Улсын бүртгэлийн үйлчилгээний цогцолбор төв байгуулах ажлын хүрээнд тайлант хугацаанд дараах ажлыг гүйцэтгэв: - Улсын бүртгэлийн ерөнхий газрын Архив, үйлчилгээний цогцолбор төвийн 23/19-ИТ шифртэй ажлын зураг төслийг	100



					<p>2020 оны 3 дугаар сарын 6-ны өдөр экспертизээр батлуулсан;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 342 тоот тогтоолын дагуу тус газрын Үйлчилгээний 2, 3 дугаар байрыг буулгаж талбайг чөлөөлсөн;</li> <li>- 2020 оны 04 дүгээр сарын 16-нд нийт 8914.4 м.кв талбай бүхий барилгыг 14,9 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "Хос бар" ХХК-тай гэрээ байгуулсан.</li> <li>- Барилгын В, С блок, дэд станц хуваарилах байгууламжийн бэлтгэл ажлууд, С блок, цахилгааны дэд станц хуваарилах байгууламжийн газар шорооны ажил, цахилгаан дэд станц хуваарилах байгууламжийн ханын өрлөг, төмөр бетон хучилт, заслын ажлууд, барилгын С блокийн зоорины давхрын цутгалт, В блокийн суурийн цутгалтын ажил тус тус хийгдсэн.</li> <li>- Захиалагчийн хяналтаар үе шат бүрд хяналт хийж байна. Барилга угсралтын ажил 2020 оны 12 сарын 14-ний өдрийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй.</li> </ul> <p>"Нэг иргэн-нэг бүртгэл" үндэсний хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 83.15 хувьтай байна. ХЗДХЯ-ны улсын төсвийн урсгал зардалд "Нэг иргэн-нэг бүртгэл" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 430.0 сая төгрөг батлагдсаны сонгон шалгаруулалт зарлаж, 421.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авсан.</p>	
				7.5		
				Улсын төсөв		
				0.4		
				Улсын төсөв		
17.8	Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.а дахь заалт, Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.3.3.3 дахь	Хүн ам, орон сууцны улсын тооллогыг явуулж, үр дүнд үндэслэн дэлгэрэнгүй судалгаа хийх, нийтэд тархаах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0		100
					<p>Монгол Улсын 11 дэх удаагийн Хүн ам, орон сууцны тооллогыг холбогдох хууль тогтоомж болон Нэгдсэн Үндэсний байгууллагын Статистикийн хэлтсээс гаргасан тооллогод баримтлах зарчим зөвлөмжийг үндэслэн амжилттай зохион байгуулж, тооллогын үр дүнгээр хураангуй тайлан гаргаж, Үндэсний Статистикийн хорооны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн. Тооллогын хүрээнд дараах ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Тооллогын ухуулга, сурталчилгааны ажлыг улс орон даяар болон нийслэл, бүх аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч (ТВ, радио, сонин, цахим орчин) зохион байгуулан, сурталчилгааны материал тарааж, байршуулсан.</li> <li>2. Тоолох, хянах үйл ажиллагааны талаар 3048 тоологч, шалгагч</li> </ol>	



	заалт				<p>нарт зориулсан сургалтыг аймаг, нийслэлийн тооллогын комисс, түр товчоод зохион байгуулсан. Тоолох, хянах үйл ажиллагаа, тооллогын мэдээллийг хүлээн авагч, шивэгч, кодлогч нарт зориулсан 50 хүний сургалтыг зохион байгуулсан.</p> <p>3.Үндэсний Статистикийн хорооны ажлын хэсэг Улсын комисс, комиссын гишүүд, тооллогын салбар ажлын хэсэг, аймаг, нийслэл, сум, дүүргийн тооллогын комисс, орон нутгийн түр товчоод, тоологч, шалгагч нарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, шуурхай мэдээллээр хангаж ажиллалаа. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын мэдээлэл цуглуулах үе шатанд бүх шатны комисс, түр товчооны 15675 гишүүд, ажилтан, 72 сургагч багш, 595 шалгагч, 2274 тоологч, нийт 18616 хүн ажиллаж, нийт 94622 тооллогын нэгжээс тооллогын мэдээллийг, 9443 тооллогын нэгжээс хяналтын тооллогын мэдээллийг цуглуулан авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу хариуцлагатай жижүүр хийж, заавар, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>4.Тооллогын үр дүнгээр хийгдсэн улсын тайлангийн 12 бүлгийн хүн амын асуудлаар 108, өрхийн 30, боловсрол 20, гадаадад оршин суугаа иргэдийн 11, хөгжлийн бэрхшээлийн 22, байшин, орон сууцны 29, интернэт, гар утасны хэрэглээгээр 15, нийт 235 хүснэгтүүдийг SPSS программ дээр боловсруулж, гарган, аймаг, нийслэлээр тус бүр задлан асуулгын боломжит бүх үзүүлэлтийг гаргаж, хураангуй болон хуудас дэлгэрэнгүй тайлан бичиж, хянуулан, засварыг хийж, хураангуй тайланг монгол, англи хэл, монгол бичгээр, дэлгэрэнгүй тайланг монгол, англи хэлээр статистикийн мэдээллийн санд байршуулан, хэвлүүлсэн.</p> <p>5.Аймаг, нийслэлийн дэлгэрэнгүй тайлан хэвлүүлэх зардал, сэдэвчилсэн судалгаа бичих болон улсын тайлангийн орчуулгын зардлын тооцоо хийж, батлуулсан. Сэдэвчилсэн 7 судалгааны багыг сонгон шалгаруулж, гэрээ хийж, явцтай холбоотой онлайн хурал зохион байгуулав. Тооллогын үр дүнгээр хийгдсэн 6 сэдэвчилсэн судалгааг хянаж, эцэслэн, статистик мэдээллийн санд байршуулсан. Хүн ам зүйн атласын шаардлагатай нэмэлт хүснэгтүүдийг гаргаж, сэдэвчилсэн судалгаануудын тайланг хүлээн авч гэрээ дүгнэсэн актыг бэлтгэн санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгөв.</p> <p>6. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Завхан аймгийн тархаалтын семинарын илтгэл бэлтгэж, Баян-Өлгий, Архангай аймагт тооллогын мэдээллийн тархаалтын семинарын бэлтгэл ажлыг хийж, зохион байгуулж явуулсан байна.</p>
--	-------	--	--	--	---

17.9	ЗГҮАХ-ийн 5.2.8 дахь заалт	Үндэсний гадаад паспортод бичилт хийх, программ хангамж тоног төхөөрөмж нийлүүлэх	Гадаад паспортын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэлт, угсралтын ажлын гүйцэтгэл, хувиар	100.0	3.7 Улсын төсөв	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/64 тушаалаар Гадаад паспортын бэлдцэд бичилт хийх, техник, тоног төхөөрөмж, программ хангамж бүхий системийг нийлүүлэх, суурилуулах, нууцлал, аюулгүй ажиллагааг хангах, ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан. Энэ хүрээнд 2020 оны 11 сарын 28, мөн 12 сарын 10-ны өдөр гадаад паспортын бэлдцэд бичилт хийх тоног төхөөрөмж, системийг хүлээж авсан. Үндэсний гадаад паспортын бэлдцэд бичилт хийх, хэвлэх зориулалттай техник, тоног төхөөрөмж, программ хангамж бүхий систем нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хууль журмын дагуу ажиллаж, ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулсан. Үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн байрыг олон улсын стандартын шаардлагыг хангасан байдлаар засварлан нууцлал, орчны аюулгүй байдлыг хангах хөдөлгөөн мэдрэгч утаа мэдрэгч дохиоллын систем, тусгай код хурууны хээгээр онгойдог хаалга, галын хор, агааржуулагч гэх мэт тоног төхөөрөмжийг суурилуулсан. Бичилтийн үйлдвэрийн хэвлэх машин, сервер тоног төхөөрөмжийг суурилуулж дотоод сүлжээг зохион байгуулсан. Хуваарийн дагуу иж бүрэн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж, 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр системийг хүлээж авсан. 2021 оноос эхлэн олон улсын стандарт шаардлагыг хангасан санах ой /чип/ бүхий гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.	100
17.10	ЗГҮАХ-ийн 5.2.8, 5.2.9, 5.2.10 дахь заалт	Монгол Улсын Их Хурлын ээлжлэлт сонгууль зохион байгуулах бэлтгэлийг хангаж, техник хэрэгслээр хангах	Сонгуулийн техник хэрэгслийн хангалт, хувиар	100.0	1.1 Улсын төсөв	УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд зориулж 3.0 тэрбум төгрөг батлагдсаны дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн А/595 тоот тушаалаар нийт зарцуулах зардлыг батлан хэрэгжилтийг хангаж ажилласан.Тухайлбал, Улсын бүртгэлийн байгууллагын болон итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хэвлэх, сургалт зохион байгуулах болон сонгуулийн үеэр ажиллах техник хэрэгслийг тээвэрлэх, мэдээлэл сурталчилгааны зардал зэргийг хуваарилж, шийдвэрлэсэн. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 40 ширхэг компьютер, 40 ширхэг сканер, 1 ширхэг сервер, 1 ширхэг сторез, сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагдах 430 ширхэг зөөврийн компьютер, 100 ширхэг принтер, 600 ширхэг хурууны хээ уншигчийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100

17.11	ЗГҮАХ-ийн 5.4.7 дахь заалт	Шүүхийн шинжилгээний байгууллагын дигитал судлалын шинжилгээний чадавхыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.05  ШУТС	<p>Дигитал судлалын шинжилгээний лаборатори байгуулах ажлын хүрээнд гэрэл зураг, дүрс бичлэг, дүрс зургийн шинжилгээний лабораторид дуу авианы шинжилгээ хийхэд шаардлагатай "Икар-лаб-2" техник, тоног төхөөрөмжийг худалдан авч, 2020 онд 23 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. БНСУ-ын Прокурорын дэргэдэх Шүүхийн шинжилгээний төвтэй программ ашиглалтын гэрээ байгуулж, "СFT" дигитал судлалын шинжилгээний программ хангамжийг авч, шинжилгээнд ашиглаж байна.</p> <p>БНСУ-ын "КОЙКА" Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжийн хүрээнд "Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Уг төслийн Техник эдийн засгийн нарийвчилсан үзүүлэлтийг "КОЙКА"-ийн судалгааны баг бүрэн хийж дуусгаад 100.0 сая долларын төсөвт өртөгтэй төслийн нээлт хийсэн боловч, "Ковид-19" цар тахлаас хамаарч хойшлогдсон.</p>	100
17.12	ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь заалт	Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх программ хангамжийг нэвтрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.038  Улсын төсөв	<p>Визийн зөвшөөрөл, хувийн урилга цахимаар олгох үйлчилгээ 2017 онд бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд 2018 онд "evisa.mn" системийг өргөтгөж сайжруулах зорилгоор дагалдах техник, программ хөгжүүлэлт, цахим лавлагаа, цахим визийн хүсэлт, тайлангийн автоматжуулалтын системийг хийж гүйцэтгэсэн. Мөн "evisa.mn" цахим хуудасны "SSL" хамгаалалтыг тохируулж аюулгүй байдлыг сайжруулсан. 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс "Ковид-19" вирустэй холбоотойгоор evisa.mn программд тусгай хүсэлтийг хүлээж авах нэмэлт үйлчилгээ, мөн А2 болон S1 ангиллын оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулах цахим хүсэлтийг тус тус нэвтрүүлсэн. Дээрх үйлчилгээ, системүүдийг нэвтрүүлснээр 9 төрлийн визийн зөвшөөрөл, виз сунгуулах хүсэлтийг цахимаар хүлээн авах боломжтой болсон. Тус онд нийт 3449 хүсэлтээр 7572 гадаадын иргэнд цахимаар үйлчилгээ үзүүлж, хариуг цахим зурвас (SMS), цахим шуудан (EMAIL)-гаар өгч ажилласан. Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.</p>	100
17.13	ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь	"ISM" системийн өргөтгөл, сайжруулалтын хүрээнд "APIS буюу APP"	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.048  Улсын төсөв	<p>"Хилийн хяналт шалгалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 306 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд "SITA", "ARINC/Owinfo" компаниудаас гэрээний төсөл, санхүү болон техникийн саналуудыг хүлээн авч, холбогдох уулзалтуудыг</p>	70



	заалт	системийг холбож, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх				зохион байгуулсан, Мөн Гадаад харилцааны яамнаас НҮБ-ын Терроризмтой тэмцэх албанаас хэрэгжүүлж буй зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд систем /goTravel/-ийг Монгол Улсад нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, уг хөтөлбөрт хамрагдах санал ирүүлсэн. Иймд зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд системийг нэвтрүүлэх зорилгоор гэрээ байгуулахтай холбогдуулан төрийн байгууллагуудаас гаргасан зарчмын зөрүүтэй саналыг эцэслэж, /goTravel/-ийг Монгол Улсад нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газрын тогтоолд өөрчлөлт оруулах саналыг 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн н/31 дүгээр албан бичгээр Тагнуулын ерөнхий газарт хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд Тагнуулын ерөнхий газар нь Терроризмтой тэмцэх зөвлөлийн хурлаар төрийн байгууллагын зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцүүлэн эцэслэж, Засгийн газарт танилцуулахаар тогтоод байна.	
17.14	ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь заалт	Гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах баримт бичгүүдийн бүрдлийг цахим хэлбэрээр бүрдүүлэх боломж бүхий төрийн байгууллагуудын хооронд холбосон дэд бүтэц, системийг бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.038  Улсын төсөв	Үндэсний дата төвтэй байгуулсан гэрээний дагуу Хил хамгаалах ерөнхий газарт байрших "ISM" системийн үндсэн серверээс гадаадын иргэнтэй холбоотой мэдээллийн сангийн хэсэгчилсэн хуулбар мэдээллийн санг Гадаадын иргэн, харьяатын газарт хуулбар сервер үүсгэн байршуулав. Байгууллагын хэмжээнд "ХУР" мэдээллийн сангаас мэдээлэл авч харуулах зорилго бүхий дундын программ кангамж, системийг хөгжүүлэн 2019 оны 07 дугаар сард бэлэн болгосон. "ХУР" төрийн мэдээлэл солилцооны системээс нийт 48 сервис үйлчилгээг авч байгаа бөгөөд лавлагаа, тодорхойлолт, мэдээллийн 21 сервис үйлчилгээг "ХУР" системээр дамжуулан Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Үндэсний хөгжлийн газарт ашиглуулж байна. 2020 оны байдлаар Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар, Үндэсний хөгжлийн газар зэрэг байгууллагуудтай мэдээллийн сүлжээгээр холбогдсон бөгөөд төрийн үйлчилгээний "e-mongolia.mn" цахим хуудсаар дамжуулан гадаадын иргэний тодорхойлолт, лавлагаа шаардлагатай төрийн бусад байгууллагууд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	100
17.15		Их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг нэмэгдүүлж,	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.112  Улсын төсөв	Хууль зүйн салбарын инновацын дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний дагуу 2020 онд инновацын шилдэг бүтээл шалгаруулах уралдааныг Их сургуулийн цахим хуудсаар дамжуулан зарлаж, 15 инновацын	70



	ЗГҮАХ-ийн 3.2.18, 3.2.19 дэх заалт	сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухаан, технологийн ололт, төрийн бодлоготой уялдуулан, багш судлаач, албан хаагч, сонсогчдын чад авхыг нэмэгдүүлэх				төслийг хүлээн авч шалгаруулалтыг зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэхээр шинээр "Цагдаагийн ажил-эрх зүй" сургалтын индексэд нийцүүлэн мэргэшүүлэх чиглэлээр "Цагдаа- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил", "Замын хөдөлгөөний аюулгүй байдал", "Мөрдөх алба-эрх зүй" сургалтын индексэд нийцүүлэн мэргэшүүлэх чиглэлээр "Эдийн засгийн мөрдөгч-эрх зүй" 2 жилийн сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтын төлөвлөгөөг 120 багц цагт шилжүүлэн, нийт 520 хичээлийн хөтөлбөрийг индексжүүлсэн. Мөн "Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр", "Суралцагчдын хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийг тус тус батлан хэрэгжилтийг хангаж байна. Их сургуулийн үйл ажиллагаанд олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, боловсролын чанарын ISO 21001:2018 стандартуудыг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. 2020 оны 01 дүгээр сард нийт 137 багшлах бүрэлдэхүүнд багшлах ур чадварын 5, ОХУ-ын ДХЯ-ны Уфагийн Хуулийн дээд сургуультай хамтран заах арга зүйн семинарт 3 багшийг тус тус оролцуулсан. Шинээр Их сургуульд томилогдсон 19 багшийг багшлах эрх олгох сургалтад хамруулсан. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисстой хамтран ажиллах санамж бичгийг 2020 оны 10 дугаар сард байгуулсан.	
17.16	ЗГҮАХ-ийн 5.4.11 дэх заалт	Төрийн архивуудын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх	Цахим хэлбэрт шилжүүлэх хадгаламжийн нэгжийн тоо	55 мянга гаруй хадга- ламжийн нэгж	0.6  Улсын төсөв	2017-2020 оны байдлаар 75933 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлсэн. 2020 онд 12505 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэхээс 13059 хадгаламжийн нэгж баримтыг цахим хэлбэрт шилжүүлээд байна. 100 хүнийг гэрээт ажилтнаар ажиллуулсан бөгөөд цалингийн зардалд 575.9 сая төгрөг гэрээт ажилтны цалин урсгал зардлаас зарцуулсан.	100
17.17	МУТХҮБ-2030- ын 2.2 дахь заалт	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмчилгээний тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Гэмтлийн дараах эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтын хувь	100.0	0.033  ЭМДС  Улсын төсөв	Гэмтлийн дараах эмчилгээний тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тус онд 22 нэр төрлийн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг үе шаттай нэвтрүүлсэн. Тухайлбал, Спортын гэмтлийн болон гэмтлийн мэс заслын тусламж, үйлчилгээнд хэрэглэх протез, ортопед, эмнэлгийн 4 төрлийн багаж, техник хэрэгслүүдийн худалдан авалт хийсэн. Гэмтлийн дараах эмчилгээний тоног төхөөрөмж 100 хувь хангагдсан. Мөрний үений дурангийн мэс заслыг нутагшуулах ажлын хүрээнд мөр өргөгч булчингуудын гэмтэл, мөрний сурмаг мултрал, эгэм, далны шонтонгийн үений бүтцийн өөрчлөлт, мөрний үений уутны үрэвсэл зэрэг гэмтлүүдийн үед дурангийн мэс заслаар	100

						эмчлэх аргыг 35 (100%) хүнд амжилттай хийсэн. Дээрх багаж, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар 2020 онд Гэмтлийн тасагт нийт 393 мэс засал хийснээс яаралтай 10, төлөвлөгөөт хагалгааг 383 хүнд хийсэн. Мөн шагайн гадна хавчаар ясны үе дайрсан хугарлын гэмтлийн үөний мэс заслыг бага хүрцээр зүсэх хагалгааг 6 хүнд тус тус хийсэн байна.	
17.18	ЗГҮАХХАХТ-ний 5.1.16, 5.3.5.12 дахь заалт	Прокурорын байгууллагын боловсон хүчний чадавхыг сайжруулах, барилга, конторын их засвар, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	5.7 Улсын төсөв	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасан "Хуулиар төрийн нууцад хамруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж заасны дагуу прокурорын байгууллагын барилга нь тусгай зориулалтын байгууламжид хамрагдах тухай холбогдох газрын тодорхойлолт гарсан. Үүний дагуу сонгон шалгаруулалтаар ажил гүйцэтгэх компанийг сонгож, гэрээг байгуулан ажлыг эхлүүлж холбогдох арга хэмжээг тухай бүр аван ажиллалаа. Прокурорын байгууллагад хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгслийн худалдан авсан хугацаа, ашиглалт зэргээс үүдсэн хангалтыг үе шаттайгаар хийх шаардлагатай. Үүний дагуу тайлант онд нээлттэй төндөр шалгаруулан "ХАК" ХХК, "Жөм нэт" ХХК, "Вертөксмон" ХХК, "Бодь электроникс" ХХК, "Грандмакс" ХХК зэрэг компаниудтай гэрээг байгуулан гэрээний дагуу барааг хүлээн авч, нэгж прокурорын газруудад хуваарилсан. Прокурор, ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор нийт нэгж газрууд сургалтын төвүүдтэй сургалт хийх гэрээг байгуулсан. Мөн тайлант хугацаанд "Ковид-19"-өөс үүдэн зарим сургалт цахим хэлбэрт шилжсэн тул прокурорын байгууллагын нэгж газруудад сургалтад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангалтыг хийсэн.	100
17.19	МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 2	Сонгуулийн санал тооллогын техник хэрэгслийг шинэчлэх арга хэмжээг авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	1.4 Улсын төсөв	Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн зардал батлагдсаны дагуу Сонгуулийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг нийлүүлэх аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Комиссыг Сонгуулийн ерөнхий хороо, Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын хамтарсан 2019 оны 17/112/133 дугаар тогтоол/тушаалаар баталсан "Сонгуулийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг нийлүүлэх, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах журам"-ын дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын А/05 дугаар	100

						<p>захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Дээрх комиссын 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн саналыг Сонгуулийн ерөнхий хорооны хуралдаанаар авч хэлэлцээд Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 08 дугаар тогтоолоор гэрээ байгуулах эрх олгосны дагуу АНУ-ын Доминион Воутинг Симтем компанитай 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр УИХ/09 дүгээр гэрээг байгуулсан байна. Уг гэрээнд сонгуулийн санал авах, тоолох, дүн гаргах ICP төхөөрөмж 250 ширхгийг худалдан авахаар тусгасан. 2020 оны 6 дугаар сарын 04-06-ны хооронд 250 ширхэг ICP төхөөрөмжид техникийн хүлээн авах шалгалтыг хийж, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн санал хураалтын үйл ажиллагаанд нийслэлийн хэсгүүдэд ашигласан.</p> <p>АНУ-ын Доминион Воутинг Симтем компаниас тоног төхөөрөмж хүлээлгэж өгөх ажилтнууд Коронавируст /Covid-19/ цар тахалтай холбоотойгоор ирэх боломжгүй болсон бөгөөд 2 талын биечилж хийх хүлээлцэх баримт бичиг бүрдэхгүй байснаас дээрх тоног төхөөрөмжийн төлбөрийг 12 дугаар сард хийсэн.</p>	
<b>Зорилт 18. Үндэсний стандартын тоог нэмэгдүүлж, стандарт, хэмжил зүй, мэргэжлийн хяналтын орон нутгийн чадавхыг сайжруулна.</b>							
18.1	МУТХҮБ-2030-ын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.5, 2.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.7 дахь заалт	Монгол Улсын үндэсний стандартыг шинээр боловсруулан баталж, орон нутгийн стандартын байгууллагын чадавхыг бэхжүүлэх	Шинээр боловсруулж батлуулах стандарт	5	0.4 Улсын төсөв	<p>Монгол Улсын үндэсний стандартыг шинээр боловсруулж, мөрдүүлэх хүрээнд 2020 онд стандартчиллын ажлын хөтөлбөрт тусгагдсан дараах 10 стандартыг үндэсний стандартаар шинээр баталсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Текстиль. Ноос, ноолууран нэхмэл драп. Техникийн ерөнхий шаардлага MNS 6816:2020;</li> <li>- Текстиль. Амны даавуун хаалт. Техникийн шаардлага MNS 6828:2020;</li> <li>- Хялгасыг нь ялгасан хонины ноосны ноолуур. Техникийн шаардлага MNS 6398:2020;</li> <li>- Хатаамал сүү, сүүн бүтээгдэхүүн. Техникийн шаардлага MNS 6858:2020;</li> <li>- Зөгийн гэр. Техникийн шаардлага MNS 6829:2020;</li> <li>- Хүнсний арвай. Техникийн шаардлага MNS 3810:2020;</li> <li>- Хамгаалах хувцас-Халдвар үүсгэгчээс хамгаалах хувцсанд тавих шаардлага ба шинжлэх арга MNS EN 14126:2020;</li> <li>- Эмнэлгийн зориулалттай нэг удаагийн хамгаалах хувцасны техникийн шаардлага MNS GB 19082:2020;</li> <li>- Байгалийн ба органик гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний</li> </ul>	100



						<p>орц найрлага болон бүтээгдэхүүнд тавих шаардлага, техникийн тодорхойлолтын удирдамж 1-р хэсэг: Орц найрлагын тодорхойлолт MNS ISO 16128-1:2020;</p> <p>- Байгалийн ба органик гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлага болон бүтээгдэхүүнд тавих шаардлага, техникийн тодорхойлолтын удирдамж 2-р хэсэг: Орц найрлага болон бүтээгдэхүүнд тавих шаардлага MNS ISO 16128-2:2020.</p>	
			Шинээр ашиглалтад орох барилга	1		Дорнод аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга болон лабораторийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлж, 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч ашиглалтад оруулсан. Уг барилга ашиглалтад орсноор стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааг стандартын шаардлага хангасан нөхцөлд явуулах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлсэн.	
18.2	МУТХҮБ-2030-ын 2.1.7, Зорилт 1, ЗГҮАХХАХТ-ний 2.18, 2.23 дахь заалт	Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх	Шинээр ашиглалтад орох барилга	2	2.4 Улсын төсөв	Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгыг "Хан жаргалант стоунс" ХХК барьж дуусгасан бөгөөд барилгыг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр улсын комисс хүлээн авсан. Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгыг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр ашиглалтад бүрэн оруулсан бөгөөд 923.8 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг барилгын ажлыг гүйцэтгэгч "Оазислэнд констракшн" ХХК-д 2020 оны 1 дүгээр сард бүрэн шилжүүлсэн.	100
<b>Зорилт 19. Хил орчмын дэд бүтцийг хөгжүүлж, хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлнэ.</b>							
19.1	Гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид ГБУБ гэх/-ын 3.21.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.6.5, 5.6.7 дахь заалт	Хөрш орнуудтай хийх гадаад худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлын явц, хувиар	100.0	-	Шадар сайдын ажлын албанаас "Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг соёрхон батлуулахаар Улсын Их Хуралд 2019 онд өргөн барьсан хэдий ч, хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцээгүй хүлээгдэж байна.	0



19.2	ГБҮБ-ын 2.14.1 дэх заалт, ЗГҮАХ- ийн 5.6.2 дахь заалт	Монгол Улс- ОХУ-БНХАУ-ын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төвийг байгуулах ажлыг эрчимжүүлэх	Төв байгуулах ажлын явц, хувиар	30.0	0.1  Улсын төсөв	<p>Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төвийг байгуулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд 2020 онд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гурван тал 2020 онд "Монгол, Орос, Хятадын Эдийн засгийн коридорын Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-ийн ажлыг эхлүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл" болон түүний хавсралт болох "Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-ийн Ажлын төлөвлөгөө"-ний төслийг монголын талаас 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн Е/07/20/132, 2 дугаар сарын 20-ны өдрийн Е/07/20/17, 4 дүгээр сарын 23-ны өдрийн Е/07/20/260, 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Е/07/20/314 цахим тоотыг Бээжин, Москва дахь Элчин сайдын яамдад хүргүүлж, ОХУ-аас 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн Д25и-1300 тоот, 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Д25и-7968 тоот, 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн Д25и-14381 тоотоор, БНХАУ-аас 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдөр, 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр, 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдөр хариу тус тус ирүүлж, төлөвлөгөөний төслийг зарчмын хувьд тохиролцсон.</li> <li>- "Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг урагшлуулах Хамтарсан ажлын хэсгийн дарга нарын (дэд сайдын түвшний) анхдугаар уулзалтыг 2020 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, талууд тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүдийг урагшлуулах, түүний дотор "Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийн ажлыг эхлүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл", "Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийн Ажлын төлөвлөгөө"-ний төслийг эцэслэн тохиролцож, гурван улсын Төрийн тэргүүн нарын ээлжит уулзалтын үеэр гарын үсэг зурахаар тохиролцсон. Уулзалтын протоколд "Талууд Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридорын Төмөр зам төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийн ажлыг эхлүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл" болон түүний хавсралт "Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийн Ажлын төлөвлөгөө"-д гарын үсэг зурах хугацааг төмөр замын шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн хугацаа гэж тооцож, гурван улсын хамтарсан Хөрөнгө оруулалт, зураг</li> </ul>	100
------	---	---	---------------------------------------	------	---------------------------	---	-----

						төслийн төвийн дүрмийн төслийг ойрын хугацаанд тохиролцох саналыг монголын тал дэвшүүлээд байна.	
19.3	ГБҮБ-ын 6.27.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.9 дэх заалт	Хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Цахим хэлбэрт шилжүүлэх консулын үйлчилгээ	6	0.0025  Улсын төсөв	Хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд 2020 онд дараах 6 цахим үйлчилгээг сайжруулах ажлуудыг шинээр хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Хилийн чанадад 90-с дээш хоног сууж буй 25,803 монгол иргэн <a href="http://www.citizen.gov.mn">www.citizen.gov.mn</a> цахим хуудсанд хандан сайн дурын үндсэн дээр бүртгүүлээд байна. Монгол Улсын иргэний 16 хүртэлх насны гадаад улсын харьяат хүүхэд тус улсад 90 хүртэл хоногоор хувийн хэргээр зорчиход гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөл шаардахгүйгээр виз олгож байсныг өргөжүүлж Монгол Улсын харьяатаас гарсан, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүнд "Н" (хувийн хэргээр зорчих гадаадын иргэнд олгодог) ангиллын 90 хүртэл хоногийн нэг болон хоёр удаагийн визийг урьдчилсан зөвшөөрөл шаардахгүйгээр олгож байна. 2. Гадаад харилцааны яамны Консулын газар Монгол Улсад 30-аас доош хоног албан ажлаар зорчих гадаадын иргэний визийн урилгын мэдүүлгийг <a href="http://consul.mn/index.php?moduls=8">http://consul.mn/index.php?moduls=8</a> цахим хуудсаар хүлээн авч баталгаажуулан, холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт зөвшөөрөл хүргүүлж, улмаар зохих ангиллын виз олгож байна. 3. Дипломат, албан паспортын бүртгэл, биометрийн мэдээллийн санг тогтмол баяжуулж байгаа бөгөөд энгийн, албан, дипломат паспортын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх нөхцөл хангагдсан хэдий ч Гадаад харилцааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газрыг сүлжээгээр холбох, нэгдсэн сан байгуулах, техникийн аюулгүй байдлын болон санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 4. Хилийн чанадад суугаа Монгол Улсын ДТГ-уудад үйлдсэн иргэдийн итгэмжлэлийг ГХЯ-ны Консулын газраар дамжуулан авах, итгэмжлэл ирсэн эсэхийг шалгах цонхыг шинээр	100

					<p><a href="http://www.consul.mn">www.consul.mn</a> цахим хуудаст байрлуулсан. ГХЯ-ны Консулын газар Монголын Нотариачдын Танхимтай хамтарсан ажлын хэсгийг 2020 оны 2 сарын 10-ны өдөр ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/18 тоот тушаалаар байгуулж, “Цахим нотариат” системд ГХЯ-ны Консулын газар, ДТГ-уудын нотариатын үйлчилгээ, консулын баталгаажуулалтыг хамруулах, апостиль гэрчилгээний хүсэлтийг цахимаар авах, гэрчилгээний болон баталгаажуулалтын бичилт хийх зориулалттай тусгайлсан программ хангамжийг боловсруулах, шаардлагатай гэрээг байгуулахаар ажиллаж байна. Түүнчлэн 2020 оны жилийн эцсийн байдлаар апостиль гэрчилгээ 7,914 ширхэг, ДТГ-аас ирүүлж, иргэдэд олгосон итгэмжлэл 9,004 ширхэг, ДТГ-уудаас илгээсэн баримт бичиг 1,523 ширхэг, консулын баталгаажуулалт 5,908 ширхэг үйлчилгээг иргэдэд үзүүлсэн.</p> <p>5. Гадаадад оршин суугаа иргэдийн иргэний бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа, мэдээллийг ДТГ-ууд УБЕГ-аас цахим шуудангаар авдаг тогтолцоог бүрдүүлж, гадаадад оршин суугаа иргэдийн гэмт хэрэгт холбогдсон эсэх, жолооны үнэмлэхийн лавлагааг Консулын газраар дамжуулан цахим шуудангаар ажлын 2-7 өдөрт авч хэвшсэн. Хилийн чанадад байгаа монгол иргэдийн иргэний бүртгэлийн болон гадаад паспортын лавлагааг <a href="mailto:civil.reg@burtgel.gov.mn">civil.reg@burtgel.gov.mn</a> хаягаар шуурхай (ажлын 8-14 цагт) авах боломжийг бүрдүүлэн хэрэгжүүлж байна. Иргэдийн захиалсан гадаад паспортыг цаг алдалгүй шуурхай хүргэх зорилгоор зарим ДТГ-дад олон улсын DHL буухиа шуудангийн үйлчилгээ авах зөвшөөрлийг олгож, амжилттай хэрэгжүүлж байна. Дэлхийн 215 гаруй улсад тархаад байгаа шинэ төрлийн коронавирусын цар тахлаас үүдэн дэлхийн ихэнх улс хилээ хааж, олон улсын нислэг, автозамын хөдөлгөөн, шуудан үйлчилгээг хязгаарласан тул иргэдийн гадаад паспортын захиалга буурсан үзүүлэлттэй (2020.01-12 дугаар сард нийт 3,472 ширхэг энгийн гадаад паспорт) байна.</p> <p>Хилийн чанадад гэмт хэрэг үйлдсэн, ял эдэлж байгаа, нас барсан иргэдийн бүртгэлийн программыг тогтмол ашиглаж, 1,894 иргэний бүртгэлийг хөтөлж байна. Энэ хүрээнд Төрийн мэдээллийн “ХУР” систем болон өрхийн мэдээллийн системийг Консулын газрын ажлын хэрэгцээнд ашиглаж байна.</p> <p>6. Гадаад харилцааны яамны өргөдөл, гомдлын бүртгэл,</p>
--	--	--	--	--	--

шийдвэрлэлт, хяналтад ашигладаг Offshare программын мэдээгээр 2020 онд иргэдээс 1,454 өргөдөл, гомдол ирүүлснээс 1,414 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж (шийдвэрлэх хугацаа болоогүй 40 өргөдөл), шийдвэрлэлтийн байдал 97.3 хувьтай байна.

7. Гадаад харилцааны яамыг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх арга хэмжээ авах хүрээнд хилийн чанадад байгаа монгол иргэдэд хүргэх боломжтой төрийн үйлчилгээний төрлийг тодорхой болгох, хэрэгжүүлэх аргачлалыг гаргаж, зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэг бүхий холбогдох байгууллагын төлөөлөлтэй ажлын хэсгийг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын А/105 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Түүнчлэн дараах бусад үйлчилгээг шинээр ашиглалтад оруулаад байна. Үүнд:

- Гэрэгэ киоск бэлэн бус мөнгөн төлбөр гүйцэтгэх машиныг 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс ГХЯ-ны Консулын газарт байрлуулж, иргэдийн төлбөр тооцоо хийх нөхцөлийг хөнгөвчилж, 2020 онд 8 төрлийн үйлчилгээг 2,472 хүнд үзүүлсэн байна.
- Цар тахлын улмаас гадаад улсад зорчиж яваад нутаг буцах боломжгүй болсон монгол иргэдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авах, заавар, зөвлөгөө, сэрэмжлүүлэг өгөх зорилгоор “70082222” автомат дуудлагын дугаар, 83042222, 83052222 шуурхай утсыг 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс 24/7 цагаар ажиллуулж, өдөрт 30-40 дуудлагад хариу өгч байна.
- Дэлхийн 215 гаруй улсад тархаад байгаа шинэ төрлийн коронавирусын цар тахалтай холбоотойгоор 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар дэлхийн 91 улсаас агаарын замаар 106 удаагийн нислэг үйлдэж 20,582 иргэн, Монгол Улс-БНХАУ-ын боомтоор 4,210 иргэн, Монгол Улс-ОХУ-ын боомтоор 2,392 иргэн, нийт 27,184 иргэнийг Монгол Улс зохион байгуулалттайгаар татан авсан.
- Хилийн чанадад зорчих болон коронавируст цар тахлын улмаас гадаад улсад гацсан, эх нутагтаа ирэх боломжгүй байгаа иргэдэд мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлэг хүргэх үүднээс [www.consul.mn](http://www.consul.mn) цахим хуудсыг шинэчилж 120 орчим мэдээ, сэрэмжлүүлгийг байршуулсан. 2020 оны 12 дугаар сарын байдлаар тус цахим хуудсанд 610 мянган хүн хандсан байна.



19.4	ЗГҮАХ-ийн 5.6.8 дахь заалт	“Монгол экспорт” хөтөлбөрийн хэ рэгжилтийг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	<p>Монгол экспорт хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2020 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Гадаад харилцааны сайдаар 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд биелэлт 89.6 хувьтай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох шаардлагыг хангасан тухай НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг-нийгмийн комисст мэдэгдэж, хэлэлцээрийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжүүлэхээр 2020 оны 1 дүгээр сард тохиролцсон.</li> <li>- ГХЯ-ны Хөрөнгө оруулалтын судалгааны төв болон НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Зүүн болон Зүүн-Хойд Азийн газартай хамтран 2020 оны 10 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Эдийн засгийн коридорын менежмент” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, зам тээвэр, эрчим хүч, гааль, хил хамгаалах, мэргэжлийн хяналт, чөлөөт бус, боомтын салбарт ажилладаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын 62 хүн оролцсон.</li> <li>- УИХ-ын 2020 оны 35 тогтоолоор “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулж зарим хүнсний ногооны импортын татварыг нэмэгдүүлж импорт орлох үндэсний үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авсан. Мөн тогтоолоор дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор Дэлхийн Худалдааны Байгууллагын “Хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээр”-т нийцүүлэн “Хамгаалалтын арга хэмжээний журам”-ыг батлах, хэлэлцээрийн хүрээнд үйлчлэх импортын барааны тоо хэмжээний хязгаар болон гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох талаар Засгийн газарт үүрэг болгосны дагуу Хамгаалалтын арга хэмжээний журмын төслийг боловсруулж яамдаас санал авч, Засгийн газрын тогтоолын төслийн хамт 2020 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</li> <li>- “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” байгуулах төслийг амжилттай хэрэгжүүлж, 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр ашиглалтад оруулсан.</li> <li>- Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас экспортын бараанд олгож байгаа зөвшөөрлийн үйл ажиллагааны цахим хуудсыг хөгжүүлж төрийн мэдээллийн “Хур” цахим системд 2020 онд холбосон.</li> </ul>	70
------	----------------------------------	---	---	-------	---	----

						<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар жил бүрийн 12 дугаар сарын 3 дахь долоо хоногийн бямба гарагийг “Экспортлогчдын тэмдэглэлт өдөр” болгон тэмдэглэхээр шийдвэрлэсэн.</li> <li>- Засгийн газраас 2020 оныг “Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийн ашиглалт, экспортыг нэмэгдүүлэх жил” болгож, Ази тивийн сүү үйлдвэрлэлийн нарийн бичгийн дарга нарын газрыг Улаанбаатар хотод байгуулах тухай Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг баталсан.</li> <li>- Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөнд ХАА-н бүтээгдэхүүний экспорт-импортыг дэмжих заалтыг тусгасан. Хятадад нийлүүлэх махны экспортыг 2020 оны 6 дугаар сарын 1-ээс сэргээж, 2020 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 17.7 мянган тонн адууны мах экспортлоод байна.</li> <li>- Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааны бэлтгэл ажлыг хангах, айлын талтай холбогдох мэдээлэл солилцох, хэлэлцээнд баримтлах боломжит байр суурийн талаар санал боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, баримтлах удирдамжийг батлан, Евразийн эдийн засгийн комиссын Зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны Ажлын хэсэг байгуулахыг дэмжсэн шийдвэрийг гаргаж, Ажлын хэсгийн анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 10 дугаар сарын 5-ны өдөр цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан.</li> </ul>	
<b>Зорилт 20. Энхийг сахиулах ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, барилгын засвар төслийг үргэлжлүүлнэ.</b>							
20.1	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГҮАХ-ийн 5.5.2 дахь заалт	Зэвсэгт хүчний хээрийн хөдөлгөөнт холбооны зангилгааг шинэчлэх, хээрийн удирдлагын	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана.	70

		байруудад сансрын холбооны бага оврын станцуудыг суурилуулах					
20.2	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГҮАХ-ийн 5.5.2 дахь заалт	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудыг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	70.0	0.14 Бусад эх үүсвэр	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана.	100
20.3	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГҮАХ-ийн 5.5.5 дахь заалт	НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	1.9 Зэвсэгт хүчний хөгжлийн сан /ЗХХС/	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана.	100
0.4	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГҮАХ-ийн 5.5.6 дахь заалт	"Барилгын засвар" төслийг хэрэгжүүлж Зэвсэгт хүчний анги, салбаруудын зарим барилга байгууламжийн тохижилт, их засварын ажлыг гүйцэтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	5.8 Улын төсөв 1.8 ЗХХС	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.3 дахь хэсэгт хамаарах тул нууцаар тайлагнана.	100

—ooOoo—

